ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Утас/Факс: (976) 7011 2857,
E-mail: nctmmgl@gmail.com

2024.05.27 № 184

танай 2024.05.13-ны № 9/2025-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
С.ТӨГСДЭЛГЭР ТАНАА

Тус төвийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийн тайлан болон холбогдох баримт бичгийг хүргүүлж байна.

ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР

1300030038

**ТӨВИЙН 2023-2026 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙГДСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр.

**Үнэлгээний зорилго**

Төвийн 2023-2026 оны Стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хүрсэн түвшинг тогтоох, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.

**Үнэлгээний арга зүй**.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам батлах тухай” 216 дугаар тогтоол , Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачилал заавар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ий А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх нийтлэг журмыг тус тус үндэслэн Төвийн 2023-2026 оны Стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

**Хяналт-шинжилгээ**

Төв нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам батлах тухай” 216 дугаар тогтоол, мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдал, орчны шинжилгээ, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн болон үйл ажиллагааны зорилтууд тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, хяналт үнэлгээ гэсэн арга зүйн дарааллын дагуу боловсруулж Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Стратеги төлөвлөгөөнд Ерөнхий 4 чиг үүрэг, 22 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2023 онд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

**Төвийн стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээг хүснэгтээр харуулав.**

Хүснэгт 1. Стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийн үнэлгээний дүн

| № | Байгууллага | Зорилтын тоо | 2023 онд Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үнэлгээ | | | | | | Дундаж хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0.0 | |
| 1. | ЦССҮТ-ийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөө | 22 | 63 | 38 | 17 | 2 | - | 6 | - | 89,7% |

Хүснэгт 2. Хэрэгжилт сул, 70%-иас доош үнэлгээтэй арга хэмжээ

| **№** | **Заалтын дугаар** | **Хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжилтийн хувь** | **2023 оны хүрэх түвшин** | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| **Зорилт 1.1.4. Цус цуглуулах төвийн тоог нэмэгдүүлж, цус тээвэрлэх үйл ажиллагаанд технологийн шинэчлэл хийнэ**. | | | | |
| 1. | 9 | Цус цуглуулах суурин төвийн тоог нэмэгдүүлэх-30% | Төсөв, орон тоо шийдэгдсэн үед Цус цуглуулах суурин төвийг шинээр байгуулан ажилласан байна. | Байгууллагын 2024 оны төсвийн төсөлд суурин төвийн тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай 6 орон тооны цалин хөлс, тоног төхөөрөмжийн нэмэгдлийг төсөвт тусгах саналыг хүргүүлсэн. Суурин төв байгуулах төсөл боловсруулсан. |
| 2. | 10 | Сийвэн цуглуулах Аферезийн төв байгуулах-30% | Судалгаа, төслийг боловсруулж, төсөвт суулгах саналыг хүргүүлнэ | Сийвэн цуглуулах Аферезийн төв байгуулах төсөл боловсруулж, төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. |
| 3. | 11 | Цус цуглуулах, тээвэрлэх зориулалтын автомашин үйл ажиллагаанд нэвтрүүлэх-30% г | Цус цуглуулах, тээвэрлэх зориулалтын автомашин шийдвэрлэгдсэн тохиолдолд үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. | Байгууллагын 2024 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд цус цуглуулах, тээвэрлэх зориулалтын автомашин худалдан авах саналыг тусган хүргүүлсэн. Мөн МУЗН-нд санал хүргүүлсэн. |
| **Зорилт 1.2.1. Цахим мэдээллийн сан бүрдүүлж, аюулгүй байдлыг хангана**. | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | 17 | Хүндэт доноруудад үзүүлсэн нийгмийн халамжтай холбоотой мэдээллийн санг баяжуулах-30% | Эрх бүхий байгууллагатай хамтран хүндэт донорын нийгмийн халамж үйлчилгээ хүртэх үйл ажиллагааг хялбаршуулсан байна. | Хүндэт доноруудад олгох нийгмийн халамж үйлчилгээний тодорхойлолтыг цахимжуулах ажил ЭМХТ, ХНХЯ-тай хамтран хийгдэх төлөвлөлтүүд хийгдэж байна |
| **Зорилт 1.4.1. Технологи шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 100%-д хүргэнэ.** | | | | |
| 5. | | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэгчийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ-70% | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 490 нэгжийг үйлдвэрлэж эмнэлэгт олгосон байна. | 2023 онд эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 166 нэгжийг үйлдвэрлэж, эмнэлэгт олгосон. Энэ бүтээгдэхүүгийг үйлдвэрлэхэд шаардагдах урвалж, эм эмнэлгийн хэрэгсэл нь өндөр өртөгтэй байдаг бөгөөд төсөв нэмэгдэхгүй байгаатай холбоотой зорилтот түшинд хүрээгүй байна. |
| **Зорилт 1.4.2. Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, олголтод технологийн шинэчлэл хийнэ.** | | | | |
| 6. | 24. | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бүрэн автоматжуулах бэлтгэл ажлыг хангана.-30% | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бүрэн автоматжуулах техник, технологийн судалгаа, төсвийг хийж төсөвт суулгах санал өгсөн байна | 2024 оны төсвийн төсөлд суулгуулахаар санал өгсөн боловч шийдвэрлэгдээгүй байна |
| **Зорилт 2.1.1. Цусны сонор сэрэмжийн тогтолцооны бүртгэл мэдээллийг баяжуулж, дэмжлэгт хяналт үнэлгээ, мэргэжил арга зүйгээр хангана.** | | | | |
| 7. | 30 | Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх журмыг шинэчлэн батлуулах-70% | Тушаал шинэчлэх санал, тушаалын төслийг шинэчлэн боловсруулж ЭМЯ-д хүргүүлсэн байна | Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал гарч, ажлын хэсгийн хурлыг 2 удаа хийж, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэсэн тушаалын төсөл, танилцуулга, саналын товъёог зэргийг нэгтгэж байна. |
| **Зорилт 4.1.4. Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног, төхөөрөмжийн шалгалт тохируулга баталгаажилтыг тогтмол хийлгэнэ.** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | 64 | Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийх-30% | Жил бүрийн төсөвт шаардлагатай эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн төсвийг тусган шийдвэрлүүлж, тоног төхөөрөмж ийн шинэчлэлийг үе шаттай хийсэн байна. | Ашиглалтын хугацаа дууссан, эвдрэл гэмтэлтэй эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийг жил бүр төсөвт тусгадаг боловч шийдвэрлэгдэхгүй байна. |

**Дүгнэлт.**

1. Төвийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу боловсруулж ЭМЯ, төрийн захиргааны удирдлагын газраас аргазүйн зөвлөгөө авч, бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж хугацаанд нь батлуулж, хэрэгжүүлж ажилласан;
2. Төвийн стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтэд үнэлгээ хийхэд 100% биелэлттэй 38 ажил, 90%-ийн биелэлттэй 17 ажил, 70% биелэлтэй 2 ажил, 30%-ийн биелэлттэй 6 ажил байна.
3. Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Төвийн стратеги төлөвлөгөөний 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлт 89.7%-тай байна.
4. 30%, болон 70%-ийн биелэлттэй ажлууд зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай төсөв шийдэгдээгүйтэй холбоотой байна.

**Цаашид авах арга хэмжээ**.

1. Төвийн стратеги төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийн биелэлтэд хийсэн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, танилцуулгыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан зөвлөмж шийдвэрийг хэрэгжүүлэх;
2. Тус төв нь улсын төсвийн санхүүжилтээр санхүүждэг бөгөөд Эрүүл мэндийн сайдаар батлуулсан Төвийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төсвийн төслөө /эм эмнэлгийн хэрэгслийн төсөв, орон тоо, цалингийн сан/ хүргүүлдэг боловч шийдэгдэхгүй байгаагаас зарим арга хэмжээ дутуу биелэлттэй байна. Иймд стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан төсвийн төслийг дэмжин батлуулах саналтай байна;
3. Цус цусан бүтээгдэхүүний нөөц, аюулгүй байдлыг хангах хүрээнд 2016 он хүртэл хэрэгжсэн төслүүдийн үр дүнд эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн шинэчлэлүүд хийгдсэн боловч 2023 оны байдлаар тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дуусч шинэчлэх шаардлагууд үүсээд байгаа тул 2025 оны төсвийн төсөл, 2026 оны төсвийн төсөөлөлд дахин санал явуулах.

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ЦЧАБА-НЫ ДАРГА Э.ТУНГАЛАГТУЯА

**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН**
**2023-2026 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
**(2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР)**

**2024.05.14**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2023 оны Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 1. Цус цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийн тасралтгүй байдлыг хангах | | | | | | | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1.1. Цусны донор элсүүлэх, цус цуглуулах | | | | | | | |
| **Зорилт 1.1.1.** Цусны донорын сургалт сурталчилгааг өргөжүүлж донор элсүүлэлтийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 1. | Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх | | Цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулалтын тоо | 2022 онд ЦССҮТ-ийн хэмжээнд 27000 донороос цус, сийвэн, эс цуглуулахаар төлөвлөсөн. Тайлант онд нийт 90494 нэгж ЦЦБ-ийг үйлдвэрлэсэн. | 30000 донороос цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулж, 93630 нэгжээс багагүй ЦЦБ үйлдвэрлэж эмнэлгүүдийн захиалгыг 100% хангасан байна. | 2023 онд **32956** донороос цус цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулсан бөгөөд цус цуглуулалтын 60%-ийг суурин хэлбэрээр, 40%-ийг явуулын хэлбэрээр цуглуулсан байна.<br>Нийт **93600** нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагуудын захиалгыг **100%** хангаж ажилласан. | 100% |
| 2. | Сайн дурын идэвхтэн, бэлтгэх сургалт зохион байгуулах | 25.0 Улсын төсөв МУЗН-ийн санхүүжилт | Сайн дурын идэвхтэн бэлтгэх сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | 2022 онд МУЗН-тэй хамтран 5 удаагийн сургалтаар 242 хүн хамруулж, үүнээс 112 сайн дурын идэвхтэн бэлтгэж гэрчилгээ олгосон. | Сайн дурын идэвхтэн, бэлтгэх, чадавхжуулах сургалт зохион байгуулж, чадавхжуулсан сайн дурын ажилтны тоо суурь үзүүлэлтээс буураагүй байна. | 2023 онд Сайн дурын идэвхтэн, бэлтгэх, чадавхжуулах, цусны донорын сургалт, сурталчилгаа явуулах төлөвлөгөө боловсруулан бүрэн хэрэгжүүлж ажилласан. Үүнд:<br>- 2023 оны 03 сарын 15-ны өдөр “Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэхэд сайн дурын идэвхтнүүдийг чадавхжуулах нь” сэдэвт сургалтад Баянзүрх дүүргийн 16-р ЕБС-ийн Өсвөрийн Улаан загалмайн бүлгэмийн ахлагч 20 сурагч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 2023.03.28-ны өдөр Монголын донорын холбооны идэвхтэн сайн дурын гишүүдэд “Сайн дурын цусны донор сурталчлагч гишүүдийг чадавхжуулах “сургалтад зохион байгуулж нийт 20 ахмад донор;<br>- 2023 оны 11 сарын 28, 29-ний өдрүүдэд Эрүүл мэндийн яам, Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран “Донор элсүүлэгч, сурталчлагч багш" бэлтгэх онол, дадлага хосолсон 2 өдрийн сургалтад нийт 160 сайн дурын идэвхтэн, МУЗН-ийн цусны донорын арга зүйч, Өсвөрийн улаан загалмай, Залуучуудын улаан загалмайн гишүүд их дээд сургуулийн эмч, нийгмийн ажилтнууд хамрагдаж 150 сайн дурын ажилтаныг чадвахжуулж, сургагч багш 10 шинээр бэлтгэгдсэн. **Нийт 190 сайн дурын ажилтаныг чадвахжуулах сургалтад хамруулж, 10 сургагч багш шинээр бэлтгэсэн** байна. | |
| 3. | Хүн амд зориулсан амьдралын зөв дадал хэвшлийн талаар мэдээ мэдээлэл хүргэх | | Шинээр бүтээсэн контентийн тоо<br>Олон нийтэд хүргэсэн сургалт, сурталчилгаа, мэдээллийн тоо | 2022 онд шинээр 10 контент бүтээж сургалт сурталчилгаанд ашигласан.<br>Цахим орчинд 240 гаруй мэдээлэл байршуулж мэдээлэл хүргэсэн. | Шинээр контент бүтээх буюу ЭМЯ, НЭМҮТ зэрэг бусад эх үүсвэр тодорхой баталгаажсан мэдээллийг цахим орчинд байршуулж ард иргэдэд хүргэсэн байна. | Хүн амд зориулсан амьдралын зөв дадал хэвшлийн талаарх сургалт мэдээллийг тогтмол хийсэн бөгөөд ЭМЯ, НЭМҮТ-өөс гаргасан В гепатит, Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, Халтиргаа гулгаанаас сэргийлэх, Сэтгэцийн эрүүл мэндийн заавар зөвлөмжүүдийг тогтмол хүргэж хэвшсэн.<br>**2023 онд 10 нэр төрлийн нугалбар, постер контентийг цахим, танхим, самбараар 112 удаагийн давтамжтай мэдээлэл түгээсэн.**<br>Танхимаар:<br>-БИУГ, ТЗТК, БЗД-ийн ЗДТГ, ИТХ, ЦЕГ харьяа ЭЦГ, Баянзүрх цус цуглуулах төвийн амьдралын зөв дадлын талаар 1200 хүнд сургалт мэдээлэл хийсэн.<br>-ЦССҮТ дээр Этүгэн анагаах ухааны их сургуулийн Булган багштай 5, 4 курсийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 97 оюутанд 5 удаа цусны донорын талаар мөн эрүүл жин, амьдралын зөв дадал, халдварт болон халдварт бус өвчлөлөөс мэргийлэх талаар мэдээлэл хийсэн.<br>-Баянзүрх дүүргийн 16 ЕБС-ийн Өсвөрийн Улаан загалмайн бүлгэмийн 25 ахлагч хүүхдүүдэд дэлгэцийн дондолтоос сэргийлэх, эрүүл хоололтын талаар 2 цагийн сургалт хийсэн.<br>-БХГ ажилтан албан хаагчдад “Сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах энгийн арга” сэвдээр нийт 56 хүнд сургалт хийсэн.<br>-МУЗН-ийн Анхны сургалтын төвд 160 хүнд “Амьдралын зөв дадал, томуу, томуу төст өвчлөлөөс сэргийлэх талаар мэдээлэл өгсөн.<br>- “Энэ жилдээ- эрүүл жиндээ” аяны хүрээнд нийт ажиллагсдад эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлах, эрүүл хоололт, эрүүл зан үйлийг хэвшүүлэхэд чиглэж Амос ТББ-тай хамтран үе шаттайгаар сургалт зохин байгуулж нийт 62 хүн хамрагдсан. -Анхны тусламжийн сургалтыг ажиллагсадын дунд зохион байгуулж эцэг, эхчүүдэд хүүхдээ асран сувилах, осол гэмтэл, осголт, хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх арга барил эзэмшүүлсэн. Нийт 65 ажилтан хамрагдсан. | |
| **Зорилт 1.1.2.** Цусны донор алдаршуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнг сайжруулна. | | | | | | | |
| 4. | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэнэ. | 7.4<br>Улсын төсөв Төрийн болон ТББ | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэсэн тайлан. | 2022 оны 1 дүгээр сарын 3-нд Цусны донорын үндэсний өдрийг зохион байгуулж | Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэж, цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчлан, тэднийг | Цусны донорын Үндэсний өдөр тэмдэглэх удирдамж, төсөв ерөнхий захирлын 2022 оны А/20 тушаалаар батлаж хөтөлбөрийн дагуу арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний гол зорилгын хүрээнд Алтан донор 1, Мөнгөн донор 1, Хүрэл донор 1, хамгийн олон удаа цус, цусны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | донор алдаршуулсан. | алдаршуулсан байна. | бүрэлдэхүүн хэсгээ өгсөн 2 донор, Бахархал 10, 20, 30, 40, 50 тэмдгээр тус бүр 1 нийт 10 донорыг шагнаж алдаршуулсан. 2022 оны Цусны донор хамт олон"-оор Ахлагчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хамт олон, Зэвсэгт хүчний 326-р анги, Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль, "Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч байгууллага"-аар "Сүү" ХК, Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо" Тэргүүний "Донор элсүүлэгч байгууллага"-аар СХД-ийн УЗХ-г шалгаруулж хамт олон, ард иргэдэд адаршуулав. МУЗН-ийн "Энэрэнгүй үйлстэн" одонгоор 1, "Нигүүлсэл" мөнгөн медалиар 2, "Шилдэг залуу Алтан медалиар 1 донор, донорын үйлсийг дэмждэг иргэнийг шагнаж байнгын донорт онооны урамшууллыг нь олгосон. Сошиал орчинд болон хэвлэл мэдээллийн байгууллагаар арга хэмжээний мэдээлэл, ярилцлага, мэдээг түгээсэн. | |
| 5. | "Цусны донорын Дэлхийн өдөр"-ийг зохион байгуулна. | 15.0 Улсын төсөв ДЭМБ-ын санхүүжилт | Цусны донорын Дэлхийн өдрийг зохион байгуулсан тайлан. | 2022 оны 6 сарын 14-нд Цусны донорын Дэлхийн өдрийг танхимаар зохион байгуулсан. | ДЭМБ-ын 2023 оны удирдамжийг олон нийтэд сурталчилж, Цусны донорын Дэлхийн өдрийг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлсэн байна. | 2023 оны "Цусны донорын Дэлхийн өдөр" -ийн 20 дэх удаагаа "**Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ өгч, амьдрал бэлэглэе**" уриа, **Донор та амь тэтгэгч** сэдвийн дор Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Арга хэмжээнд Эрүүл мэндийн дэд сайд, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгч нар, МУЗН, МДХ-ны хүндэт зочид, бусад байгууллага, хүндэт донорууд, улаан загалмайчид, ОУ-ын байгууллагын төлөөлөл оролцсон. Уламжлалын дугуу шилдэг тэргүүний байгууллага, цусны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | донор, хүмүүнлэгийн ажилтаныг төвийн болон МУЗН, хандивлагчийн шагналаар шагнаж алдаршуулсан. Шинээр хүндэт донорын болзол хангасан нийслэлийн 65 цусны донорт үнэмлэх тэмдгийг олгов. 19 хэвлэл мэдээллийн байгууллага сайт мэдээ, шууд ярилцлага хийсэн. ДЭМБ-ын санхүүжилтээр цусны донорын сурталчилгааны материал хэвлүүлж, цусны бүлгийн талаар шторк бэлтгэн сургалт, сурталчилгаанд ашиглаж байна. Энэ үеэр Нээлттэй хаалганы өдөр болж ЦЦБ, цусны донорын талаарх сурталчилгаа, анхны тусламжийн мэдээллийг 300 гаруй иргэнд хүргэсэн байна. | |
| 6. | “Цусаа бэлэглэх өдөр”-ийг 2-12 дугаар саруудад зохион байгуулна. | 24.0 Улсын төсөв Эрүүл мэндийг дэмжих сан Төрийн болон ТББ | Цусаа бэлэглэх өдөр тэмдэглэсэн тайлан. | 2022 онд Цусаа бэлэглэх өдрийг 11 удаа зохион байгуулж цусны донор, донор хамт олныг шагнаж алдаршуулсан. | “Цусаа бэлэглэх өдөр”-ийн арга хэмжээг 11 удаа зохион байгуулж цусны донор, донор хамт олон, донорын үйлсийг дэмжигч байгууллагуудыг шагнаж алдаршуулсан байна. | Сар бүрийн 3 “Цусаа бэлэглэх өдөр”-ийн арга хэмжээг 11 удаа зохион байгуулж цусны байнгын донор, донор хамт олон, донорын үйлсийг дэмжигч байгууллагуудыг шагнаж алдаршуулсан. Үүнд:<br>1.Алтан донор 1<br>2.Мөнгөн донор 9<br>3.Хүрэл донор 36<br>4.Бахархал 50 тэмдгээр 10<br>5.Бахархал 40 тэмдэгээр 4<br>6.Бахархал 30 тэмдгээр 13<br>7.Бахархал 20 тэмдгээр 21<br>8.Бахархал 10 тэмдгээр 23<br>нийт 117 донорыг тус тус шагнаж алдаршуулсан. Үйл ажиллагааг Сэтгэлийн 1000 үйлс ТББ, БЗД ИТХ, ЗДТГ, УЗДШХ, Барилгын хөгжлийн төв, МУЗН, УСУГ, Үнэртэй усанд дурлагсдын клуб, Улаанбаатар Смарт карт ХХК, МДХ, Сайн дурынхан хамтран зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж, ULKER Mongolia, TMB XXK брэнд МУЗН, Наран Бьюти ворлд, МДХ, МУЗН ХЗХГ, нар дэмжиж гарын бэлэгээ гардуулжээ. Сар бүрийн 3-ны өдрөөр үйлчлүүлэгчийн ЭМ-ийн боловсролыг дээшлүүлэх сургалт 2 удаа, “Хувь хүний хөгжил”-эрүүл ажлын байр” сэвдээр 1 удаа сургалт зохион байгуулсан байна. Цусны донорын тухай ерөнхий ойлголтыг танхимаар 2200 гаруй хүнд хүргэсэн. Нийт давхардсан тоогоор 60 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж донорын үйлсийн талаар мэдээлэл-50 ярилцлага -19, сурвалжлага, нийтлэл-15 удаа явуулж сурталчилгаа мэдээлэл хийсэн. | |
| 7. | Хүндэт donoruudad Засгийн газрын болон төрийн шагнал олгох эрх зүйн зохицуулалт бий болгоно. | | Засгийн газрын болон төрийн шагнал олгосон донорын тоо | Шударга журам медалиар 4 хүндэт донорыг шагнуулсан. Хүндэт донор тэмдгийг Засгийн газрын шагнал болгох саналыг Донорын тухай хуулийн төсөлд тусгасан. | Эрх зүйн зохицуулалтыг бий болгож, жил бүр болзол хангасан цусны “Хүндэт донор”-ыг Засгийн газрын болон Төрийн шагналд тодорхойлж, дэмжиж ажилласан байна. | 2023 онд Ерөнхийлөгчийн зарлиг гарч 9 хүндэт донорыг **Шударга журам** медалиар шагнасан. | 100% |
| **Зорилт 1.1.3**. Цусны донорын эрүүл мэндэд учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг, шинжилгээ хийнэ. | | | | | | | |
| 8. | Цусаа өгөхөөр ирсэн хүн бүрт эрүүл мэндэд учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг тогтмол хийх | 57.3 Улсын төсөв | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хүний too | Цусаа өгөхөөр ирсэн хүн бүрт учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг тогтмол хийж байна. | Цусаа өгөхөөр ирсэн хүн бүрт учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг тогтмол хийж, сөрөг хариу урвалаас сэргийлж ажилласан байна. | 2023 онд цусаа өгөхөөр ирсэн 33599 доноруудад эрүүл мэндийн асуумж үзлэг хийснээс асуумж үзлэгээр 1885 хасагдаж, нийт үзлэгийн 5.6%-ийг эзлэж байна. Үүнээс түр хойшлох шалгуур үзүүлэлтээр 1753(5,2%), бүр хасагдах шалгуур үзүүлэлтээр 132(0.4%), донор хойшлогдсон байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад асуумж үзлэгээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хасагдалт 4%-иар буурсан үзүүлэлттэй байна.<br>Цусны донорын эрүүл мэндийг хянах, сөрөг хариу урвалаас сэргийлэх зорилгоор тогтмол хугацаанд цусаа өгсөн 1012 донорт ферритин тодорхойлох шинжилгээ хийсэн. Шинжилгээнд хамрагдсан доноруудын 75%-нд ферритиний хэмжээ хэвийн, 4%-д нь ихэссэн, 21%-д нь багассан үзүүлэлттэй байна. Хэвийн хэмжээнээс багассан доноруудад ДЭМБ-ын зөвлөмж болон олон улсад хэрэгжүүлж буй заавар зөвлөмжийг үндэслэн 6-12 сарын хугацаанд цусаа өгөх хугацааг түр хойшлуулах арга хэмжээ авч ажиллаж байгаа бөгөөд Энэхүү арга хэмжээний үр дүнд түр хойшлогдоод дахин цусаа өгөхөөр ирсэн доноруудын 81%-д нь ферритиний хэмжээ хэвийн болсон үр дүнтэй үзүүлэлттэй байна. Мөн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донор бүрт цус өгсний дараах зөвлөмжийг цаасан болон аман хэлбэрээр тогтмол өгч хэвшсэн бөгөөд 2023 онд 32956 донорт зөвлөмжийг өгсөн байна.<br>Цусны донорт илрэх сөрөг хариу урвалаас сэргийлэх зорилгоор 92 удаагийн явуулын цус цуглуулалтад зориулалтын орыг хэрэглэж 6968 донороос цус цуглуулсан бөгөөд энэ нь нийт явуулаар цус цуглуулалтын 55,5%-ийг эзэлж байна.<br>Донорт илрэх сөрөг урвалаас сэргийлэх арга хэмжээг олон талт хэлбэрээр зохион байгуулсны үр дүнд өмнөх оноос 16%-иар буурсан үзүүлэлттэй байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.1.4.** Цус цуглуулах төвийн тоог нэмэгдүүлж, цус тээвэрлэх үйл ажиллагаанд технологийн шинэчлэл хийнэ. | | | | | | | |
| 9. | Цус цуглуулах суурин төвийн тоог нэмэгдүүлэх | | Шинээр байгуулсан суурин төвийн тоо | УБ хотод 3 суурин төвөөр цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулдаг. | Төсөв, орон тоо шийдэгдсэн үед Цус цуглуулах суурин төвийг шинээр байгуулан ажилласан байна. | Байгууллагын 2024 оны төсвийн төсөлд суурин төвийн тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай 6 орон тооны цалин хөлс, тоног төхөөрөмжийн нэмэгдлийг төсөвт тусгах саналыг хүргүүлсэн. Суурин төв байгуулах төсөл боловсруулсан. | 30% |
| 10. | Сийвэн цуглуулах Аферезийн төв байгуулах | | Сийвэн цуглуулах төв | - | Судалгаа, төслийг боловсруулж, төсөвт суулгах саналыг хүргүүлнэ. | Сийвэн цуглуулах Аферезийн төв байгуулах төсөл боловсруулж, төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч шийдэгдээгүй болно. | 30% |
| 11. | Цус цуглуулах, тээвэрлэх зориулалтын автомашин үйл ажиллагаанд нэвтрүүлэх | | Зориулалтын автомашин | Цус цуглуулах зориулалтын автомашины төслийг боловсруулж ЭМЯ, МУЗН, ОУ-ын байгууллагад хүргүүлсэн. | Цус цуглуулах, тээвэрлэх зориулалтын автомашин шийдвэрлэгдсэн тохиолдолд үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. | Байгууллагын 2024 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд цус цуглуулах, тээвэрлэх зориулалтын автомашин худалдан авах саналыг тусган хүргүүлсэн. МУЗН-нд санал хүргүүлсэн. | 30% |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1.2. Цахим мэдээллийн сан бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах | | | | | | | |
| **Зорилт 1.2.1.** Цахим мэдээллийн сан бүрдүүлж, аюулгүй байдлыг хангана. | | | | | | | |
| 12. | Кибер аюулгүй байдлын тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах | | Хэрэгжүүлсэн ажлын тайлан | 2020 онд төвийн үндсэн үйл ажиллагааны программ, ЦССҮТ-ийн мэдээллийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн. | Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамрагдаж, онц чухал мэдээллийн дэд бүтцэд хамрагдсан байгууллагад тавигдах шаардлагыг хангасан байна. | Тус төв нь 2019 онд байгууллагын нууц хадгалах 1 ажилтныг Тагнуулын байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамруулан төвийн захирлын Б/12 тоот тушаалаар томилон одоог хүртэл ажиллуулж байна.<br>Төвийн ажиллагсад болон харьяа байгууллагын хэмжээнд Төрийн болон албаны нууцын тухай хууль, ЗГ-ын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/279 дугаар тушаалаар батлагдсан “Албаны нууцын жагсаалт”-ыг төвийн цахим хуудсанд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байрлуулан танилцуулсан. Мөн учирч болох эрсдэлээс сэргийлэх зорилгоор үндсэн үйл ажиллагааны программд нэвтрэх бүрд санамж, хууль, тогтоомжтой танилцах холбоосыг байршуулсан.<br>Төвийн ажилчдын ирцийг QR code ашиглан ERP систем, E-Chat-аар бүртгэж, албан ёсны лицензтэй Norton security анти-вирусийн программыг сүлжээнд холбогдсон компьютер бүрд суулгасан.<br>Төвийн үндсэн үйл ажиллагааны программд хандаж буй хэрэглэгчдийн нууц үгийг стандартын дагуу 8-аас доошгүй том жижиг үсэг, тоо, тусгай тэмдэгт ашиглан шинэчилсэн ба өгөгдлийн санд хандаж буй 52 ажиллагсдаас нууцын баталгаа гаргуулж авсан.<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглаж байгаа сервер компьютер, сүлжээний төхөөрөмж шинэчлээгүй, гадаад улсын зээл, тусламж, хөрөнгө оруулалт хэрэгжиж буй мэдээллийн технологийн төсөл хөтөлбөр, шинээр нэвтрүүлсэн программ хангамж байхгүй байна. | |
| 13. | Үндсэн үйл ажиллагааны программ хөгжүүлэн, цусны донор үйлчлүүлэгчдийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх | 10.0<br>Улсын төсөв | Программд хөгжүүлэлт хийсэн баримтжуулалт | 2021 онд тасаг нэгжүүдээс программд орох өөрчлөлт, шинэчлэлийн саналыг авч хөгжүүлэлт хийсэн. | Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр программ хангамжийг хөгжүүлэх санал боловсруулж, цусны донор үйлчлүүлэгчийн мэдээллийн нэгдсэн | Тус төвийн лавлагаа лаборатори улсын хэмжээнд зохион байгуулдаг Иммуногематологийн үндэсний чанарын гадаад үнэлгээнд ашиглах qt.bloodcenter.mn цахим программыг хөгжүүлж Нэгдсэн лабораторийн үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлсэн. Уг программ нь Иммуногематологийн үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөр зарлагдах хугацааг урдаас | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санг баяжуулан ажилласан байна. | оролцогчдод email хаяг болон бүртгэлтэй утасны дугааруудад мэдэгдэх, оролцогч байгууллагууд төлбөрөө төлж баталгаажуулнаар цахим программд үнэлгээнд оролцох эрх нээгдэх, шинжилгээний хариу оруулах, үрд дүнг бодож хариуг гарган, гэрчилгээг автоматаар илгээдэг цахим платформ юм. Энэхүү платформыг нэвтрүүлснээр ажиллагсдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн, хүнээс шалтгаалах алдаа эрсдлээс сэргийлэх, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргах гэх мэт олон давуу талуудыг бий болгосон.<br>Ашигласан технологиуд:<br>UX: Miro<br>UI: Figma<br>Back-end: Node.js<br>Front-end: React.js<br>дээр тус тус хийгдсэн. | |
| 14. | Иргэд цусны бүлгийн мэдээллээ “e-Mongolia” нэгдсэн системээс харах боломжийг олгоно. | | Бүлгийн мэдээллээ авсан донор, үйлчлүүлэгч-ийн тоо | 2022 онд “e-Mongolia” нэгдсэн системээр нийт бүртгэлтэй цусны донор, үйлчлүүлэгчид цусны бүлгийн мэдээллээ хардаг болсон. | Үндсэн үйл ажиллагааны программын аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангаж, “e-Mongolia” нэгдсэн системээр цусны донор, үйлчлүүлэгчдийн цусны бүлгийн мэдээллийг тогтмол харах нөхцлийг бүрдүүлж ажилласан байна. | 2022 онд 76778 донор үйлчлүүлэгч “e-Mongolia” нэгдсэн системд хандаж мэдээллээ харж байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 87330 цусны донор, үйлчлүүлэгч цусны бүлгийн мэдээллээ авсан байна. Энэ нь өмнөх оноос 10552 буюу 14 хувиар өссөн үзүүлэлттэй юм. | 90% |
| 15. | “Цусны донор” аппликейшнд хөгжүүлэлт хийнэ. | 8.0<br>Улсын төсөв | Аппликейшн тогтмол | 2022 онд МУЗН-тэй хамтран андройд болон | “Цусны донор” аппликейшнд хөгжүүлэлт | МУЗН-ийн санхүүжилтээр “Цусны донор” аппликейшнийг шинээр хөгжүүлсэн. Энэхүү аппликейшнийг ашигласнаар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ашигладаг донорын хувь | IOS үйлдлийн системд ажилладаг “Цусны донор” аппликейшныг шинээр ашиглалтад оруулсан. | хийгдэж, ашиглалт нэмэгдсэн байна. | цусны донор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлж байнгын донорын тоог нэмэгдүүлэх боломжыг бүрдүүлсэн. Уг аппликейшнийг ашигласнаар цусны донорын дараагийн цус өгөх хугацаа, цусны бүлэг, нийт цус өгөлтийн тоо, цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээний хариу, явуулын хэлбэрээр цус цуглуулах байршил, цаг хугацаа зэргийг харах боломжийг бүрдүүлсэн. Энэ онд 2 удаа дээрх харагдах хэсгүүд, загвар дизайнд өөрчлөлт оруулсан ба ашиглалтын явцад гарсан алдаануудыг засварлах байдлаар хөгжүүлэлт хийсэн. 2023 онд “Цусны донор” аппликейшнаас давхардсан тоогоор 11465 цусны донор үйлчилгээ, мэдээлэл авсан байна. | |
| 16. | Төвийн засвар үйлчилгээ удирдлагын системийн мэдээллийн сан бүрдүүлэх | | Мэдээллийн санд оруулсан өөрчлөлтийн тоо | Хөрөнгийн хөдөлгөөнийг хийж Санхүүгийн программын хөрөнгийн бүртгэлтэй засвар үйлчилгээ удирдлагын системийн мэдээллийн сан нийлүүлсэн байна. | Санхүүгийн программтай уялдуулан, хөрөнгийн хөдөлгөөнийг засвар үйлчилгээ удирдлагын системийн мэдээллийн сан баяжуулан байна. | Засвар үйлчилгээ удирдлага хяналтын системд засварын 18 хүсэлт ирсэнийг хуваарлаж засвар үйлчилгээг хийж хариу арга хэмжээ авч ажилласан.<br>-Хөрөнгийн мэдээллийг шинэчилж эд хариуцагч болон дахин үнэлсэн хөрөнгийг шинэчлэж бүртгэсэн.<br>“Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт Үндэсний семинар дээр цусны салбар төвүүдэд Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, арчилгаа үйлчилгээ, аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулсан. | 90% |
| 17. | Хүндэт доноруудад үзүүлсэн нийгмийн халамжтай холбоотой мэдээллийн сан баяжуулах | | Хэрэгжүүлсэн ажлын тайлан | Хүндэт донорын болзол хангасан иргэдийн нэрсийг холбогдох байгууллагад хүргүүлэн шагнуулах, | Эрх бүхий байгууллагатай хамтран хүндэт донорын нийгмийн халамж үйлчилгээ хүртэх үйл ажиллагааг | Хүндэт доноруудад олгох нийгмийн халамж үйлчилгээний тодорхойлолтыг цахимжуулах ажил ЭМХТ, ХНХЯ-тай хамтран хийгдэх төлөвлөлтүүд хийгдэж байна<br>2023 онд Улсын хэмжээнд 158 донор шинээр хүндэт донорын болзол хангасан. | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрх болон мөнгөн тусламж авах, рашаан сувилалд амрах эрхийн тодорхойлолтыг олгодог. | хялбаршуулсан байна. | Нэрсийг нь МУЗН-д хүргүүлсэн. Донор инфо цахим сүлжээнд Улаанбаатар хотын 52 донорыг Хүндэт донор гэсэн хэсэгт бүртгэн оруулсан.<br>Хүндэт донорууд нийтийн тээврээр хөнгөлттэй үнээр зорчих Смарт карт сунгах-138 үүнээс шинээр олголт-71 ,хуучин дахин олголт-67 байна.<br>Сувилалд 100 хувь үнэ төлбөргүй амрах тодорхойлолт- 240 хүнд олгосон. | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1.3. Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, шинжилгээ хийх | | | | | | | |
| **Зорилт 1.3.1. Л**абораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 18. | Лабораторийн шинжилгээзний Олон улсын чанарын гадаад үнэлгээнд хамрагдаж, шинжилгээний чанарыг ханган ажиллана. | 16.0<br>Улсын төсөв | Чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан гэрчилгээ | 2022 онд бүлэгнэлтийн шинжилгээгээр 1 удаа иммуногематологийн чиглэлээр ОУ-ын чанарын гадаад үнэлгээнд 2 удаа хамрагдаж гэрчилгээ авсан. | Молекул биологи, иммунологийн Иммуногематологи, бүлэгнэлтийн чиглэлээр олон улсын чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хамрагдаж гэрчилгээ авсан байна. | Молекул биологи, иммунологийн шинжилгээний гадаад хяналтыг сонгох тендер зарлаж, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулж ажилласан.<br>Иммунологийн шинжилгээгээр: 7 сараас эхлэн сард 1 удаа RIQAS-аас зохион байгуулсан Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт 4 үзүүлэлтээр, 2 аппаратаар 2 сорьцонд нийт 6 удаа амжилттай оролцсон.<br>Молекул биологийн хяналтын сорьцонд шинжилгээг хийж 11 сарын 26-нд хариуг илгээсэн. Үр дүн хүлээгдэж байна.<br>Иммуногематологийн чиглэлээр Австралийн RCQAP-ийн чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт 12 сарын 4-нд хамрагдаж хариуг илгээсэн. Үр дүн хүлээгдэж байна. | 90% |
| 19. | Лабораторийн шинжилгээзний Үндэсний чанарын гадаад үнэлгээнд хамрагдах болон | 380.0<br>Улсын төсөв | Шинжилгээний чиглэл тус бүрээр чанарын гадаад | 2022 онд Гематологи, биохими, бүлэгнэлт, нян судлалын | Гематологи, биохими, бүлэгнэлт чиглэлээр үндэсний чанарын гадаад үнэлгээнд | 2023.05.29-нд MEQAS-аас зохион байгуулсан гематологиийн 30 дах удаагийн үнэлгээнд үнэмлэхүй үнэлгээ 91,66%, биохимиийн 24 дэх удаагийн хяналтанд үнэмлэхүй үнэлгээ 96,66%, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өөр хувилбарт аргыг ашиглан шинжилгээний чанарыг ханган ажиллана. | | үнэлгээнд хамрагдсан дүн | чиглэлээр чанарын гадаад үнэлгээнд тус бүр 1-с дээш удаа хамрагдсан. | хамрагдаж гэрчилгээ авсан байна.<br>Нян судлалын чиглэлээр өөр хувилбарт арга ашиглан шинжилгээний чанарыг ханган ажилласан байна. | цусны бүлэгнэлтийн 4 дэх удаагийн үнэлгээнд харьцангуй үнэлгээ 96,67% тус тус хамрагдаж гэрчилгээ авсан.<br>2023.11.29-д MEQAS-аас зохион байгуулсан гематологиийн 31 дэхь биохимийн 25 дахь, бүлэгнэлтийн 5 дахь удаагийн үнэлгээнд хамрагдаад байна. Үр дүн хүлээгдэж байна.<br>2023 онд УХТЭ-тэй /нян судлалын шинжилгээ/ цусны ариун чанар тодорхойлох шинжилгээгээр лаборатори хоорондын харьцуулалт хийсэн. Үр дүн 100% тохирсон. | |
| 20. | Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээний ФХЭБУ-ын аргаас CLIA аргад шилжих | | Халдвар илрүүлэх шинжилгээнд CLIA аргыг нэвтрүүлсэн хувь | 2022 оны байдлаар Халдвар илрүүлэх шинжилгээний 15%-д CLIA аргыг хэрэглэсэн. | Халдвар илрүүлэх шинжилгээний 30%-д CLIA аргыг хэрэглэсэн байна. | 2023 онд нийт 2840 донорт CLIA аргаар Хепатитийн B, C вирүс, ХДХВ, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээг хийсэн нь нийт шинжилгээний 8,6%-д CLIA аргыг хэрэглэсэн байна.<br>10276 сорьцонд B, C, ХДХВ, Тэмбүүгийн халдварыг тус тусад нь хийсэн нийт сорьцын **31%-ийг** эзэллэж байна. | 100% |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1.4. Цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, олгох | | | | | | | |
| **Зорилт 1.4.1**. Технологи шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 100%-д хүргэнэ. | | | | | | | |
| 21. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэн хөлдөөсөн шинэ сийвэнгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 790.5<br>Улсын төсөв | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | 2022 онд 2541 нэгж эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэн хөлдөөсөн шинэ сийвэн үйлдвэрлэсэн. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэн хөлдөөсөн шинэ сийвэнгийн 2900 нэгжийг үйлдвэрлэж эмнэлэгт олгосон байна. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн бүтээгдэхүүн 3500 нэгж үйлдвэрлэж эмнэлэгт олгосон байна. | 100% |
| 22. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэгчийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | Улсын төсөв | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | 2022 онд 268 нэгж эмгэг төрүүлэгчийг идэвхгүйжүүлэн ялтаст эсийн өтгөрүүлэг үйлдвэрлэсэн. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 490 нэгжийг үйлдвэрлэж эмнэлэгт олгосон байна. | Эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг 166 нэгжийг үйлдвэрлэсэн байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23. | Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 126.3 Улсын төсөв | Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | 2022 онд 3827 нэгж цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. | Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг суурь оны үзүүлэлтээс бууруулаагүй байна. | Цагаан эсгүйжүүлсэн улаан эс 4974 нэгж үйлдвэрлэж өмнөх оны түвшингээс 1147 нэгжээр нэмэгдүүлсэн байна. | 100% |
| **Зорилт1. 4.2.** Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, олголтод технологийн шинэчлэл хийнэ. | | | | | | | |
| 24. | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бүрэн автоматжуулах бэлтгэл ажлыг хангана. | | Нэвтрүүлсэн бүрэн автомат технологи | Гар ажиллагаат битүү систем ашиглаж байна. | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бүрэн автоматжуулах техник, технологийн судалгаа, төсвийг хийж төсөвт суулгах санал өгсөн байна. | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бүрэн автоматжуулах техник, технологийг Төвийн Журнал клубд танилцуулж үнийн саналыг авсан. 2024 оны төсвийн төсөлд суулгуулахаар санал өгсөн болович шийдвэрлэгдээгүй байна | 30% |
| 25. | Гемофилийн эсрэг факторыг хүлээн авах, хуваарилах, түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх | | Амбулаторийн урьдчилан сэргийлэх факторыг захиалгын дагуу авсан хүний тоо, олгосон тун нэгжээр | Гемофили А-тай 85 хүнд 2,866,250 ОУН VIII фактор, гемофили В-тэй 32 хүнд 831,000 ОУН IX факторыг олгосон. | Амбулаторийн урьдчилан сэргийлэх тунгаар VIII, IX факторыг эмчийн жорын дагуу олгосон байна. | Монгол улсад 2023 оны байдлаар цус бүлэгнэлтийн VIII, IX факторын дутагдалтай хэмээн оношлогдсон нийт 170 өвчтөн бүртгэгдсэн байна. Үүнээс: Гемофили А нийт 116 буюу 68% (насанд хүрэгчид 34%, хүүхэд 66%) Гемофили В нийт 48 буюу 28% (насанд хүрэгчид 53%, хүүхэд 47%,) Виллебранд нийт 6 буюу 4% (насанд хүрэгчид 34%, хүүхэд 66%). Эдгээр өвчтнүүдээс Гемофили А-тай 82, Гемофили В-тэй 20, нийт 102 өвчтөн VIII, IX фактор амбулаториор хэрэглэж байна2023 онд нийт VIII-р фактор 89 хүнд 2.785.250 ОУН, IX-р фактор 23 хүнд 314.500 ОУН тус тус олгосон. ДХХ-с ирэх 5 удаагийн хандивын факторын импортын бичиг баримтыг бүрдүүлж ажилласан. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 26. | Яаралтай үед эмнэлгүүдийн цус цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтэд нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглана. | - | Техник технологийн ололтыг ашигласан тээвэрлэсэн ЦЦБ-ний тоо | Red Drone төсөл хэрэгжүүлж нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглан ЦЦБ тээвэрлэх боломж бүрдсэн. | Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, яаралтай тусламжийн үед ЦЦБ тээвэрлэхэд нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашигласан байна. | Яаралтай үед эмнэлгүүдийн цус, цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтэд нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг ашиглах зорилгоор Япон улсын Ньюком групптэй 4 удаагийн уулзалт хийсэн. Уг уулзалтаар нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг Монгол улсад ашиглах хууль эрхзүйг орчинг бүрдүүлэх, Ньюком группийн нисгэгчгүй нисэх AirTruck буюу тусгай ложистикийн дроны туршилтын нийслэг хийх, иргэний нийсхийн газраас туршилтын нислэг хийх зөвшөөрөл авах, цус цусан бүтээгдэхүүнийг төрлөөр нь ангилан тээвэрлэх 2 тасалгаатай савыг хийлгэсэн. 2023 оны 09 дүгээр сарын 28-нд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан ‘Mongolia New Smart Logistics Symposium 2023’-ын үеэр Монгол болон Япон улсын 10 байгууллага (Japan International Cooperation Agency (JICA) Цус сэлбэлт судлалын үндэсний төв, АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг, Ньюком групп Мобиком Корпораци ХХК, Ток Ток ХХК, Aeronext Inc. ACSL Ltd. KDDI SmartDrone Inc. Seino Holdings Co., Ltd) аж ахуйн нэгж санамж бичигт гарын үсэг зурж дрон ашиглан хүргэлт хийх үйлчилгээг Монгол Улсад бий болгох төслийг эхлүүлсэн. Уг төслийн хүрээнд анхны тээвэрлэлтийг 2023 оны 11 сарын 13 өдөр Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг хооронд нийт 4,75км зайд AirTruck буюу тусгай ложистикийн дрон ашиглан цус цусан бүтээгдэхүүн тээвэрлэх нислэг хийсэн. Энэхүү AirTruck тусгай ложистикийн дрон нь 12 нэгж цус цусан бүтээгдэхүүнийг цагт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 36 км хурдтай 12 минутад зорилтод газраа хүргэлт хийсэн. Цаашид хөгжүүлэлт хийн 2024 оны хавраас тогтмол ашиглахаар төлөвлөн ажиллаж байна. Олон эмнэлэг рүү тээвэрлэх боломж бүрдсэн. | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1.5. Улсын нөөцийн тухай хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагчийн агуулахад технологийн горимын дагуу хадгалах | | | | | | | |
| **Зорилт 1.5.1.** Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн ЦЦБ-ий нөөц хангамж, бэлэн байдлыг хангана. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27. | Цус, цусан бүтээгдэхүүний Улсын нөөцийн хадгалалтын аюулгүй байдлыг хангаж, нөхөн сэлгэлтийг хийнэ. | - | ОБЕГ-тай хийгдсэн гэрээ, ажлын тайлан | Гэрээг дүгнэж, улсын нөөцөд бараа, материал худалдан авах нэмэлт гэрээ байгуулсан. | Гэрээний үүргийг хэрэгжүүлж, шаардлагатай бүтээгдэхүүний нөхөн сэлгэлтийг бүрэн хийж, нөөцийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | ОБЕГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газартай 2012 оноос хийсэн (Маш нууц) гэрээг тухай бүр шинэчлэн хэрэгжилтийг ханган ажилласан. 2023 оны ОБЕГ-аас гэрээний хэрэгжилтийг маш сайн гэж дүгнэсэн. 2023 оны 7, 9, 12 дугаар саруудад нөөцийн & нэгж цус цусан бүтээгдэхүүний нөхөн сэлгэлтийг 3 удаа хийж, тооллогоор баримтжуулсан. Гамшгийн нөөц төвийн цус цусан бүтээгдэхүүний хадгалалт, аюулгүй байдлыг хангах зорилгоор нэмэлт камер суурилуулан хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, -30C хүйтэн өрөөний үйл ажиллагааг камериар хянаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 365 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Улсын нөөцийн нэр төрлөөс балансаас баланст шилжүүлэх бараа, материалын жагсаалт”-аас дараах 4 төрлийн 13 ширхэг тоног төхөөрөмжийг балансаас баланст шилжүүлэн авсан. Үүнд:<br>1. Гүн хөлдөөгч 5 ширхэг<br>2. Сейф 1 ширхэг<br>3. Тог баригч 5 ширхэг<br>4. Хөргөгч 2 ширхэг | 100% |
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ **2.** Тусламж үйлчилгээний чанар, цусны аюулгүй байдлыг хангаж, Чанарын болон ХЭМАБ-ын менежментийг тогтвортой хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах | | | | | | | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2.1. Үндэсний хэмжээнд цусны сонор сэрэмжийн тогтолцоог хөгжүүлж, цусны аюулгүй байдалтай холбоотой баримт бичгийг шинэчлэх | | | | | | | |
| **Зорилт 2.1.1.** Цусны сонор сэрэмжийн тогтолцооны бүртгэл мэдээллийг баяжуулж, дэмжлэгт хяналт үнэлгээ, мэргэжил арга зүйгээр хангана. | | | | | | | |
| 28. | ДЭМБ-ын стратегийн зорилтыг хэрэгжүүлж, цус, цусан бүтээгдэхүүний | - | Бүртгэл мэдээлэл, дүн шинжилгээ хийсэн тайлан | 2020-2022 оны ДЭМБ-ын стратегийг мөрдөж, Эрүүл мэндийн байгууллагуудын | Эрүүл мэндийн байгууллагуудын цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн тайланд дүн шинжилгээ хийж | Цусны салбар төвүүд болон цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч гэрээт эрүүл мэндийн байгууллагууд цус сэлбэлттэй холбоотой урвал хүндрэлийн болон цусны донорт илэрсэн сөрөг хариу урвалын тайланг жилийн эцэст ЭМТ-308 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урвал хүндрэлтэй холбоотой бүртгэл мэдээллийг баяжуулж дүн шинжилгээ хийнэ. | | | цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн тайланг нэгтгэсэн. | мэдээллийн сан үүсгэсэн байна. | тайлангийн маягтаар ирүүлдэг. Эрүүл мэндийн сайдын А/506 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Google form ашиглан мэдээний сан үүсгэсэн. Мэдээний санд цусны донорын сөрөг хариу урвал 84, цус сэлбэлттэй холбоотой 5 урвал, хүндрэл бүртгэгдсэн. Бүртгэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийн, ноцтой тохиолдол гарахаас сэргийлж, 11 ЭМБ-ын 886 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд цусны аюулгүй байдлын сургалт зохион байгуулан мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. | |
| 29. | Цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээний заавар шинэчлэн батлуулна. | - | Шинэчлэн батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/03 дугаар тушаалыг мөрдөж ажилладаг. | Тушаал шинэчлэх санал, тушаалын төслийг шинэчлэн боловсруулж ЭМЯ-д хүргүүлсэн байна | “Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар”, Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал гарч, ажлын хэсгийн хурлыг 2 удаа хийж, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэсэн тушаалын төсөл, танилцуулга, саналын товьёог зэргийг нэгтгэн Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт хүргүүлсэн. | 100% |
| 30. | Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх журмыг шинэчлэн батлуулах | - | Шинэчлэн батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/506 дугаар тушаалыг мөрдөж ажилладаг. | Тушаал шинэчлэх санал, тушаалын төслийг шинэчлэн боловсруулж ЭМЯ-д хүргүүлсэн байна | Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал гарч, ажлын хэсгийн хурлыг 2 удаа хийж, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэсэн тушаалын төсөл, танилцуулга, саналын товьёог зэргийг нэгтгэж байна. | 70% |
| 31. | Цусны салбар төвүүд болон | 5.4 Улсын төсөв | Дэмжлэгт хяналт | 2022 онд 2 гэрээт Эрүүл мэндийн | 3-аас цөөнгүй Цусны салбар төв болон | Цусны аюулгүй байдлын дэмжлэгт хяналт үнэлгээ хийх удирдамжийг төвийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад цусны аюулгүй байдлын дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангана. | | үнэлгээний тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | байгууллага, 3 Цусны салбар төвд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан. | эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн байна. | Ерөнхий захирлаар батлуулан Цэргийн төв эмнэлэг, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэг, ЭХЭМҮТ эх барих эмэгтэйчүүдийн эмнэлэгт газар дээр нь, 5 аймгийн цусны салбар төвүүдэд цахимаар хийж, зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдсан. Орон нутгийн Цусны салбар төвийн жилийн үйл ажиллагаа дүгнэх журмыг шинэчлэн боловсруулж, батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу “Шилдэг” цусны салбар төвийг шалгаруулан, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн. | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2.2. Лавлагаа шатны тусламж үйлчилгээг үзүүлж мэргэжил арга зүйгээр хангах | | | | | | | |
| **Зорилт 2.2.1. Л**авлагаа шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн шаардлагад нийцүүлэн өндөр түвшинд үзүүлнэ. | | | | | | | |
| 31. | Цус сэлбэлт судлалын чиглэлээр иммуно-гематологийн лавлагаа шинжилгээг хийх | | Лавлагаа шинжилгээ- ний нэр, төрөл, тоо, тохирлын хувь. | Хувийн тохироо, эргэлзээтэй бүлэг тодорхойлох, кумбсын шууд ба шууд бус урвал, эсрэг бие илрүүлэх, дүйн тодорхойлох, резус сөрөг баталгаажуулах, анти-Д титр тодорхойлох, резусийн дэд бүлэг тодорхойлох 7 нэр төрлийн шинжилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр хийсэн. | Жил бүр үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу Цус сэлбэлт судлалын чиглэлээр иммуногематологийн лавлагаа шинжилгээг 100% хийж, хариуг олгосон байна. | Үйлчлүүлэгчийн хүсэлтээр:<br>Цусны хувийн тохироо-1361<br>Кумбсын шууд ба шууд бус урвал-532<br>Эргэлзээтэй бүлэг-19<br>Эсрэгбие илрүүлэх, дүйх-178<br>Анти-Д титр-612<br>Резусын дэд бүлэг-3146<br>Нярайн бүлэг,резус-3<br>Д баталгаажуулах-125<br>шинжилгээг тус тус хийж хариуг олгосон. 2023 оноос цусны АВО дэд бүлэг тодорхойлох шинжилгээг шинээр нэвтрүүлэн өөр бүлэгтэй донороос эд эрхтэн шилжүүлэн суулгасан нийт 3 тохиолдлын (донор болон резипентийн) шинжилгээг хийж хариуг олгосон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32. | Цусны бүлэг, хувийн тохирооны Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | 5.6 Улсын төсөв | Гэрчилгээ авсан лабораторийн тоо | 2022 онд 2 удаа зохион байгуулж 85 байгууллагад Үндэсний чанарын гадаад үнэлгээний гэрчилгээ олгосон. | 19, 20 дахь удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, 18, 19 дах удаагийн үнэлгээнй тайлан семинарыг зохион байгуулж, үнэлгээнд оролцсон лабораториудад гэрчилгээг олгосон байна. | 2023 оны 4 сарын 26-нд чанарын гадаад үнэлгээ ба стандартчлал сэдэвт тайлан семинарыг зохион байгуулж 18 дах удаагийн үнэлгээний гэрчилгээг лабораториудад олгосон.<br>2023.05.29-нд цусны бүлэг, хувийн тохирооны 19 дэх удаагийн ЧГҮ-ний хөтөлбөрийг 105 лабораторийг хамруулан зохион байгуулсан.<br>2023.09.05-нд Гадаад үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж, 19 дэх удаагийн дүнг бүх оролцогчдод танилцуулж, сертификат олгосон.<br>2023.11.29-д цусны бүлэг, хувийн тохирооны 20 дах удаагийн ЧГҮ-ний хөтөлбөрийг 104 лабораторийг хамруулан зохион байгуулсан. | 100% |
| 33. | Цусны бүлэгнэлтийн шинжилгээний Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | 8.0 Улсын төсөв Ханган нийлүүлэгч байгууллага | Үндэсний чанарын гадаад үнэлгээнд оролцсон лабораторийн тоо | 2022 онд 6, 11 сард 2 удаа зохион байгуулж, 80%-иас дээш үнэлгээтэй оролцсон лабораториудад гэрчилгээ олгосон. | 4, 5 дах удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, 3, 4 дэх удаагийн үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж, амжилттай оролцсон лабораториудад гэрчилгээг олгосон байна. | 2023 оны 4 сарын 26-нд чанарын гадаад үнэлгээ ба стандартчлал сэдэвт тайлан семинарыг зохион байгуулж 3 дах удаагийн үнэлгээний гэрчилгээг амжилттай оролцсон лабораториудад олгосон.<br>-2023.05.29-нд цусны бүлэгнэлтийн 4 дэх удаагийн ЧГҮ-ний хөтөлбөрийг 95 лабораторийг хамруулан зохион байгуулсан.<br>-2023.09.05-нд Гадаад үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж, 4 дэх удаагийн дүнг оролцогчдод танилцуулж, 80%-с дээш оноо авсан 38 лабораторит сертификат олгосон.<br>2023.11.29-нд цусны бүлэгнэлтийн 5 дахь удаагийн ЧГҮ-ний хөтөлбөрийг 102 лабораторийг хамруулан зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2.3. Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй стандартын хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангах, сайжруулах | | | | | | | |
| **Зорилт 2.3.1. О**лон улсын болон үндэсний стандартын шаардлагыг тогтвортой хангаж, тасралтгүй сайжруулна. | | | | | | | |
| 34. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2018-2022 оны Чанарын хөгжлийн хөтөлбөрийг 95 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, 2023 онд төлөвлөсөн ажлын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө /2023-2025/-г нийт 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн. Үүнээс 2023 онд 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 19 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, төлөвлөгөөний биелэлт 90 хувь. | 90% |
| 35. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологи, чанарын шаардлагын магадлан итгэмжлэлд хамрагдана. | 1.0 Улсын төсөв | Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ | 2018 онд магадлан итгэмжлэлд хамрагдаж 5 жилээр итгэмжлэгдсэн. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологи, чанарыг шаардлагын магадлан итгэмжлэлд хамрагдаж гэрчилгээг сунгасан байна. | 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 5 хүний бүрэлдэхүүнтэй Магадлан итгэмжлэлийн шинжээч нар ажиллаж, магадлан итгэмжлэлийн хугацааг 3 жилээр сунгуулсан. | 100% |
| 36. | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх | | Аудитын тайлан, зөвлөмж | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлж, 2022 онд магадлах аудитад амжилттай хамрагдсан. | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын батал-гаажуулах аудитад хамрагдсан байна | Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын 3 дахь давтан баталгаажуулалт, ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын магадлах аудитыг нэгдсэн байдлаар 2023 оны 11 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Монсертф ХХК-ий аудитад амжилттай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх | | Аудитын тайлан, зөвлөмж | 2022 онд ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын баталгаажуулах аудитад амжилттай хамрагдсан. | Жил бүр ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын магадлах аудитад хамрагдаж, ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог тогтвортой хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулсан байна. | хамрагдаж, гэрчилгээний хугацааг 3 жилээр сунгуулсан. Нэгдсэн менежментийн тогтолцоонд шилжих ажлын хүрээнд тогтолцооны гарын авлага, бодлого, зорилтыг шинэчлэх болон бусад холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэж Менежментийн тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлж, хадгалж байна. | |
| 38 | Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015 стандартыг хэрэгжүүлэх | | Аудитын тайлан, зөвлөмж | 2022 онд Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015 стандартын баталгаажуулах аудитад амжилттай хамрагдсан. | Жил бүр Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015 стандартын магадлах аудитад хамрагдаж, лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлагыг тогтвортой хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулсан байна. | Тус тасаг нь ISO 15189:2015 стандартыг хэрэгжүүлэх хүрээнд: Сэрэмжлүүлэх аюултай үр дүнг мэдээлэх журмыг шинэчилэн батлуулсан.<br>HISCL-5000 аюулгүй ажиллагааны зааврыг шинэчлэн батлуулсан.<br>Донорын шинжилгээний 5 САЗ-ыг шинэчлэн батлуулсан.<br>4 халдварын САЗ-ыг шинэчлэн батлуулсан.<br>Лабораторит хэрэглэж байгаа оношлуур урвалжийн хор аюулын мэдээллийг гаргаж САЗ, АЗ боловсруулж, сургалт хийсэн. 2023.11.29-нд Дотоод аудит хийгдэж 11 сайжруулах зөвлөмж гарсныг залруулж ажилласан. 2023.12.25-нд УДШ-г хийж шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2023 онд Үндэсний итгэмжлэлийн төвөөс магадлах аудит хийх хүний нөөц байхгүй гэсэн шалтгаанаар ирээгүй. | 90% |
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 3. Хүний нөөцийн хөгжлийг хангах, мэдээллийн технологи, сургалт, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэн, инноваци нэвтрүүлэх | | | | | | | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3.1. Хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажлуулах, хөгжүүлэх | | | | | | | |
| **Зорилт 3.1.1. Т**өрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангана. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 39. | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2021-2025)-ийн хэрэгжилтийг хангана. | 1228.0 Улсын төсөв | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2022 оны төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн. | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт тодотгол хийж, жил бүр төлөвлөгөө гарган, хэрэгжилтэнд үнэлгээ хийсэн байна. | Төвийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2021-2025)-ийн 2023 онд төлөвлөсөн арга хэмжэг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Үүнд:<br>- 2023 онд ЭМЯ, ЭМХТ болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан 63 удаагийн сургалт, семинар, зөвлөгөөнд мэргэжил, чиглэлийн дагуу давхардсан тоогоор нийт ажиллагсдын 48 хувь хамрагдсан.<br>- Энэ онд 5 сувилагч магистрын зэрэг, Мэргэжлийн “Ахлах” зэрэг 1 сувилагч хамгаалж, МСН, ХБНГУ-тай хамтарсан ”Эмнэлгийн халдвар хяналтын сувилагч” бэлтгэх сургалтад 2 сувилагч, 1 туслах сувилагчийг ариутгалын курсд сургаж бэлтгэсэн байна. ЭМЯ-наас зохион байгуулсан гадаадад туршлага судлах сургалтад 1 сувилагч, МУЗН-нээс 1 сувилагчийг “Амьлуулах суурь тусламж” чиглэлээр гадаадад туршлага судлах сургалтад тус тус хамруулсан байна.<br>- Нийт ажилтан, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбогдуулж 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 58 тоот албан бичгийг Үйлдвэрчний эвлэлийн хорооны саналын хамт Эрүүл мэндийн сайдад хүргүүлж дэмжлэг хүссэн.<br>- Дотоод зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ажилчдын цалин, хөлсийг холбогдох хууль дүрмийн дагуу 2023 оны 1, 7 саруудад тушаалаар шинэчлэн баталж мөрдсөн. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Төвийн албан хаагчидад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг мөн хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, эзгүй ажилтны ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл зэргийг хууль, журамд нийцүүлэн олгосон.<br>- МУ-ын ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу ур чадварын нэмэгдлийг 25 хүртлэх хувиар 7 удаа, 2019 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг улирал бүр 60 хүртэл хувиар урамшуулалт цалин олгосон.<br>- Санхүүгийн аудитын зөвлөмжийн дагуу 2 албан тушаалын 6 ажилтны цалинг шинэчилэн тогтоосон.<br>- Сангийн сайдын тушаалын дагуу үйл ажиллагааны давсан орлогын 60 хүртэл хувийг ажилтны нийгмийн асуудалд шийдвэрлэхээр ажиллаж байна.<br>- Байгууллагын соёлын баг, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын зөвлөлтэй хамтран “Өглөөний цайтай” уулзалтыг 4-р улиралд 8 удаа удирдамж, хуваарийн дагуу тасаг нэгжүүдтэй хамтран зохион байгуулж өглөөний цайны ач холбогдол, хамт олны ажилд амжилт хүсч талархал илэрхийлэх арга хэмжээ хийв.<br>- “Стрессээ инээдээр солъё” хөгжөөнт үйл ажиллагаа зохион байгуулж, 20 хүнийг хамруулж 2 удаагийн бичлэг хийж байгууллагын цахим хуудсанд байршуулах, “Урмаар тэтгэе” ажиллагсадад урам өгөх зорилгоор урмын үгийг бие биедээ хэлж, сэтгэлийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлэг бэлэглэх ажиллагааг зохион явуулж 67 ажилтан хамрагдсан.<br>- “Спиртээр биш спортоор” уриатай шинэ жилийг угтсан спортын аяныг зохион байгуулах удирдамж батлан цуврал тэмцээн зохион байгуулж эрүүлжүүлэх, спорт олон нийтьийн ажлыг идвэхжүүлэх ажлыг зохион байгуулж байна.<br>- ҮЭХ-оос нийт ажилтаны дунд “Ажилтнаа сонсьё” аяныг зохион байгууж, санал асуулга авч, цаашид авах арга хэмжээ, шийдвэрийг албан хаагчдад танилцуулж зарим үр дүн гарсан.<br>- ”Эрүүл бие-эрүүл шүд” аяныг санаачлан хэрэгжүүлж Нийслэлийн шүд эрүү нүүрний төвтэй хамтран 2023 онд 03-р сарын 02-ны өдөр эмч ажиллагсдад шүд, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эрүүлжүүлэх арга хэмжээ авсан.<br>- Нийт ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.<br>- Сүрьеэгийн лабораторийн оношилгоог сайжруулах зорилгоор QIAreach QFT оношлуурыг шинээр нэвтрүүлэх арга, технологийн гүйцэтгэлийг үнэлэх нь” сэдэвт судалгааны харьцангуй эрүүл бүлгийн цусны донор, албан хаагчдыг 2023 оны 4 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд хамруулсан.<br>- Ажилтны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг дэмжиж Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дэргэдэх цэцэрлэгт тодорхой тооны хүүхдийг хамруулж ажилтны ажлаа амар тайван хийх нөхцлийг дэмжсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 40. | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах замаар тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | - | Нийт ажилчдад 3-аас дээш жил ажилласан ажилчдын эзлэх хувь | 2022 онд нийт ажилчдын тоонд 3-аас дээш жил тогтвортой ажилласан ажилчдын эзлэх хувь 55 байна. | Нийт ажилчдын тоонд 3-аас дээш жил тогтвортой ажилласан ажилчдын эзлэх хувь суурь түвшинөөс буураагүй байна. | 2023 оны хүний нөөцийн хөдөлгөөн 18 хувьтай, нөхөн хангалт 90 хувьтай байна. Нийт ажилчдын тоонд 3-аас дээш жил тогтвортой ажилласан ажилчдын эзлэх хувь 83 байна. | 100% |
| 41. | Төсвийн орлогын давсан хэсгээс олгох урамшууллын 60-аас доошгүй хувийг ажилтнуудын нийгмийн асуудал шийдвэрлэхэд зориулах | | Урамшуулалд зарцуулсан хэмжээ, хувь | 2021 онд 57 хувийг зарцуулсан байна. | 60-аас доошгүй хувийг зарцуулж, Цусны донорын тухай хуулийн төсөлд ажилтны нийгмийн хамгаалалтай холбоотой заалтыг тусгасан байна. | Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 224 дугаар тушаалаар 856 075 634 төгрөг үйл ажиллагааны орлогоос давж батлагдсан байна. Ерөнхий захирлын 2023 оны А/92 дугаар тушаалаар 368,4 сая төгрөгийг нийт ажилтны нийгмийн асуудлыг дэмжих, 6,6 сая төгрөгийг ахмад ажилтнууд дэмжлэг үзүүлэх, 5,4 сая төгрөгийг Монголын донорын холбоо ТББ-ын сайн дурын ажилтнуудын нийгмийн асуудлыг дэмжихэд тус тус зарцуулсан. | 100% |
| 42. | Ажлын гүйцэтгэл, ур чадварт суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ. | 132.0 Улсын төсөв | Мөнгөн урамшуулал олгох журам, Ур чадварын нэмэгдэл олгох журам, урамшуулал авсан ажилчдын хувь | 2022 онд Улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал болон ур чадварын нэмэгдлийг тооцон бүрэн олгосон. | 2023 онд ур чадварын нэмэгдлийг ажилтны 80-аас доошгүй хувьд олгосон байна. | 2023 онд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулалыг 4 удаа, ур чадварын нэмэгдлийг 7 удаа тус тус тооцож нийт ажилтны 95 хувьд олгосон байна. | 100% |
| **Зорилт 3.1.2.** Хүний нөөцийг бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 43. | Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод хэрэгжүүлж, | - | Хүний нөөцийн хөдөлгөөний хувь | 2022 оны хүний нөөцийн хөдөлгөөн 14 хувьтай, сул | Ажилтны тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, Сонгон | Сул ажлын байрыг нийтэд ил тод мэдээлж, сул ажлын байранд сонгон шалгаруулалт явуулах зарыг Зангиа.мн сайт, ЭМХТ-ийн HRDS систем, төвийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дасан зохицох хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. | | | ажлын байрыг нийтэд ил тод мэдээлж, нөхөн хангалт 90 хувьтай байсан. | шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн хэрэгжилт, ил тод байдлыг хангаж, хүний нөөцийн хөдөлгөөнийг жилд 15-аас доош хувьд тогтмол байлгана. | вэб сайт, пейж хуудсанд тус тус тухай бүр ил тод байршуулж ажилласан.<br>2023 оны хүний нөөцийн хөдөлгөөн **18 хувьтай**, нөхөн хангалт 93 хувьтай байна. | |
| 44. | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх | | Үнэлгээний дүгнэлт, авсан арга хэмжээ | 2018, 2021, 2022 онд мэргэжлийн байгууллагаар хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн. | Хөдөлмөрийн нөхцөлийн болон зарим ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. | 2018 онд ХАБЭМ-ийн төвөөр 13 ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэсэн. Ажлын хэвийн нөхцлөөр үнэлэгдсэн. 2021 онд АШУҮИС-ийн Хөдөлмөр орчны эрүүл ахуйн лабораториор гэрэлтүүлэг, агаарын харьцангуй чийглэг, температур, шуугианы хэмжилтүүдийг нийт 24 байршилд хийлгэсэн. Дахин хийлгэх шаардлага гараагүй тул энэ онд хийлгээгүй. 2023 онд АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээр үйлдвэрийн тасгийн технологич сувилагч, Инженер техникийн тасгийн тоног төхөөрөмжийн инженерийн ажлын байранд эрсдлийн үнэлгээг хийлгэсэн.<br>Дээрх үнэлгээний хүрээнд ирсэн 21 зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Нэгдсэн лабораторийн тасагт өгсөн зөвлөмжийн дагуу ашиглаж буй химийн бодисуудын “Хор аюулын лавлах мэдээлэл ХАЛМ-ийг боловсруулж лабораторид ажиллаж буй бүх ажиллагсдад танилцуулах сургалтыг зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | Эрүүл мэндийн ажилтныг мэдлэг чадвараа дээшлүүлэх боломжоор хангана. | - | Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, мэргэжлийн зэрэг шинээр авсан, ахиулсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 2022 онд мэргэшил дээшлүүлсэн, мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 72.5% байна. | Мэргэшил дээшлүүлсэн, мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувийг 2026 он хүртэл 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ. | ЦССҮТ-ийн нийт эмч, сувилагч эмнэлгийн мэргэжилтний 93,2 хувь нь төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн бөгөөд, 67,7 хувь нь мэргэшлийн зэрэг хамгаалсан байгаагийн **9,6 хувь нь** 2023 ондоо шинээр мэргэшлийн ахлах зэрэг хамгаалсан бөгөөд ахлах зэрэг хамгаалсан ажилчдын 6,4 хувь нь эмч 3,2 хувь нь сувилагч мэргэжилтэй албан хаагчид байсан байна. 2024 онд 1 эмч мэргэшлийн ахлах зэрэг, 1 эмч зөвлөх зэрэг хамгаалахаар шалгалтад хамрагдаж байна.<br>Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны Сургалт төслийн ажилтан Э.Энхболор 24 багц цагийн “Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи төрөлжсөн мэргэшлийн сургалтанд суралцаж төгссөн. Донор зохион байгуулалтын тасгийн технологич сувилагч Э.Дашгарав АШУҮИС-ийн “Чих хамар хоолой” мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтад, Цусны чанар, аюулгүй байдлын албаны Халдвар судлаач, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ажилтан Э.Чагцалдулам Монголын тархвар, халдвар судлаач эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулсан 18 долоо хоногийн “Infection prevention and control” сургалтад, Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга А.Амарзаяа удирдлагын академи дээр зохион байгуулагдсан Эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг чадавхижуулах 2 сарын сургалтад, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны Мэдээллийн технологийн инженер Ч.Далайцэрэн, Б.Хишиг-Очир нар Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан 32 өдрийн IT админ сургалтад тус бүр хамрагдсан. Мөн Донор зохион байгуулалтын тасгийн технологич сувилагч Э.Анар ЭМХТ-ийн 2023 оны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжил дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалтын намрын элсэлтээр “Цус, цусан бүтээгдэхүүний технологич” мэргэжил дээшлүүлэх сургалтад элсэн суралцаж байна. | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3.2. Цус сэлбэлт судлалын чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх | | | | | | | |
| **Зорилт 3.2.1.** Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | |
| 46. | Цус сэлбэлт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын бүс нутгийн болон гадаад орны байгуулагатай хамтын ажиллагааг хөгжүүлнэ. | 0.4 Улсын төсөв | Байгууллагын гишүүнчлэл хамтын ажиллагаатай байгууллагын тоо | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн (ISBT) 2022 оны гишүүнчлэлээ сунгасан. 2019 онд Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM)-той 4 жилийн хугацаатай санамж бичиг байгуулсан. | 2023 оны гишүүнчлэл сунгаж хамтран ажилласан байна. AATM-тай санамж бичигт заасан хамтын ажиллагаа хэрэгжсэн байна. | Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй 5 жилийн хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг /ISBT/-ийн гишүүнчлэлээ сунгаж “Affiliate Membership” гэрчилгээг 2023 оны 5 дугаар сард авсан.<br>Олон улсын Цус Сэлбэлтийн Нийгэмлэг(ISBT )-ийн гишүүнчлэлийн эрхийг ажилтан бүрийн Төрийн цахим шуудан https://mail.gov.mn/ email хаягийг шинээр бүртгүүлж мэдээлэл солилцож байна. Цусны 26 салбар төвийн ажилчдын мэдээллийг шинэчлэн ISBT-ийн боловсролын портал дээрх материал, илтгэл, вебинар, цахим ном, олон улсын удирдамжыг үнэ төлбөргүй авч танилцах, үйл ажиллагаанд оролцох, хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлсэн.<br>Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM -)ноос жил бүр зохион байгуулдаг XVIII удаагийн их хурал болон Цус сэлбэлтийн анагаах ухааны салбарын тэргүүлэх судлаач, эрдэмтэн, мэргэжилтнүүдийн олон улсын хурал болох AATM-AABB-ийн 4 дэх удаагийн хурлаар 2023 оны Азийн цус сэлбэлтийн холбооны шилдэг байгууллагаар шалгарсан.<br>Азийн цус сэлбэлтийн холбоотой 2013 оноос хойш хамтран ажиллаж байгаа ба | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санамж бичгийг 2023 оны 3 сарын 14 өдрөөс хойш 2028 он хүртэл 2 тал харилцан тохиролцож хамтын гэрээг байгуулсан. Хамтын гэрээний заалтууд бүрэн хэрэгжсэн. | |
| 47 | Эрүүл мэнд, боловсролын болон бусад төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх | | Хамтын ажиллагаатай байгууллага, хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 2022 онд 70 гаүй байгууллагатай гэрээ, санамж бичиг байгуулан ажилласан. | Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг үнэлсэн байна. | 2023 онд шинээр болон үргэлжлүүлэн 6 байгууллагтай байгуулсан хамтын ажиллагаа санамж бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: МУЗН, ЗХЖШ, Ротару Монгол Байгууллага, Монголын Донорын Холбоо, JCI Монгол байгууллага, Сэтгэлийн 1000 үйлс. JCI МОНГОЛ байгууллага нь Цус өгөх үндэсний өдрийг тэмдэглэн өнгөрүүлж 1 сарын туршид салбар 15 байгууллагын хамт олон цусаа бэлэглэсэн. | 90% |
| **Зорилт 3.2.2.** Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 48. | Эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулах | 10.5 Улсын төсөв | Зохион байгуулсан хурлын хөтөлбөр, илтгэлийн хураангуй | Цусны албаны эрдэм шинжилгээний онол, практикийн XYII бага хурлыг зохион байгуулсан. | Цус сэлбэлт судлалын салбарын онол, практикийн XIX бага хурлыг зохион байгуулагдаж, илтгэлийн хураангуй хэвлэгдсэн байна. | Монгол Улсын Цусны албаны 60 жилийн ойд зориулсан Олон Улсын Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Ерөнхий захирлын 2023.09.28-ний өдрийн А/62 тушаалаар батласан. Цус сэлбэлт судлалын салбарын олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Эмнэлзүйн цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, эмчилгээний үр дүн”, “Лабораторийн суурь судалгаа”, “Цусны албаны үндсэн үйл ажиллагаа” гэсэн үндсэн сэдвээр зохион байгуулсан. Ирүүлсэн илтгэлүүдээс 10 илтгэлийг сонгон аман хэлбэрээр, 5 ханын илтгэлийг тус тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сонгон шалгаруулж хэлэлцүүлсэн. ЦССҮТ-ийн Ерөнхий захирал АУ-ны доктор, профессор Н.Эрдэнэбаяр “Цусны албаны сургалт, эрдэм шинжилгээний ажлын өнгөрсөн ба одоо” сэдвээр, БНХАУ-ын Шанхайн цусны төвийн профессор Зу Зиан “Цусны ховор бүлэг” сэдвээр зочин илтгэл тавьсан. Зочин шүүгчээр АШУҮИС-ийн Био-Анагаахын сургуулийн Дархлаа судлалын тэнхимийн багш, АУ-ны доктор, дэд профессор Л.Энхсайхан, Молекул биологи, Удам Зүйн тэнхимийн багш, АУ-ны доктор, дэд профессор Ж.Жамбалдорж, Цус судлалын тэнхимийн багш АУ-ны доктор О.Пүрэвжал нар ажилласан. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн хураангуйг хэвлүүлж судлаачдын хүртээл болгосон. | |
| 49. | Цус сэлбэлт судлалын чиглэлээр “Үндэсний семинар”-ыг зохион байгуулна. | 8.0 Улсын төсөв | Семинарын хөтөлбөр, удирдамж, тайлан | 2022 онд “Үндэсний семинар”-ыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. | Үндэсний семинарыг зохион байгуулж, цусны салбар төвүүд, холбогдох эмч, мэргэжилтнийг мэргэжил аргазүйгээр хангасан байна. | ДЭМБ-ын санхүүгийн болон техникийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Цусны албаны 60 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Цус сэлбэлт судлалын салбарын “Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь сэдэвт Үндэсний семинар”-ыг баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу 2023.04.27-28-ны өдрүүдэд зохион байгуулж Эрүүл мэндийн яам, төв болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, 21 аймгийн 26 Цусны салбар төв болон төвийн удирдлага, эмч мэргэжилтэн нийт 240 хүн хамрагдлаа. Семинарын эхний өдөр ЦССҮТ-ийн хурлын танхимд 21 аймгийн 26 Цусны салбар төвийн нийт 80 орчим эмч, мэргэжилтнүүдийг хамруулж мэргэжил | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга зүйн дэмжлэг үзүүлэн, цусны салбар төвийн эрхлэгч эмч нар үр дүнгийн тайлан, сайн туршлага, ололт амжилтын талаар хэлэлцэн туршлага солилцлоо.<br>Семинарын хоёрдах өдөр Цус сэлбэлт судлалын нийт эмч, мэргэжилтнүүд болон Улсын болон хувийн хэвшлийн эмнэлэг, Цусны салбар төвүүд, нийт 160 эмч, мэргэжилтнүүдийг хамруулан Чингис хаан зочид буудлын Өргөө танхимд зохион байгуулав. Үндэсний семинарыг зохион байгуулснаар цус сэлбэлт судлалын чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг улсын болон хувийн хэвшлийн нийт эмч нарын дунд цусны чанар, аюулгүй байдлын талаарх мэдлэг, ур чадвар нэмэгдэж, цус сэлбэлт судлалын салбарын талаар бодлогын чиг хандлагыг тодорхойлж үр дүнд хүрсэн семинар болсон. Мөн Цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч гэрээт Эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн тайланд хийсэн дүн шинжилгээ, анхаарах асуудлыг хэлэлцсэн.<br>АШУҮИС, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХСҮТ, ГССҮТ-ийн эмч нар уригдан оролцож эмнэлэг тус бүрийн цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ, сүүлийн үеийн судалгаа, үр дүнг танилцуулав.<br>Цус сэлбэлт судлалын үндэсний семинарыг улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг хамруулан анх удаа зохион байгуулж байгаагаараа онцлог бөгөөд техникийн болон санхүүгийн тайланг ДЭМБ-д хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3.3. Цус сэлбэлт судлалын чиглэлээр сургалт зохион байгуулах, сургалт зохион байгуулах чадавхийг дээшлүүлэх | | | | | | | |
| **Зорилт 3.3.1.** Сургалт зохион байгуулж, эмч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулна. | | | | | | | |
| 50. | Богино хугацааны багц цагийн сургалт зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан эмч мэргэжилтний тоо | 2022 онд богино хугацааны багц цагийн сургалтыг 2 чиглэлээр нийт 7 удаа зохион байгуулж 192 эмч, мэргэжилтэн хамрагдсан | Богино хугацааны багц цагийн сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтэнг мэргэжил арга зүйгээр хангаж, чадавхжуулсан байна. | 2023 онд багц цагийн богино хугацааны сургалтыг үндсэн 2 сэдвээр 18 удаа зохион байгуулж нийт 1452 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | 100% |
| 51. | Нийт ажилчдын авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн болон бусад тасралтгүй сургалт зохион байгуулах | | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, 2022 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүл мэндийн яамны батлагдсан ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Эхний хагас жилийн тайланг 06 дугаар сарын 13-ны 267 дугаар албан бичгээр, бүтэн жилийн тайланг 12 сарын 01-нд хугацаанд нь хүргүүлсэн. Зохион байгуулсан сургалтын тоо 9, ажиллагсдын хамрагдалтын хувь 90% байна. | 100% |
| **Зорилт 3.3.2.** Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | | | | | | | |
| 52. | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал /их эмч/, Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи/ биоангаах судлаач/ чиглэлээр төрөлжсөн | 4.0 Суралцагч-дын төлбөр | Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тушаал, төгссөн эмч, мэргэжилтний тоо | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал чиглэлээр 9 их эмч, Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр 3 био-анагаахын мэргэжилтэн, тус | Эмнэлзүйн цус сэлбэлт судлалаар , Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн сургалтыг тус тус | Эрүүл мэндийн сайдын А/533 тоот тушаалын дагуу 2022 оны намрын элсэлтээр элссэн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтыг ЭМХТ-ийн захирлын А/14 тоот тушаалаар 03 сарын 31-ний өдөр төгсөлтийн шалгалт зохион байгуулж шалгалтын протоколыг ЭМХТ-д хүргэсэн.<br>Эрүүл мэндийн сайдын А/216 тоот тушаалаар Эмнэл зүйн цус сэлбэлт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэшлийн сургалт зохион байгуулна. | | | тус суралцаж төгссөн. | зохион байгуулсан байна. | судлалын их эмчийн төрөлжсөн мэргэшлээр 3 эмч, Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи мэргэжлээр 1 Био-анагаахын мэргэжилтэн элсэн суралцаж 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр төгсөлтийн шалгалтыг зохион байгуулж ЭМХТ-д шалгалтын протоколыг хүргэсэн. 2023 оны 11 сарын 08 нд ЭМС-ын А/394 тоот тушаал гарч 4 гэрчилгээг баталгаажуулахаар ЭМХТ-д хүргүүлсэн. | |
| 53. | Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн /сувилагч/ мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | 4.0 Суралцагч-дын төлбөр | Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тушаал, төгссөн сувилагчийн тоо | Цус, цусан бүтээгдэхүүний технологич чиглэлээр 3 сувилагч тус тус суралцаж төгссөн. | Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан байна. | ЭМХТ-ийн захирлын мэргэжил дээшлүүлэх сургалтын А/09 дүгээр тушаалаар 2 сувилагч төгссөн.<br>Мэргэжил дээшлүүлэх сургалтад 2023 оны 05 дугаар сарын 26-ний өдрийн ЭМХТ-ийн захирлын А/43 тоот тушаалаар 5 сувилагч элсэн суралцаж, ЭМХТ захирлын А/76 төгсөлтийн тушаалаар 4 сувилагч төгссөн. | 100% |
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ:4. Байгууллагын хөгжил, ил тод байдлыг хангах | | | | | | | |
| **Зорилт 4.1.1** Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. | | | | | | | |
| 54. | Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллана. | - | Цусны донорын тухай хууль | Цусны донорын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, шат шатны хэлэлцүүлэг хийгдсэн. | Хуулийн төслийг өргөн барьсан байна. Батлагдсан хуулийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. | Цусны донорын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан УИХ-ын Ажлын хэсэгт хүргүүлсэн. Засгийн газар, холбогдох яам, агентлагуудаас санал авч төсөлд тусгасан. D-Parliament.mn сайтад байршуулан олон нийтийн санал авч, 2022 оны 9 сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Засгийн газраас хуулийн төсөлд өгсөн санал, дүгнэлтийг нэгтгэн 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр УИХ-ын Ажлын хэсгийн хурал, Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд тус тус танилцуулсан байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Холбогдох ажлуудыг бүрэн хийсэн. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсон “Цусны донорын тухай хуулийн төсөл”-ийг УИХ-ын бүрэн эрхийн дагуу бие даан санаачлан боловсруулж, батлуулахаа УИХ-ын гишүүн уламжилсан болно. | |
| 55. | Төвийн бүтэц үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулна. | 1.0 Улсын төсөв | Шинэчлэн боловсруулсан стандартын төсөл | ЦССҮТ-ийн бүтэц, үйл ажиллагааны MNS 6674:2017 стандартыг мөрдөж байна. | | Ерөнхий захирлын 2023 оны А/77 дугаар тушаалаар ЦССҮТ-ийн бүтэц, үйл ажиллагааны MNS 6674:2017 стандарт шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ЦЧАБА-ны даргаар ахлуулсан 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажилласан. Ажлын хэсэг Үндэсний болон Олон улсын жишигт нийцүүлэн стандартыг шинэчлэх төслийг боловсруулж байна. | 2024 онд төлөвлөсөн |
| 56. | Цусны донорын тухай хуультай уялдуулан байгууллагын дүрэм, бүтцийг шинэчлэн батлуулна. | - | Төвийн шинэчлэн батлуулсан бүтэц, дүрэм | 2020 онд батлагдсан дүрэм, бүтцээр үйл ажиллагаа явуулж байна. | | Цусны донорын тухай хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, санал авах ажлуудыг бүрэн хийсэн. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсон “Цусны донорын тухай хуулийн төсөл”-ийг УИХ-ын бүрэн эрхийн дагуу бие даан санаачлан боловсруулж, батлуулахаа УИХ-ын гишүүн уламжилсан болно.<br><br>Цусны донорын тухай хууль батлагдахаар хуультай уялдуулан төвийн дүрэм, бүтцийг шинэчлэхээр төлөвлөж байна. | 2024 онд төлөвлөсөн |
| 57. | Үйл ажиллагаатай холбоотой журам заавруудыг шинэчлэх | | Шинэчилсэн журам, заавар | 2022 оны байдлаар төвийн үйл ажиллагааг зохицуулж буй 58 | Төвийн үйл ажиллагааг зохицуулж буй бүх журмуудыг | Нэгдсэн менежментийн тогтолцоонд шилжих хүрээнд төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, стандарт үйл | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | журамд үнэлгээ хийсэн. | шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | ажиллагааны зарим зааварт шинэчлэл хийсэн.<br><br>Байгуулагын хэмжээнд нийт<br><br>1. Үйл явцын тодорхойлолт зураглал-9<br>2. Журам-70<br>3. Стандарт ажиллагааны заавар-81<br>4. Тоног төхөөрөмжийн ажлын заавар -39<br>5. Ажлын заавар-60<br>6. Маягт-180<br>7. Хяналтын хуудас-36 тус тус мөрдөн хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 58. | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой дагалдаж гарах журмуудыг боловсруулж мөрдөх | - | Журмын хэрэгжилтийг хангаж авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөө, Сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, Цалин хөлсний журам, Шагнал, урамшлын журмыг боловсруулж баталсан. | Шинэчлэн батлагдсан Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөө, Сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, Цалин хөлсний журам, Шагнал, урамшлын журмыг хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Шинэчлэн батлагдсан Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөө, Сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, Цалин хөлсний журам, Шагнал, урамшлын журмыг хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br><br>Төвийн ажиллагсдад Ур чадварын нэмэгдэл олгох журмыг шинэчлэн баталсан.<br><br>Засгийн газрын 240 дүгээр тогтоолын дагуу 6 ажилтны цалингийн зэрэглэлийг шинэчлэн А01 тушаалаар баталгаажуулсан. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төвийн хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэх санал авч 2024 онд шинэчлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 59. | Эрүүл мэндийн улсын албаны тушаал, шийдвэр, төлөвлөгөөтэй уялдуулан төвийн гамшгийн үеийн ажиллах журам, төлөвлөгөөг шинэчлэн, бэлэн байдлыг хангаж ажиллах | | Тодотгосон төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ЦССҮТ-ийн ажиллах журмыг 2021 оны А/17 тушаалаар шинэчлэн баталсан. ТУТ-ны төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийсэн. | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах тодотгосон төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. | ЦССҮТ-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Чанарын менежмент, эрсдэлийн удирдлагын багаар эрсдэлийн үнэлгээ хийлгэн тодотгол хийж БЗД-ийн Онцгой байдлын хэлтсээр шинэчлэн батлуулсан. ОБЕГ-ын даргын 2019 оны А/388 дугаар тушаалын дагуу БЗД-ийн Онцгой байдлын хэлтэс, ЧД-ийн Онцгой байдлын хэлтсээс чиглэл, мэдээлэл авч ажилласан. Тодотгосон төлөвлөгөө хэрэгжилт 100%. Төлөвлөгөөнд:<br>● Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч<br>● Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг<br>● Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн орон тооны бус бүлгийн тусгай үүрэг гүйцэтгэх бүлгүүдийн томилгоот бүрэлдэхүүний гүйцэтгэх чиг үүрэг<br>● Байгууллагын эрсдэлийн менежмент<br>● Байгууллагын гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах 2023 оны төлөвлөгөө<br>● Байгууллагын гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах 2023 оны төлөвлөгөө<br>● Аюулгүй цэгт цугларах, нүүн шилжих арга хэмжээ<br>● Гамшгийн үед байгууллагын ажилтан, албан хаагч, эд хөрөнгийг түр байранд нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэх арга хэмжээ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ● Гал түймрээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөө<br>● Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн хээрийн эмнэлгийн бүдүүвч<br>● Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги байгуулсан тушаал<br>● Холбоо зарлан мэдээллийн схем<br>● Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн судалгаа<br>● Төвийн ажиллагсдын авто тээврийн хэрэгслийн судалгаа<br>● Улаанбаатар хотод газар хөдлөлтийн үеийн цус цуглуулалтын төлөвлөгөө<br>● Ажлын зураг зэргийг шинэчлэн тусгаж албажуулсан. | |
| Зорилт 4.1.2. Мэдээ тайлан гаргах, нэгтгэх, дүн шинжилгээ хийнэ | | | | | | | |
| 60 | Статистик мэдээ тайланг хүлээн авч нэгтгэх, дүн шинжилгээ хийх тайлагнах | - | Үндсэн үйл ажиллагааны өдөр тутмын тоон мэдээ, сарын статистик үзүүлэлт, тайлан | Сар бүр статистик үзүүлэлт гаргаж дүн шинжилгээ хийж танилцуулдаг. Өдөр тутам үндсэн үйл ажиллагааны тоон мэдээ гаргаж мэдээлдэг. | Тогтмол гардаг статистик үзүүлэлт, тоон мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж , эрх бүхий байгууллагад хугацаанд нь тайлагнасан байна. | Цусны салбар төвүүдээс батлагдсан маягтаар 2022 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж, ЭМХТ-д тайлангийн хугацаанд хүргүүлж, А үнэлгээ авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 61. | Шийдвэр гаргагчийг нотолгоонд суурилсан бодит мэдээллээр хангана. | - | Боловсруулсан мэдээлэл, тайлан | ЭМЯ, удирдлагыг шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, тайлангаар тогтмол ханган ажилладаг. | ЭМЯ, эрх бүхий байгууллага, удирдлагыг шийдвэр гаргахад нотолгоонд суурилсан бодит мэдээлэл тайлангаар тогтмол ханган ажилласан байна. | Цусны албаны сүүлийн 5 жилийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэн баяжуулж “Эрүүл мэндийн үзүүлэлт 2022” эмхэтгэлд 2022 оны онцлох үйл ажиллагааны хамт хэвлүүлсэн. Цусны албаны үндэсний семинарт тайлан мэдээ гаргалт, сайжруулах зөвлөгөөг танилцуулж мэргэжил арга зүйгээр хангасан. Цусны албаны үйл ажиллагааны статистик үзүүлэлтийн 2013-2022 оны дэлгэрэнгүй нэгтгэл гаргаж, мэдээний бүртгэлийн санг баяжуулсан. 2023 онд сарын бүрийн статистик мэдээг гарган, дүн шинжилгээ хийж, ажиллагсад болон удирдлагыг мэдээллээр тогтмол хангасан. Өдөр тутмын статистик тоон мэдээ гаргаж төвийн дотоод группэд байршуулж мэдээллийн шуурхай ил тод байдлыг хангаж, шийдвэр гаргах боломжоор бүрэн хангасан. Уламжлал болгон зохион байгуулладаг эрдэм шинжилгээний XX бага хуралд “ЦССҮТ-ийн цус цусан бүтээгдэхүүний зардлыг тооцсон дүн” Цусны албаны 2013-2022 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлийг харьцуулсан судалгаа сэдвээр хамтарсан илтгэл хэлэлцүүлсэн. Нийтэд мэдээллийн ил тод байдлыг хангаж https://donor.mohs.mn/web/?p=6565 хаягт тотмол байршуулсан. | 100% |
| **Зорилт 4.1.3.** Төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг сайжруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 62. | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн | 4.0<br>Улсын төсөв | Шинэчлэн батлуулсан Нягтлан бодох бүртгэлийн | 2019 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг анх | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэн боловсруулах санхүүжилтыг 2022 оны давсан орлогоос шийдвэрлэж, ХАА-ны төлөвлөгөөнд тусгаж хуулийн дагуу шийдвэрлэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, мөрдөнө. | | бодлогын баримт бичиг | боловсруулж хэрэгжүүлсэн. | боловсруулж, хэрэгжүүлсэн байна. | Хараат бус аудиторууд, нягтлан бодогч, захирлуудын холбоо ТББ-тай 2023 оны 06 сарын 21-ний өдрийн 23/10 тоот гэрээ байгуулан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн. | |
| 63. | Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангана. | - | Тайланд хийсэн дүн шинжилгээ | - | Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангах, байгууллагын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажилласан байна. | 2023 онд Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан. | 90% |
| **Зорилт 4.1.4.** Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног, төхөөрөмжийн шалгалт тохируулга баталгаажилтыг тогтмол хийлгэнэ. | | | | | | | |
| 64. | Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийх | 38.0 Улсын төсөв | Шинэчлэсэн тоног төхөөрөмжийн тоо | 2016-2019 онд Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж, тавилгын иж бүрэн шинэчлэл хийсэн. | Жил бүрийн төсөвт шаардлагатай эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн төсвийг тусган шийдвэрлүүлж, тоног төхөөрөмж ийн шинэчлэлийг үе шаттай хийсэн байна. | Ашиглалтын хугацаа дууссан, эвдрэл гэмтэлтэй эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийг жил бүр төсөвт тусгадаг боловч шийдвэрлэгдэхгүй байна. | 30% |
| 65 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, хэвийн үйл үйл ажиллагааг ханган, мэргэжлийн байгууллагаар шалгалт, тохируулга, | 38.0 Улсын төсөв | Шалгалт тохируулга, баталгаажуула лт, Засвар үйлчилгээ хийсэн удаа | 2022 онд тоног төхөөрөмжийн баталгаажуулалт 8, багаж хэрэгслийн шалгалт тохируулга 39 удаа хийлгэсэн. Эмнэлгийн тоног төхөөрөмжид 7 удаагийн | Жил бүр эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ шалгалт тохируулга, баталгаажуулалтыг бүрэн хийж үйл ажиллааны хэвийн байдлыг хангаж ажилласан байна. | Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дугаартай ‘’ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийх’’ журмын дагуу төвийн хэмжээнд ашиглагдаж байгаа Электрон Жин-1, Температур, чийгшил хэмжигч-1, Автоклав монометр-1, Жингийн туухай-1, Механик, даралтын аппарат-5 Пепитика-9 Цусны жин-30 Аналитика жин-1 Биеийн өндөр жин хэмжигч нийт 53 ширхэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баталгаажуулалт тогтмол хийлгэх | | | төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийсэн. | | хэмжих хэрэгсэлийг мэрэгжлийн байгууллагаар шалгалт тохируулга, баталгаажуулалт хийлгэсэн. Төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг сар болгон үзлэг, засвар үйлчилгээ хийж техникийн ашиглалтын паспортод тэмдэглэл хөтөлж хэвийн үйл ажиллагааг хангаж, төлөвлөгөөний биелэлт 100% хэрэгжсэн. | |

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ДАРГА Ч.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

# ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023-2026 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

# НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь 1963 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 505 дугаар тогтоолоор анх байгуулагдсан бөгөөд Эрүүл мэндийн тухай хууль, Донорын тухай хууль, Эрүүл мэндийн сайдын холбогдох тушаалууд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, санамж бичигт заасны дагуу цусны донор элсүүлэлт, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлтийн чиглэлээр лавлагаа тусламж үзүүлэх, оношилгоо, эмчилгээний заавар, стандарт, арга зүйн зөвлөмж боловсруулах, цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, судалгаа шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд эмчилгээний өндөр чанар бүхий аюулгүй найдвартай цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эмнэлгүүдийн хэрэгцээг хангаж ажилладаг.

Цус сэлбэлт судлалын салбарт шинэ технологийг нэвтрүүлж нутагшуулснаар үйл ажиллагааны чанар хүртээмж жилээс жилд сайжирч байна. Тухайлбал сүүлийн 10 жилд улсын хэмжээнд нийт цус цуглуулалт 73.1 хувиар, цус цусан бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2.1 дахин, цус цусан бүтээгдэхүүний хадгалалтын хүчин чадал 5 дахин тус тус нэмэгдсэн ба цус сэлбэлтээр дамжих халдварын хасагдалт 8.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ЦССҮТ нь Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, MNS ISO 9001:2016 стандарт, Эрүүл мэндийн лаборатори-чанар ба чадавхад тавих шаардлага ISO 15189:2012 стандарт, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны OHSAS 18001:2007 стандартыг тус тус нэвтрүүлж, олон улсын болон үндэсний байгууллагаар баталгаажуулсан анхны Эрүүл мэндийн байгууллага болсон.

Монгол улс 2016 онд 100 хувь сайн дурын, авлагагүй донорын тогтолцоонд шилжсэн бөгөөд 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо Улаанбаатар хотын хэмжээнд 2020 онд 18.3 болж 5.3-аар өссөн, байнгын донорын эзлэх хувь 2010 онд 35.7 байсан бол 2020 онд 65 хувь болж 29.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн тус төв 2017 оныг хүртэл нийт 15 нэр төрлийн цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол өнөөдрийн байдлаар 30 гаруй нэр төрлийн технологи шингэсэн, эмчилгээний өндөр үр дүн бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2007 онд "Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар

баримтлах бодлого" баталсан бөгөөд уг бодлогын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө (2008-2015 он)-г Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 111 дүгээр тогтоолоор батлан, 5 зорилтын хүрээнд 41 арга хэмжээ төлөвлөн 96,9% -ийн үзүүлэлттэй хэрэгжүүлж ажилласан. Дээрх арга хэмжээний дунд цус сэлбэлтээр дамжих халдвар болох ХДХВ, Гепатит В, С вирусийн халдвар илрүүлэх нуклейн хүчил олшруулах шинжилгээг орчин үеийн аргаар хийх, аюулгүй байдлыг бүрэн хангасан цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах боломж бүрдсэн. Түүнчлэн дээрх арга хэмжээний хүрээнд цусны албаны үндсэн үйл ажиллагааны цахим програмыг бүрэн нэвтрүүлж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн ашиглаж байгаагийн дээр Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний загвар төвийг анх удаа байгуулж, цусны албаны тоног төхөөрөмжийн ашиглалт, засварыг хариуцан ажиллаж ирлээ.

Сүүлийн жилүүдэд хүн амын дунд өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны өвчлөл, хорт хавдар, осол гэмтэл, элэг, бөөрний эмгэг орж байгаа бөгөөд анагаах ухааны салбарт элэг, ясны чөмөг шилжүүлэн суулгах зэрэг шинэ технологиуд нутагшин эмнэлгийн тусламж, үйлчилгээний цар хүрээ нэмэгдэхийн хэрээр цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өссөөр байна.

Тухайлбал: Өндөр хөгжилтэй орнуудад ЦЦБ-ний 75 хувийг 65-аас дээш насны хүн амд хэрэглэдэг, бага, дунд орлоготой орнуудад 52 хувийг нь 0-5 насны хүүхдэд хэрэглэдэг дэлхийн статистик байдаг бол манай улсын хувьд цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгч өвчтөнүүдийн 50.5 хувь нь 36-65 нас буюу ид хөдөлмөрийн насны хүмүүс байна. Монгол улсад 2021 оны байдлаар нийт цусны донорын 74 хувь нь 40 хүртэл насны иргэд байгаа бөгөөд хүн амын суваргын хэтийн төлөвөөр идэвхтэй донор /24-45 нас/-ын хүн амын тоонд эзлэх хувь 2 дахин буурахаар байгаа бөгөөд дунджаар 20 орчим жил үргэлжлэх цонх үеийн цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах нь бидний өмнө тулгамдсан гол асуудал болохоор байна. Бидний хийсэн тооцооллоор 2035 он хүртэл цус, цусан бүтээгдэхүүний захиалга, хэрэглээ жил бүр нэмэгдэх хандлагатай байна.

Иймд цусны донорын хөдөлгөөнийг идэвхжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, цус сэлбэлтээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, цусны аюулгүй байдлыг хангах, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийг зохистой түвшинд байлгах, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээс

бүтээгдэхүүн үйлдвэрлэж эмчилгээнд хэрэглэж эхлэхтэй холбоотой эрх зүйн актуудыг шинээр болон шинэчлэн батлуулах, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн технологийн дэвшлийг тогтвортой хадгалан улам бүр боловсронгуй болгох, санхүүжилт, хүний нөөц, зохион байгуулалт, бүтцийн хүрээнд цус сэлбэлт судлалын салбарт үүсэж байгаа, цаашид улам хүндэрч болзошгүй зарим эрсдэлийг бууруулах зайлшгүй шаардлагатай байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн орон тоо 2014 оноос хойш 20 орчим хувь нэмэгдсэн байхад цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулалт, шинжилгээ, үйлдвэрлэлийн хэмжээ 2021 оны байдлаар 85-109.1 хувиар нэмэгдэн, 2035 он гэхэд дахин 210-275 хувь өсөх тооцоо гарч байна. Энэ ачааллыг өнөөгийн хүний нөөцөөр давах ямар ч боломжгүй байгаа төдийгүй цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, цаашид аймаг, хотуудын Цусны салбар төвүүдийн чадавхыг бэхжүүлэх, дэлхий нийтээр баримталж байгаа “Нэгдсэн тогтолцоо”-нд үе шаттайгаар шилжих асуудлыг шийдвэрлэх, цус сэлбэлт судлалын салбарт ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг дэмжих асуудал тулгамдаж байна.

Монгол Улсын ““Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2.2.10-д “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.”, 2.2.11-т “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.”, 2.2.15-д “Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна” (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт) гэж тус тус заасан болон дээр дурдсан нөхцөл байдалтай уялдуулан Цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг онцгой анхаарч, нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах шаардлага тулгарч байна.

Цусны доноруудаас авсан судалгаагаар цусны байнгын донорт дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг сайжруулах, цус өгсөн донорыг илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх, хүн амын дунд ялангуяа оюутан, сурагчдад цусны донорын нийгмийн ач холбогдлыг таниулсан сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, цусны донорын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас чөлөөлөх зэрэг цусны нөөц хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох, үндэсний аюулгүй байдалтай холбоотой онцлог салбарын хувьд төрөөс цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн талаар онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Энэхүү стратеги төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2050 онд хэрэгжих бодлого, УИХ-ын 2020 оны 23 тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020 оны 203 тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, УИХ-ын 2021 оны 56 тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2022 жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилго зорилтод нийцүүлэн боловсрууллаа. Мөн ЦССҮТ-ийг 2017-2020 онд хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгасан боловч эдийн засаг, нийгмийн хүчин зүйл, эрх зүйн зохицуулалт зэргээс шалтгаалан дутуу хэрэгжсэн буюу огт хэрэгжээгүй Улаанбаатар хотод 2-3 цус цуглуулах төвийг шинээр байгуулах, Бүх шатны боловсролын хичээлийн хөтөлбөрийн эрүүл мэндийн хичээлийн агуулга, бүтцэд цусны донорын тухай хичээл оруулах зэрэг арга хэмжээг 2022-2025 оны стратегид тусгалаа.

Дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа ажлын хэсэг байгуулан сургалтад хамруулж, төвийн зохион байгуулалтын нэгжүүдийн нийт 52 ажилтнаас судалгаа авсан бөгөөд мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг авч Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам батлах тухай" 216 дугаар тогтоол, мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар

баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдал, орчны шинжилгээ, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн болон үйл ажиллагааны зорилтууд тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, хяналт үнэлгээ гэсэн арга зүйн дарааллын дагуу боловсруулсан болно.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн мандатын шинжилгээг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн чиг үүргийг Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй 100 гаруй хууль болон Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагаанд хамаарах ерөнхий болон үндсэн чиг үүргийг "Эрүүл мэндийн тухай хууль, Донорын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, ХДХВ/ДОХ-той тэмцэх сэргийлэх хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Статистикийн тухай хуульд тулгуурлан тодорхойлсон. Тус төвийн чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж, холбогдох дүрмийг үзвэл "Ерөнхий чиг үүрэг 4, үндсэн чиг үүрэг 13" байна. Үүнийг дараах хэсэгт дэлгэрэнгүй байдлаар харуулав.

Хүснэгт 1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий болон үндсэн чиг үүрэг

| Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо- 108 | | Монгол Улсын хууль тогтоомж |
|---|---|---|
| Үүнээс: | Цус сэлбэлт судлалын үндэсний төвд хамаарах хуулийн тоо -101 | Нийгмийн эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай хууль, ХДХВ/ДОХ-той тэмцэх сэргийлэх хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Статистикийн тухай хууль гэх мэт. |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо-9 | Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь Донорын тухай хууль, Эрүүл мэндийн тухай, Улсын нөөцийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай |

| | | |
|---|---|---|
| | | хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. |

**Ерөнхий чиг үүрэг 1.** Цус цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийн тасралтгүй байдлыг хангах

| № | Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэгч чиг үүрэг, оролцогчид |
|---|---|---|---|
| 1. | 1.1. Цусны донор элсүүлэх, цус цуглуулах | 1.1.1. Цусны донорын сургалт сурталчилгааг өргөжүүлж донор элсүүлэлтийг нэмэгдүүлэх | Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж |
| | | 1.1.2. Донор алдаршуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнг сайжруулах | Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд |
| | | 1.1.3. Цусны донорын эрүүл мэндэд учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх | ЭМЯ |
| | | 1.1.4 Цус цуглуулах төвийн тоог нэмэгдүүлж, цус тээвэрлэх үйл ажиллагаанд технологийн шинэчлэл хийх | ЭМЯ |
| 2. | 1.2. Цахим мэдээллийн сан бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах | 1.2.1. Цахим мэдээллийн сан бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангана. | Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд |
| 3. | 1.3. Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, шинжилгээ хийх | 1.3.1. Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | ЭМЯ, бусад эрүүл мэндийн байгууллага |
| 4. | 1.4. Цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах, олгох | 1.4.1. Технологи шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 100%-д хүргэх | ЭМЯ, бусад эрүүл мэндийн байгууллага |
| | | 1.4.2. Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, олголтод технологийн шинэчлэл хийх | ЭМЯ, бусад эрүүл мэндийн байгууллага |
| 62. | **Зорилт 4.1.3.** Төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг сайжруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, мөрдөх | Шинэчлэн батлуулсан НББ-ийн бодлогын баримт бичиг | 2019 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдсөн. | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх төслийг боловсруулж, батлуулсан байна.<br>Батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна. | Улсын төсөв |
| 63. | | Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангах | Тайланд хийсэн дүн шинжилгээ | - | Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах байгууллагын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажилласан байна. | Улсын төсөв |
| 64. | **Зорилт 4.1.4.** Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног, төхөөрөмжийн шинэчлэл хийх, шалгалт тохируулга баталгаажилтыг | Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийх | Шинэчилсэн тоног төхөөрөмжийн тоо | 2016-2019 онд эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж, тавилгын иж бүрэн шинэчлэл хийсэн. | Жил бүрийн төсөвт шаардлагатай эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг төсвийг тусган шийдвэрлүүлж, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийсэн байна. | Улсын төсөв |
| 65. | | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, хэвийн үйл | Шалгалт тохируулга, баталгаажуулалт, засвар | Эмнэлгийн тоног төхөөрөмжид 7 удаагийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ | Жил бүр эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шалгалт тохируулга, баталгаажуулалтыг бүрэн хийж үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажилласан байна. | Улсын төсөв |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тогтмол хийлгэнэ. | ажиллагааг ханган, мэргэжлийн байгууллагаар шалгалт, тохируулга, баталгаажуулалт тогтмол хийлгэх | үйлчилгээ хийсэн удаа. | хийсэн. 2021 онд тоног төхөөрөмжийн баталгаажуулалт 8, багаж хэрэгслийн шалгалт тохируулга 60 удаа хийлгэсэн. | | |

## НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн бүтэц, хүний нөөц (Зураг1.)

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2020 оны 445 дугаар тушаалаар батлагдсан бүтэц, орон тоогоор ажиллаж байна. ЦССҮТ нь Захиргаа, маркетингийн алба, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба, Цусны чанар аюулгүй байдлын алба, Санхүү, бүртгэлийн алба, Сувилахуй, үйлчилгээний алба, Донор злхион байгуулалтын тасаг, Нэгдсэн лабораторийн тасаг, Үйлдвэрлэлийн тасаг, Инженер техникийн тасаг гэсэн 5 алба, 4 үндсэн тасаг нийт 69 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

(Зураг1.)



## ЕС. ХАВСРАЛТ

### 1. Дотоод гадаад орчны шинжилгээний холбогдох материал

### ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн өнөөгийн нөхцөл байдлыг тус төвийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн болоод бодлогын баримт бичиг, статистик үзүүлэлт, гадаад дотоод хамтын ажиллагааны баримт бичиг болон асуулгын судалгааны аргаар цуглуулсан өгөгдөл мэдээлэлд тулгуурлан тодорхойлсон.

Зураг 2. ЦССҮТөвийн чиг үүргийн хэрэгжилт, үнэлгээний оноогоор




Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн чиг үүргийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээний дүнгээс үзвэл тус төв нь цаашид цусны донорын сургалт, сурталчилгаа, цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах, судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг ойрын хугацаанд тэргүүлэх чиглэлээ болгон анхаарч ажиллах шаардлага байгаа нь харагдлаа.

Цус сэлбэлт судлалын төвийн албан хаагчид байгууллагынхаа удирдлага, зохион байгуулалтад дунд буюу 3.79 гэсэн үнэлгээ өгсөн. Үүнийг задлан үзвэл байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, үйл ажиллагаандаа цахим технологийг нэвтрүүлэх, байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг үйл ажиллагаанд мөрдлөг болгох, байгууллагын доторх нэгжүүдийн үйл ажиллагааны уялдааг хангахад илүүтэй анхаарч ажилладаг нь сайшаалтай байна. Харин байгууллагын дүрэм, журмыг цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэх, байгууллагын стратегийг тодорхой болгох, ажилтнуудын ажлын

ачааллыг тэнцвэржүүлэх, ажилтнуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг албан тушаалын тодорхойлолтод тодорхой тусгах, ажил үүргээ сайн гүйцэтгэсэн албан хаагчийг урамшуулах, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох зэрэг асуудлыг цэгцлэх, үйл ажиллагааг улам сайжруулах шаардлага харагдав.

**Зураг 3.** Судалгаанд оролцогчдын хүйс, хувиар




Асуулга судалгааны дүн*:* Асуулга судалгаанд тус төвийн нийт 52 албан хаагч хамрагдсан бөгөөд тэдний 25 хувь нь эрэгтэй, 75 хувь нь эмэгтэй байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн нийт албан хаагчдын дийлэнх нь буюу 32.7 хувь нь 31-41 насны албан хаагчид байна. Түүнчлэн 30 ба түүнээс доош насны албан хаагчид нийт албан хаагчдын 30.8 хувийг, мөн адил хувийг 42-52 насны албан хаагчид эзэлж байгаагаас үзвэл тус байгууллагын албан хаагчдын насны бүтцийн ангилалд ялгаа бага байгааг илтгэж байна.

**Зураг 4.** Судалгаанд оролцогчдын нас, хувиар



Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн албан хаагчдын ихэнх нь буюу 44.2 хувь нь 3 ба түүнээс доош жил ажилласан туршлагатай байна. Үүнийг тус байгууллагын албан хаагчдын насны бүтэцтэй харьцуулан үзвэл залуу боловсон хүчин их байгааг илтгэж байна. Гэхдээ нийт албан хаагчдын 26.9 хувийг 4-10 жил, 15.4 хувийг 11-17 жил, 7.7 хувийг 18-24 жил, 5.8 хувийг 25 ба түүнээс олон жил ажилласан хүмүүс бүрдүүлж байна. Үүнээс үзвэл нийт албан хаагчдын бараг 73 орчим хувийг тодорхой ажлын туршлагатай албан хаагчид эзэлж байна.

**Зураг 5.** Судалгаанд оролцогчдын ажилласан жил, хувиар




Харин Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн албан хаагчдын боловсролын түвшинг харьцуулан харвал нийт албан хаагчдын 59.6 хувийг бакалавр, 28.8 хувийг бүрэн дунд, 11.5 хувийг магистрын зэргийн боловсролтой хүмүүс эзэлж байна. Эндээс үзвэл тус төвийн албан хаагчдыг цаашид илүү мэргэшүүлэх, сургаж хөгжүүлэх шаардлага байгаа нь харагдаж байна.

**Зураг 6.** Судалгаанд оролцогчдын боловсрол, хувиар



1. Чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох.

Цус сэлбэлт судлалын төвийн чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг тодорхойлох санал асуулгын судалгаанд нийт 52 албан хаагчдыг хамруулсан.

Судалгааны дүнгээс үзвэл Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн чиг үүргийн хэрэгжилт сайн буюу 83.2 (4.16 үнэлгээ) хувийн хэрэгжилттэй байна. Үүнийг задлан үзвэл тус төв нь цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг боловсруулах (4.44) болон хадгалах (4.44) үйл ажиллагааг хамгийн сайн хэрэгжүүлдэг, эрүүл мэндийн ажилтны нийгмийг баталгааг хангах (3.58) хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа хамгийн сул хэрэгжилттэй байна. Мөн цусны донорыг урамшуулах, цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, цусны донорыг сурталчлах, судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага байгаа нь судалгааны дүнгээс ажиглагдав. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн чиг үүргийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээг дараах зурагт үзүүлэв.

**Зураг 7.** Байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үнэлгээний оноогоор




Судалгааны дүнгээс үзвэл байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаа дунд буюу 3.64 гэсэн үнэлгээтэй байна. Тухайлбал, байгууллагын хувьд ажилтнуудын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг сайн хангаж ажилладаг нь судалгааны дүнгээс харагдлаа. Мөн тус байгууллагын албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг чамгүй сайн эзэмшсэн байдаг байна. Харин ажилтнуудыг сургаж, хөгжүүлэх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, ажилтнуудыг идэвх санаачилгатай ажиллах хөшүүргийг бий болгох, гүйцэтгэлийг урамшуулах, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зэрэг нь

байгууллагын хүний нөөцийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа нь харагдлаа.

**Зураг 8.** Байгууллагын хүний нөөцийн өнөөгийн байдал, үнэлгээний оноогоор




Байгууллагын төсөв, санхүүгийн өнөөгийн байдлыг авч үзвэл төсвийн ил тод байдал төдийлөн хангалттай сайн биш байгаа нь судалгаанд оролцогчдын үнэлгээний дүн (2.96)-гээс харагдлаа. Мөн байгууллагын ажилтнуудыг шагнаж, урамшуулах болон үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай санхүүгийн нөөц хомс байдаг нь тус байгууллагын хувьд хамгийн том бэрхшээл болж байна.

**Зураг 9.** Байгууллагын төсөв санхүүгийн байдал




Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь техник болон орчин нөхцөлийн хувьд сайн буюу 4.07 гэсэн үнэлгээтэй байна. Тухайлбал, ажилтнуудын ажиллах орчин

нөхцөл сайн бүрдсэн, байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийн нөөц, техник тоног төхөөрөмж хангалттай байдаг байна.

**Зураг 10.** Байгууллагын техник болон орчин нөхцөл




Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн албан хаагчид тус байгууллагад ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг (4.38) нь хамгийн том давуу тал болж байна. Өөрөөр хэлбэл, байгууллагын соёлын хувьд хамт олны дунд дотоод дүрэм, журмын хэрэгжилт сайн байдаг, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бие биенээсээ саадгүй авдаг, зохион байгуулалтын нэгж хэлтсүүд нь үйл ажиллагааны хувьд уялдаа холбоотой байдаг зэргээс үзвэл тус байгууллагын соёл харьцангуй сайн, хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдсэн байдаг байна. Энэ нь судалгаанд оролцогчдын үнэлгээнээс харагдаж байгаа бөгөөд байгууллагын соёлд өгсөн дундаж үнэлгээ нь сайн буюу 4.05 байна. Гэхдээ байгууллагын удирдлага болон ажилтнууд аливаа асуудлыг хамтран зөвлөлдөж хэлэлцэн шийдвэрлэдэг байдал төдийлөн сайн бүрдээгүй (3.83) нь цаашид сайжруулах шаардлагатай асуудал болж байна.

**Зураг 11.** Байгууллагын соёл, үнэлгээний оноогоор




Судалгааны үр дүнгээс үзвэл Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн гадаад орчны нөхцөл байдал харьцангуй таатай байдаг байна. Тухайлбал, судалгаанд оролцогчид байгууллагын гадаад орчны нөхцөл байдалд 3.99 гэсэн дундаж үнэлгээ өгчээ. Үүнийг задлан үзвэл цус сэлбэлт судлалын талаарх бодлого, зохицуулалт тодорхой байдаг, гадаадын болон дотоодын байгууллагын дэмжлэг, хамтын ажиллагаа сайн, иргэдийн ойлголт, ухамсар дээшилсэн, цусны донорын талаарх олон нийтийн боловсролын түвшин нэмэгдсэн төдийгүй жилээс жилд донорын тоо өсөн нэмэгдэж байгаа зэрэг давуу талууд байна. Харин цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин хангалттай сайн бүрдээгүй, байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай төсөв, хөрөнгө дутмаг, шаардлагатай санхүүгийн нөөцийг холбогдох эрх бүхий байгууллагууд тэр бүр шийдвэрлэж өгч чадахгүй байх зэрэг хүндрэл бэрхшээлүүд байдаг байна.

**Зураг 12.** Байгууллагын гадаад орчны нөхцөл байдал, үнэлгээний оноогоор




Энэ бүгдээс нэгтгэн дүгнэвэл Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн үйл ажиллагаанд байгууллагын удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөв санхүүгийн хомсдолтой байдал нь хүндрэл бэрхшээл учруулдаг болох нь судалгааны дүнгээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр үйл ажиллагааг сайжруулах тодорхой бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна. Харин байгууллагын техник, ажлын орчин нөхцөл, байгууллагын соёл болон гадаад орчны нөхцөл байдал харьцангуй сайн байгаа нь тус байгууллагын үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг болдог нь судалгааны үр дүнгээр тодорхойлогдов.

**Зураг 13.** Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн өнөөгийн нөхцөл байдал, дундаж үнэлгээгээр



Түүнчлэн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, төсөв хөрөнгө, албан хаагчдын идэвх санаачилга, хүний нөөцийн чадавх, цалин урамшууллын систем, удирдлага зохион байгуулалт болон бүтцийн оновчтой байдал зэрэг үйл ажиллагаануудыг илүү сайжруулах шаардлага байгаа нь судалгаанд оролцогчдын нэлттэй асуултын хариултаас харагдлаа. Ялангуяа, хүний нөөцийн үйл ажиллагааг сайжруулахад оновчтой бодлого, зохицуулалт хийх, хүний нөөцийн хөтөлбөр боловсруулах, албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хүний нөөцийн сургалт, хөгжил ба ажлын гүйцэтгэлийн уялдааг сайжруулах, цалин урамшууллыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна. Мөн байгууллагын хамт олны дунд хамтач соёлыг төлөвшүүлэх, багаар хамтран ажиллах нэгдмэл уур амьсгалыг бүрдүүлэх нь чухал байна. Үүнээс гадна байгууллагын төсвийн үр ашигтай байдлыг сайжруулах, төсөв боловсруулах үндэслэл шалтгааныг тодорхой гаргах, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсвийн төлөвлөлт болон зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй алхмуудыг шат дараатай хийх нь чухал болжээ. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн найдвартай, баталгаатай байдлыг хангах үүднээс гарсан эвдрэл, гэмтлийг цаг тухайд нь засвар үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэх, үүнд шаардлагатай төсөв, хөрөнгийг төлөвлөх хэрэгцээ мөн байгаа нь судалгааны дүн илтгэж байна.

***Баримт бичгийн судалгааны дүн:*** Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо асуулга судалгаанаас гадна тус төвийн үйл ажиллагаатай холбогдох эрх зүйн болоод бодлогын баримт бичиг, бусад шаардлагатай баримт материалыг судлан үзэж, үр дүнг тодорхойлсон. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/373 дугаар тушаалаар цусны донорыг элсүүлэх, сонгох, цус цуглуулах, шинжлэх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, шинэчлэх журмын дагуу эмнэлгүүдийг мэргэжил арга зүйгээр тогтмол ханган ажиллаж байна. Үйл ажиллагааныхаа үр дүнг дээшлүүлэх, Цусны сэлбэлт судлалын салбарын уялдааг сайжруулахаар ЦССҮТ-ийн бүтэц, дүрэм, Цусны салбар төвийн дүрмийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/445 тоот тушаалаар шинэчлэн батлуулсан.

ЦССҮТ нь бүх үйл ажиллагаандаа Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 олон улсын стандартын шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, хөндлөнгийн байгууллагаар 2020 онд давтан баталгаажуулалт хийлгэн 3 жилээр сунгуулсан бол 2021 онд магадлах аудитад хамрагдан стандартын шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байна гэж дүгнэгдлээ.

Мөн лабораторийн чанар ба чадавхад тавигдах шаардлага MNS ISO 15189:2015 стандартын давтан баталгаажуулалтад амжилттай хамрагдаж, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-шаардлага OHSAS 18001:2012 стандартаас MNS ISO 45001:2018 стандартруу шилжих бэлтгэл ажлыг хангалаа.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2018 оны статистик үзүүлэлтийг харвал дэлхий дахинд 118.5 сая нэгж цус өгөлт бүртгэгдсэн байна. 1000 хүн амд ногдох цус өгөлтийн тоо өндөр орлоготой орнуудад 31.5, дундаас дээгүүр орлоготой орнуудад 15.9, дунд орлоготой орнуудад 6.8, бага орлоготой орнуудад 5.0 тус тус байна. Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээгээр нь авч үзвэл өндөр орлоготой орнуудад нийт үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүний 75 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүн амд хэрэглэгдсэн бол бага орлоготой орнуудад 54 хүртэл хувь нь 0-5 насны хүүхдүүдэд хэрэглэгдсэн байна. Гэхдээ цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээний төрлөөр нь авч үзвэл нийт донорын дунд гепатит В вирусээр хасагдалт хамгийн өндөр хувьтай байна.

Монгол Улсын хэмжээнд нийт цус цуглуулалтын тоо 2017 онд 33704 байсан бол 2021 онд 36888 болж 9.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт цус цуглуулалтын 27264 (73.9%) нь ЦССҮТ-д, 9624 (26.1%) нь Цусны салбар төвүүдэд тус тус цуглуулагдсан байна (Зураг 13). Мөн нийт цус цуглуулалтын 72.4 хувийг цус цуглуулах суурин төвд, 27.6 хувийг хөдөлгөөнт хэлбэрээр цуглуулсан байна.

**Зураг 14.** Нийт цус цуглуулалтын тоо, 2017-2021 он




Улаанбаатар хотод 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо 2019 онд 17.7, 2020 онд 18.3, 2021 онд 17.0 болж өөрчлөгдсөн үзүүлэлттэй байна. Цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ болон хүн амын тооноос шалтгаалан хөдөө орон нутагт 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо сүүлийн жилүүдэд тогтвортой байна (Зураг 14).

**Зураг 15.** 1000 хүн амд ногдох цус цуглуулалтын тоо, 2017-2021 он




Газарзүйн байршлаар нь авч үзвэл 2021 оны байдлаар цус цуглуулалтын тоо Хөвсгөл (1005), Дархан-Уул (900), Баян-Өлгий (655), Дорнод (610) аймгуудад харьцангуй өндөр байсан бол Завхан (236), Говьсүмбэр (217), Говь-Алтай (193) аймгуудад бусад аймгуудын үзүүлэлтээс харьцангуй бага байна.

**Зураг 16.** Хөдөө орон нутагт цус цуглуулалтын тоо, аймгаар (2020 он)




Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд цусны донор хадгалалт, алдаршуулалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлсний үр дүнд нийт доноруудын дунд байнгын донорын эзлэх хувь нэмэгдэж байна. Байнгын доноруудын эзлэх хувь нэмэгдэх нь цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, тасралтгүй нөөц бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Донорын төрлөөр нь авч үзвэл 2017 онд нийт цусны доноруудын дунд байнгын донорын эзлэх хувь 55 байсан бол 2021 онд 67 хувь болж 12 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Зураг 17. Цусны донорын төрөл, 2017-2021 он**




Цус цуглуулалтыг насны бүлгээр нь авч үзвэл 18-24 насныхан 25.5%, 25-44 насныхан 49,7%, 45-с дээш насны донорууд 24%-ийг тус тус эзэлж байна. Нийт цусны доноруудын 53.7 хувийг эрэгтэйчүүд, 46.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ба эмэгтэй доноруудын идэвх өмнө жилээс 0.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Цусаа өгсөн доноруудын сорьцод цус сэлбэлтээр дамжих 4 төрлийн халдвар илрүүлэх шинжилгээг 100 хувь хийдэг бөгөөд цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалтын хувь жил бүр тогтмол буурч

байна. 2017 онд цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалтын хувь 4.9 хувь байсан бол 2021 онд 3.2 хувь болж 1.5 дахин буурсан үзүүлэлттэй байна.

**Зураг 18. Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээгээр хасагдалтын хувь, 2017-2021 он**




ДЭМБ-ын зөвлөмжөөр бага, дунд орлоготой орнуудад нийт хүн амын дунд цусны донорын эзлэх хувь 1.5 байхыг зөвлөдөг. Энэ үзүүлэлт 2021 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 1.7 хувь байгаа нь эмнэлгийн захиалгыг бүрэн хангах боломжийг бүрдүүлж байна.

ЦССҮТ нь 2015 онд 15 нэр төрлийн цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол техник, технологийн шинэчлэлтийг үе шаттайгаар нэвтрүүлсний үр дүнд 2020 онд 34 нэр төрөл, 2021 онд нэмж SARS-COV-2 эсрэг бие агуулсан сийвэн, SARS-COV-2 эсрэг бие агуулсан эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн сийвэн үйлдвэрлэж эхэлснээр цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 36 нэр төрөл болж нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сүүлийн 5 жилийн байдлаар нь авч үзвэл 2017 онд 90503 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 2021 онд 103265 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт үйлдвэрлэл 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Зураг 19.** Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2017-2021 он




Мөн түүнчлэн цус, цусан бүтээгдэхүүнийг рентген туяагаар шарах технологи, улаан эсийг хөлдөөж хадгалах технологи, бүтээгдэхүүний эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлэх технологи зэрэг орчин үеийн шинэ технологийг үйл ажиллагаандаа нутагшуулсантай холбоотойгоор цаашид цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн бүтээгдэхүүн, эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн ялтаст эсийн өтгөрүүлэг, эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн хөлдөөсөн шинэ сийвэнгийн үйлдвэрлэлд эзлэх хувийг нэмэгдүүлэн ажиллахыг зорьж байна.

**Зураг 20.** Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шинэ технологийг нутагшуулах




Үүнээс гадна Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа харьцангуй сайн хөгжсөн байгаа хэдий ч зарим байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний хугацаа дууссан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 3.** Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

| № | Байгууллагын нэр | Хамтын ажиллагааны гэрээ, төслийн нэр | Эхэлсэн он | Дууссан он |
|---|---|---|---|---|
| 1. | БНХАУ-ын Шанхайн Цусны төв | Богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2014 | Үргэлжилж байгаа |
| 2. | Азийн цус сэлбэлтийн холбоо | Эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2014 | Үргэлжилж байгаа |
| 3. | Саудын Араб улсын Цусны төв | Эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2014 | 2014 |
| 4. | Турк улсын Цусны төв | Эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2015 | 2015 |
| 5. | Олон улсын цус сэлбэлтийн нийгэмлэг | Эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2018 | Үргэлжилж байгаа |
| 6. | Япон улсын Улаан загалмайн нийгэмлэг | Богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2018 | Үргэлжилж байгаа |
| 7. | Япон улсын Улаан загалмайн нийгэмлэг | Богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2018 | Үргэлжилж байгаа |
| 8. | ОХУ-ын Улан-Үдэ хотын Цусны банк | Богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2019 | 2019 |
| 9. | Кампучи улсын Цусны төв | Богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2019 | 2019 |
| 10. | Тайланд улс, Бангкок хот | Эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2019 | 2019 |
| 11. | БНСУ-ын Хавдар судлалын төв | Богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2019 | 2019 |
| 12. | Австрали улсын Саншайнь кост их сургууль | Эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2020 | Үргэлжилж байгаа |
| 13. | БНТУ-ын Хамтын ажиллагаа, хөтөлбөр | Төсөл хөтөлбөр | 2009 | Үргэлжилж байгаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зохицуулах агентлаг (ТИКА) | | | |
| 14. | Азийн хөгжлийн банк | Төсөл хөтөлбөр | 2011 | 2016 |
| 15. | Дэлхийн Гемофилийн холбоо | Төсөл хөтөлбөр | 2014 | Үргэлжилж байгаа |
| 16. | Глобаль сан | Төсөл хөтөлбөр | 2003 | 2017 |
| 17. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага | Төсөл хөтөлбөр | 2020 | 2020 |
| 18. | БНХАУ-ын Шанхайн Цусны төв | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2014 | Үргэлжилж байгаа |
| 19. | Азийн цус сэлбэлтийн холбоо | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2014 | Үргэлжилж байгаа |
| 20. | Иран улсын Цусны төв | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2014 | 2014 |
| 21. | Турк улсын Цусны төв | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2015 | 2015 |
| 22. | Олон улсын цус сэлбэлтийн нийгэмлэг | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2018 | Үргэлжилж байгаа |
| 23. | Япон улсын Улаан загалмайн нийгэмлэг | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2018 | Үргэлжилж байгаа |
| 24. | ОХУ-ын Улан-Үдэ хотын Цусны банк | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2019 | 2019 |
| 25. | Кампучи улсын Цусны төв | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2019 | 2019 |
| 26. | Тайланд улс, Бангкок хот | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад | 2019 | 2019 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | | |
| 27. | Австрали улсын Саншайнь их сургууль | Эрдэм шинжилгээ, судалгаа, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | 2020 | Үргэлжилж байгаа |

**Холбогдогч талуудыг тодорхойлох.**

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэв. Тус төвийн үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Цус сэлбэлт судлалын төвийн үйл ажиллагаанд холбогдогч талууд

| № | Холбогдогч талууд | Харилцааны чиглэл |
|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийн яам | Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллээр хангах |
| 2 | Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага | Лавлагаа шинжилгээ хийлгэх, Үндэсний чанарын гадаад үнэлгээнд хамрагдах, -Чанарын гадаад үнэлгээ хамтран зохион байгуулах, Лаборатори хоорондын харьцуулалт, Эмчилгээнд шаардлагатай цус цусан бүтээгдэхүүнээр хангах, Төрөлжсөн мэргэшлийн болон тасралтгүй сургалт зохион байгуулах |
| 3 | Төрийн захиргааны байгууллагууд | Хамтран ажиллах, мэдээлэл солилцох |
| 4 | Монголын Улаан Загалмай Нийгэмлэг | Цусны донорын сургалт сурталчилгааг зохион байгуулах |
| 5 | Монголын донорын холбоо | Цусны донорын сургалт сурталчилгааг зохион байгуулах |
| 6 | Монголын Гемофилийн холбоо | Цус бүлэгнэлтийн эмгэгтэй өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх |
| 7 | Хэвлэл мэдээллийн байгууллага | Хамтран ажиллах, мэдээлэл солилцох |
| 8 | Олон улсын байгууллага | Хамтран ажиллах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 9 | Сургалт, судалгааны байгууллага | Төрөлжсөн мэргэшлийн болон тасралтгүй сургалт зохион байгуулах, цус сэлбэлт судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх |

| | | |
|---|---|---|
| 10 | Иргэд | Хамтран ажиллах, мэдээллээр хангах |
| 11 | Эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч байгууллага | Төвийн үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэх |
| 12 | Интернет, цахим үйлчилгээ, програм хангамжтай холбоотой үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж | Үндсэн үйл ажиллагааны програм хангамжийн хөгжүүлэлт, Интернет үйлчилгээ авах, Фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан Чатбот ашиглан мэдээлэл автоматаар хариу өгөх үйлчилгээ үзүүлэх, Утасны автомат хариулагчийн үйлчилгээ үзүүлэх |
| 13 | Үндэсний дата төв | Үндсэн үйл ажиллагааны програм ажиллуулах вертуал серверээр хангах, үйлчилгээ үзүүлэх |
| 14 | Гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллага, холбоо, төрийн болон төрийн бус байгууллага | цус сэлбэлт судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, сургалт, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, туршлага солилцох |
| 15 | Үндэсний итгэмжлэлийн төв | Холбогдох чиглэлээр итгэмжлэл авах, олгохтой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх |
| 16 | Эрчим хүч, ус хангагч байгууллага | Дулаан, цахилгаан эрчим хүчээр хангах, цэвэр усаар хангах, бохир ус зайлуулах, |
| 17 | Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж | Ариутгал, халдваргүйтгэл, шавжгүйтгэл хийх, ердийн болон аюултай хог хаягдал зайлуулах |
| 18 | Бусад ханган нийлүүлэгч байгууллага | Засвар, тохижилтын материал, үйлчилгээ, донорын хүнс нийлүүлэх |

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2017-2020 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Байгууллагын стратеги | Байгууллагын стратегийн үйл ажиллагаа | Хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хугацаа | | | | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2017 | 2018 | 2019 | 2020 | |
| | СТРАТЕГИ ЗОРИЛГО: Цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж, чанарын удирдлагын тогтолцоо болон хөдөлмөрийн эрүүл мэнд, лабораторийн чанарын шаардлагыг нэвтрүүлэн, тогтвортой хэрэгжүүлэх | | | | | | | | |
| 1. | Зорилт 1. Улсын хэмжээнд Цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | 1. Цусны аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинэчлэн батлагдсан холбогдох хууль, ЭМ-ийн сайд, төвийн захирлын тушаал, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, сурталчлах, санал өгөх | Төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна. | Жил бүрийн төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Хэрэгжилтийн хувь, хийгдсэн ажил | + | + | + | + | 100% |
| 2. | | 2. Захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актанд хэрэгжилтийн үнэлгээ хийх | | Хийгдсэн үнэлгээ, аудитын зөвлөмж, хэрэгжилтийн хувь | | | + | + | 100% |
| 3. | | 3. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх | | Батлагдсан бодлогын баримт бичиг, хэрэгжүүлэх төлөвлөгөө | | + | + | + | 100% |
| 4. | | 4. Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | | Шилэн дансны мэдээлэл, бүрэн, хугацаандаа тавигдсан байна. Худалдан авах ажиллагааны мэдээллүүд нэгдсэн цахим хуудсанд бүрэн тавигдсан байна. | + | + | + | + | 100% |
| 5. | | Цусны албаны бүтэц зохион байгуулалтын шинэчилсэн төлөвлөгөөг боловсруулах | | Төлөвлөгөө боловсруулж ЭМЯ хүргүүлсэн байна | | | | + | 100% |
| 6. | | Орон тооны дотоод аудитор ажиллуулах | | Орон тооны дотоод аудитор ажиллуулсан байна. Ажлын төлөвлөгөө, биелэлт, үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | | + | + | + | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **7.** | | Маркетингийн дунд хугацааны хөтөлбөрийг батлуулан, жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах | | Жил бүрийн маркетингийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж батлуулсан байна. Хэрэгжилтийн хувь | + | + | + | + | **100%** |
| **8.** | | Гамшиг онцгой байдлын үеийн ЦССҮТ-ийн бэлэн байдлын цогц төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах | | Бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна. Хэрэгжилтийн тайлан | | + | + | | **100%** |
| **9.** | | Гамшиг онцгой байдлын үед төв бэлэн байдлаа хангах шаардлагатай эм, цэвэр ус, хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн жагсаалтыг төвийн үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цар хүрээ, хүчин чадалд тохируулан боловсруулж, батлуулах | | Батлагдсан жагсаалт | | + | + | + | **100%** |
| **10.** | | Гамшиг онцгой байдлын үед цус цусны бүрэлдэхүүн хэсгээ хэрхэн бэлэглэх чиглэлээр хүн ам, ард иргэдэд зориулсан гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулах | | Боловсруулсан гарын авлага, зохион байгуулагдсан сургалтын тоо жилд 3-аас доошгүй удаа, хамруулсан хүн, ард иргэдийн тоо | | + | + | + | **100%** |
| **11.** | | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүгийн эрсдэлийн нөөцийн санг төвийн түвшинд бий болгох | | Эрсдлийн нөөцийн санг бүрдүүлсэн байна. | | + | + | + | **50%** |
| **12.** | | Гамшиг онцгой байдлын үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний удирдамж боловсруулах | | Батлагдсан удирдамж | | + | + | + | **90%** |
| **13.** | | Гамшиг онцгой байдлын үед хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр Дүүргийн ОБХ- | | Зохион байгуулагдсан сургалт | | + | + | + | **100%** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэй үзүүлэх сургалт хамтран зохион байгуулах | | | | | | | |
| 14. | | Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, зохицуулах, мэдээлэл дамжуулах системийг боловсруулах | | Мэдээлэл дамжуулсан тоо | | + | + | + | 100% |
| 15. | | Гамшиг онцгой байдлын үед иргэд, гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалтын гарын авлага боловсруулах, МУЗН-ийн дунд шатны хороодтой хамтран сургалт зохион байгуулах | | Боловсруулсан гарын авлага, жилд 1-ээс доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | | + | + | + | 80% |
| 16. | | “Элэг бүтэн монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр оролцох | | Хепатитийн В, С вирүсийн халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуурт үнэлгээ хийсэн байна. | + | | | | 100% |
| 17. | | “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хамаарах чиг үүргийн дагуу оролцох | | Хамаарагдах үйл ажиллагаа хийгдсэн байна. | | + | + | + | 100% |
| 18. | | Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор эмнэлгийн орчныг камержуулах, аюулгүй байдлыг сайжруулах | | Орчны камержуулалтын тоо, байнгын ажиллагааг хангасан байдал | | + | + | + | 100% |
| 19. | | Лабораторийн шинжилгээний чанарын дотоод болон гадаад хяналтыг бэхжүүлэх | | Чанарын гадаад үнэлгээнд шинжилгээний чиглэл тус бүрээр хамрагдсан байх<br><br>Шинжилгээ тус бүрт дотоод хяналтыг хийсэн байх | | + | + | + | 100% |
| 20. | | Хөгжпийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг саадгүй | | Хөгжпийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн тусламж, | | + | + | + | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | авах эмнэлгийн гадаад, дотоод орчин нөхцөлийг бүрдүүлэх | | үйлчилгээг саадгүй авах нөхцөл бүрдсэн байх | | | | | |
| 21. | | Төвийн бүтэц үйл ажиллагааны батлагдсан стандартыг мөрдөх, хэрэгжилтэнд өөрийн үнэлгээ хийх | | Үнэлгээний хийгдсэн байна. Үнэлгээний тайлан | | + | + | + | 100% |
| 22. | | Орон нутаг дахь цусны банкуудыг засварлаж, тоног төхөөрөмжөөр хангасан талаар нэгдсэн тайланг гаргах | | Нэгдсэн тайлан гарсан байна. | | | + | | 100% |
| 23. | | “Шилэн төв” төсөл хэрэгжүүлэх | | “Шилэн төв” төслийн тайлан, хэрэгжилтийн хувь, | + | + | + | | 100% |
| 24. | | Улаанбаатар хотод 2-3 цус цуглуулах төвийг шинээр байгуулах | | Цус цуглуулах 2-3 төв шинээр байгуулагдсан байна. | | + | | + | 0% |
| 25. | | Эрүүл мэндийн байгууллагуудад цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээг хэвшүүлэх | | ЦЦБ-ний зохистой хэрэглээг хэвшүүлэх сургалтын тайлан. | + | + | + | + | 100% |
| 26. | | Цусны доноруудын дунд ховор бүлгийн судалгааг хийж, мэдээллийн санг үүсгэх | | 1. Доноруудын дунд ховор бүлгийн судалгаа хийгдсэн байна.<br>Цахим мэдээллийн санг үүсгэсэн байна. | | | + | + | 100% |
| 27. | | Төвийн халдвар хяналтыг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилт 80-100 хувь байна | + | + | + | + | 100% |
| 28. | | Төвд эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас сэргийлэх, хянах үйл ажиллагааг бэхжүүлэх | | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын бүртгэл, мэдээлсэн тоо | + | + | + | + | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **29.** | | Элэгний В вирүсийн дархлаажуулалтанд төвийн ажиллагсадыг бүрэн хамруулах | | Жил бүр шинээр хамрагдсан ажилтны тоо, Нийт ажиллагсадын хамралтын хувь | + | + | + | + | **100** |
| **30.** | | Хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийн хөтөлбөрийн ангиллыг ЭМҮТ-ны үйл ажиллагааны ангилалтай уялдуулж, өргөжүүлэх | | Эрүүл мэндийн үндэсний тооцооны ангиллын дагуу тооцсон үзүүлэлт /тоогоор/ | | | + | + | **100** |
| **31.** | | Цусны албаны хэмжээнд удирдлага хяналтын "B-SIMS" системийг нэвтрүүлэх, хөгжүүлэх | | Нэвтрүүлсэн шинэ технологи, үр дүн | + | + | + | + | **100%** |
| **32.** | | Эмнэлзүйн тойрон үзлэг, ижил мэргэжилтний үзлэг хяналтын хуудасны ашиглалтын байдалд дэмжлэгт хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулах | | Дэмжлэгт хяналтын үйл ажиллагаа тогтмолжсон бүртгэл, зөвлөмж, үр дүн | + | + | + | + | **100%** |
| **33.** | | Архив, бичиг хэрэг хөтлөлтийг холбогдох дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн сайжруулах | | Жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулсан байна. Хэрэгжилтийн хувь | | | + | + | **100%** |
| **34.** | | Бүх шатны боловсролын хичээлийн хөтөлбөрийн эрүүл мэндийн хичээлийн агуулга, бүтцэд өөрчлөлт оруулах Цусны донор гэж хэн бэ хичээл орох | | Батлагдсан хөтөлбөр, зохион байгуулагдсан сургалтын тоо | | + | + | + | **80%** |
| **35.** | | Иргэд доноруудад сошиал сүлжээгээр амьдралын эрүүл зөв дадлыг хэвшүүлэх мэдээлэл зөвлөгөөг олон талт хэлбэрээр зохион байгуулах | | Фэйсбүүк, твиттер мэдээллийн сайт болон бусад цахим хуудсаар жил бүр 100-аас доошгүй мэдээлэл тавигдсан байна. | | + | + | + | **100%** |
| 36. | СТРАТЕГИ ЗОРИЛТ 2: Төвийн үйл ажиллагаанд чанар болон хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, | Төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологи, чанарын шаардлага хангасныг магадлан итгэмжлүүлэх | Хүрэх үр дүн: Төвийн үйл ажиллагаа олон улсад хүлээн зөвшөөрөгдөнө. | Магадлан итгэмжлэлийн гэрчилгээг сунгуулсан байна. Давтан магадлах үнэлгээнд орж, зөвлөмж хэрэгжүүлсэн байна. | | + | | | **100%** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **37.** | лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах, хөгжүүлэх; | Төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг сунгах | | Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг сунгасан байна. | | | + | | **100%** |
| **38.** | | Төвийн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, чанарын удирдлага, эрсдэлийн удирдлагыг хослуулан хэрэгжүүлэх, хөгжүүлэх | | Батлагдсан чанарын хөгжлийн хөтөлбөр<br><br>Жил бүр чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан | | + | + | + | **95%** |
| **39.** | | Төвийн үйл ажиллагаанд MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлж, хөгжүүлэх | | 2017 онд баталгаажуулалт хийлгэн гэрчилгээ авсан байна. Цаашид жил бүр магадлах аудитад хамрагдсан байна. 2020 онд давтан итгэмжлэлд орж батламжийг сунгуулсан байна. Аудитын тайлан, зөвлөмж хэрэгжүүлсэн тайлан, баталгаажуулалтын гэрчилгээ | + | + | + | + | **100%** |
| **40.** | | ISO 9001: 2015 стандартаар олон улсын баталгаажуулалт хийлгэх, сайжруулах | | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартаар гадаадын байгууллагаар баталгаажуулалт хийлгэсэн байна. Аудитын тайлан, зөвлөмж, гэрчилгээ | | | + | + | **100%** |
| **41.** | | Төвийн чанар болон ХЭМАБ-ын гарын авлага боловсруулж, шинэчлэн | | Шинэчлэн батлагдсан гарын авлага, эмч ажилчдад | + | + | + | + | **100%** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сайжруулах, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах | | зохион байгуулсан сургалтын тоо, тайлан | | | | | |
| 42. | | Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо<br><br>MNS OHSAS 18001:2012 стандартыг нэвтрүүлэх, хөгжүүлэх | | Аудит, баталгаажуулалт хийгдэн баталгаажилтын гэрчилгээ авсан байна. Зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан үр дүнг тооцож ажиллах | | + | + | + | 100% |
| 43. | | Төвийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | | Батлагдсан төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт хувиар | | + | + | + | 100% |
| 44. | | Төвийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | | Төлөвлөгөө гарсан байна. Хэрэгжилтийг жил тутам УЗХ-аар хэлэлцсэн байна | | + | + | + | 100% |
| 45. | | Эрүүл мэндийг дэмжигч байгууллага хөдөлгөөн өрнүүлэх (Ажлын байранд эрүүл хооллох, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих ) | | Зохион байгуулсан ажил, баримтжуулалт | | + | + | + | 100% |
| 46. | | Хөдөлмөрийн чадвар түр алдалт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлтэй холбоотой мэдээллийг бүртгэн, мэдээлэх | | Ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлтэй холбоотой мэдээллийг 100% мэдээлнэ. | | | + | + | 100% |
| 47. | | Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуйн орчинг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг тусгайлан төсөвлөж, зарцуулах | | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br><br>/төсвийн 0,5 хувиас багагүй байх/ | | | + | + | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48. | | Төвийн ажиллагсадыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хяналтанд авах, эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | | Урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | | | + | + | 100% |
| 49. | | Эрүүл мэндийн лаборатори-Чанар ба чадавхид тавих шаардлага MNS ISO 15189:2015 стандартыг хэрэгжүүлэх | | Жил бүр магадлах итгэмжлэлд орж 2020 онд давтан үнэлгээ хийлгэн гэрчилгээг сунгуулсан байна. | + | + | + | + | 100% |
| 50. | | Цусны донорын болон цус цусан бүтээгдэхүүний сонор сэрэмжийн тогтолцоог хэрэгжүүлэх тушаал батлуулж, мөрдөх | | ЭМ-ийн сайдын тушаалаар батлагдсан журмыг танилцуулах сургалт зохион байгуулсан удаа, хамрагдсан хүний тоо, <br><br> ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэлийн бүртгэл, түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний жил бүрийн тайлан, түүнд хийсэн дүн шинжилгээ | + | + | | | 100% |
| 51. | | ЦЦБ үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ыг боловсруулж, нэвтрүүлэх | | Үндэсний стандартын дугаар авсан байна. <br><br> Жил бүр хэрэгжүүлсэн ажлын тайлан бичигдсэн байна. | | | + | + | 20% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **52.** | | Төвийн үйл ажиллагааны алдаа зөрчил үл тохирлыг илрүүлж, засч, сэргийлэх тогтолцоог хэрэгжүүлэх | | Алдаа, зөрчил, үл тохирлыг хэлэлцсэн протокол, шийдвэр, засч, сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, нэгдсэн сан үүсгэх | + | + | + | + | **100%** |
| **53.** | | Төвийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа хэмжих хэрэгсэл бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг мэргэжлийн байгууллагаар шалгалт, тохируулга, баталгаажилт хийлгэх | | Төвийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа бүх тоног төхөөрөмж бүрэн баталгаажуулагдсан байна. Ханган нийлүүлэгчтэй хийсэн гэрээний дагуу баталгаажуулалтын протокол, төвийн тасгуудын хийсэн баталгаажуулалтын протокол | + | + | + | + | **100%** |
| 54. | СТРАТЕГИ ЗОРИЛТ 3: Хүний нөөцийн хөгжлийг хангах, нийгмийн баталгааг сайжруулах; | Төвийн "Хүний нөөцийн хөгжлийг хангах дунд хугацааны хөтөлбөр" батлуулж, хэрэгжүүлэх | Хүрэх үр дүн: Хүний нөөцийн мэдлэг, ур чадвар дээшилж, тогтвор суурьшилтай ажиллах боломж хангагдана. | Дунд хугацааны хөтөлбөр батлагдсан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тухайн жилийн хэрэгжилтийн хувь | | + | + | + | **100%** |
| **55.** | | Ажилтнуудын сургалтын хэрэгцээ болон байгууллагын шаардлагад нийцсэн сургалтыг тогтмол зохион байгуулах (багаар ажиллах, үйлчилгээний соёл, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага г.м) | | Жил бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулсан тоо, сургалтанд хамрагдсан хүний тоо | | | + | + | **100%** |
| **56.** | | Эрүүл мэндийн байгууллагуудын эдийн засагчийг чадавхжуулах | | Зохион байгуулагдсан сургалтын тоо, эдийн засагчийн хамрагдсан удаа | | + | + | + | **100%** |
| **57.** | | Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтанд хамруулах | | Сургалтанд хамрагдсан мэргэжилтний тоо | | + | + | + | **100%** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **58.** | | Төвийн хүний нөөцийн мэдээллийн сангийн цахим программтай болох, /судалгаа мэдээлэл цуглуулах/ | | Хүний нөөцийн мэдээллийн цахим программтай болсон байна. | | | + | + | **100%** |
| **59.** | | ЖАЙКА байгууллагатай хамтарсан “Анхан ба лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөлд хамрагдах | | Жил бүр хамрагдсан үйл ажиллагааны тайлан | | + | + | + | **100%** |
| **60.** | | Төвийн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжилтийг хангах | | Шинэчлэн боловсрогдсон журам, жил бүрийн сургалтын үйл ажиллагааны тайлан | + | + | + | + | **100%** |
| **61.** | | “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын индекс”-ийн дагуу төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг үе шаттайгаар шинээр болон шинэчлэн боловсруулах | | Шинэчлэн боловсрогдсон сургалтын хөтөлбөрийн тоо | | | + | + | **100%** |
| **62.** | | Төвийг эмнэлзүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх эмнэлгийг сүлжээний тогтолцоонд хамруулах | | Эмнэлзүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх сүлжээ бүхий сургалт эрхлэх байгууллага болсон байх | | | + | + | **100%** |
| **63.** | | Эмнэлзүйн сургалт удирдах эмч-багш бэлтгэх тогтолцоонд нэгдэх, хамрагдах Эмнэлзүйн сургалт удирдах эмч-багш бэлтгэх тогтолцоонд нэгдэх, хамрагдах | | Бэлтгэгдсэн эмч багшийн тоо | | | + | + | **100%** |
| **64.** | | Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг боловсруулах, үнэлэх чиглэлээр сургалтад хамрагдах | | Жилд 2-оос доошгүй сургалтад хамрагдсан байна | | | + | + | **100%** |
| **65.** | | Батлагдсан тэргүүлэх чиглэл, төлөвлөгөөний дагуу гадаадын өндөр хөгжилтэй улс, оронд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг үе шаттайгаар сургах | | Тухайн жилд төлөвлөгдсөн мэргэжилтний хуваарь, сургагдсан эмч, мэргэжилтэн | | | + | + | **100%** |
| **66.** | | Сургалтын орчин, техникийг шинэчлэх | | Цахим сургалтын програм хангамж, техник технологи, суралцах орчин нөхцөл, тавилга хэрэгсэл бүрдсэн байна. | + | + | + | + | **100%** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 67. | | Төвийн ажиллагсадын нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлэх | | Хөтөлбөр батлагдсан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тухайн жилийн хэрэгжилтийн хувь | + | + | + | + | 100% |
| 68. | | Харилцаа, хандлагын зөрчил гаргаагүй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг жил бүрийн эцэст урамшуулах, дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах | | Зохион байгуулагдсан арга хэмжээ 2-оос доошгүй (төрөл тоогоор) | | | + | + | 100% |
| 69. | | Төвийн ажилтны мэргэшил, ур чадвар, ажлын ачаалал, үр дүнтэй нь уялдуулан урамшуулдаг болгох / 1000 онооны системийг нэвтрүүлэх, хөгжүүлэх | | Батлагдсан журам | | | + | + | 0% |
| 70. | | Батлагдсан эрх зүйн баримтын дагуу төвийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсний журмыг боловсруулан батлуулах , хэрэгжүүлэх | | Батлагдсан эрх зүйн баримт бичиг | | + | + | + | 100% |
| 71. | | Төвийн эрүүл мэндийн ажилтны шинэ урамшууллыг бий болгох | | Батлагдсан журам | | | | + | 100% |
| 72. | | Эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын ерөнхий загвар боловсруулах зааврыг боловсруулж батлахад санал өгөх | | Төвийн өгсөн санал, Батлагдсан заавар | | | | + | 100% |
| 73. | | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг дэмжих сарын аяныг зохион байгуулж хэвших | | Жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна. | + | + | + | + | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **74.** | | Байгууллагын “Сайн санал, шинэ санаа”-ны тогтолцоог хөгжүүлэх, 5с Кайзен системийг хэрэгжүүлэх | | Саналын бүртгэлийн систем, сайжруулсан ажлын тоо, хувь | | | + | + | **100%** |
| **75.** | | Гадаад дотоод ногоон эко орчин бүрдүүлэх | | Зохион байгуулсан ажлын тайлан, баримтжуулалт | + | + | + | + | **100%** |
| **76.** | | Гемофилия өвчний оношлогоонд дэвшилтэт шинэ технологи, арга зүйг нэвтрүүлж, оношлогоог сайжруулах зорилгоор эмнэлгийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй оронд сургах, гадаадаас эмнэлгийн мэргэжилтнийг богино хугацаагаар ажиллуулах | | Нэвтрүүлсэн шинэ технологи, шинжилгээний үзүүлэлт, Сургалтанд хамрагдсан хүн тоо Богино хугацаагаар рж ажилласан гадаад мэргэжилтний тоо | | + | + | + | **100%** |
| **77.** | | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороог шинэчлэн зохион байгуулах | | Шинэчлэн зохион байгуулагдсан ёс зүйн хороо | | | | + | **100%** |
| **78.** | | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн боловсруулж, ёс зүйн зөрчлийг бүртгэх мэдээний сангийн аюулгүй байдлыг хангах | | Шинэчлэн батлагдсан ёс зүйн хэм хэмжээ | | + | + | + | **100%** |
| **79.** | | Ёс зүйн эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, эрүүл мэндийн байгууллагад ажиллуулах | | Ёс зүйн эвлэрүүлэн зуучлагчийг орон тоогоор болон гэрээгээр ажиллуулсан байна. | | + | + | + | **100%** |
| **80.** | | Сувилахуйн тусламж, үйлчилгээний чиглэлээр 2018-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | | Жил бүр албаны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн ажлын тайлан, хэрэгжилтийн хувь | | + | + | + | **100%** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 81. | СТРАТЕГИ ЗОРИЛТ 4: Цус сэлбэлтийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, шинэ мэдлэг, дэвшилтэт техник технологи, инновацийг нэвтрүүлэх; | Азийн цус сэлбэлтийн холбооны 2019 оны 15 дугаар конгрессыг хариуцан зохион байгуулах | Хүрэх үр дүн: Шинэ технологи нутагшиж, шинэ бүтээгдэхүүний хэрэглээ хэвшинэ. | Зохион байгуулагдсан хурлын тайлан | | + | + | | 100% |
| 82. | | Эрдэм шинжилгээ, судалгааны нээлттэй, өрсөлдөөнт, орчинг бүрдүүлэх | | Хэрэглээний судалгаанд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг нэвтрүүлсэн байх, өрсөлдөөнд тулгуурласан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлсэн байна. | | + | + | + | 100% |
| 83. | | Эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийн дагуу шинжлэх ухаан, технологийн төслийн санал боловсруулах, хэрэгжүүлэх | | Боловсруулсан төслийн санал | + | + | + | + | 100% |
| 84. | | Технологи дамжуулалтыг дэмжих, шинэ санаа-инновацийг нэвтрүүлэн нутагшуулах | | Судалгааны ажлын үр дүнг үнэлэх арга зүй шинэчлэгдэж, эрдэмтэдийн зөвлөлөөр хэлэлцсэн байх, олон улсын хамтарсан судалгааны ажил хэрэгжүүлсэн байна. Инновацийн 2-оос доошгүй төсөл боловсруулсан байх. Шинэ инноваци нутагшуулах төсөл хэрэгжүүлсэн байх | | + | + | + | 100% |
| 85. | | Төвийн мэдээллийн технологийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх | | Батлагдсан хөгжлийн хөтөлбөр, жил бүрийн батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь | | + | + | + | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **86.** | | Эрүүл мэндийн технологийн чиглэлээр нэгдсэн мэдээллийн санд нэгдэх, тогтмол мэдээллээр хангах | | Үйл ажиллагаа нь тогтмолжсон мэдээний санг үүсгэсэн байна | | + | + | + | **100%** |
| **87.** | | Төвийн эрдэм шинжилгээ судалгааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тогтоох | | Тэргүүлэх чиглэл батлагдсан байна. | | + | + | + | **100%** |
| **88.** | | Төвийн эрдэм шинжилгээ судалгааны ажлын мэдээний сантай болох | | Мэдээний сангийн тоо | + | + | + | + | **100%** |
| **89.** | | Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх | | Хамтын ажиллагаа тогтоосон хэлэлцээрийн бичиг, хэрэгжүүлэх үйл ажиллагааны баримт бичиг | + | + | + | + | **100%** |
| **90.** | | Дотоод хамтын ажиллагаа, салбар хоорондын харилцааг хөгжүүлэх | | Дотоод хамтын ажиллагаа, салбар хоорондын хэлэлцээрийн бичиг баримт, холбогдох баримтжуулалт | | + | + | + | **100%** |
| **91.** | | Монголд шинээр нэвтрүүлж буй оношилгоо, эмчилгээний шинэ технологийн талаар гадаад дотоодын эх үүсвэрээс мэдээлэл авах, өндөр хөгжилтэй орноос мэргэжилтэн урьж ажиллуулах | | Мэдээлэлд хамрагдсан болон уригдаж ажилласан мэргэжилтний тоо, үр дүн | + | + | + | + | **100%** |
| **92.** | | Цус, цусны бүрэлдэхүүн хэсгүүдийг ялган цуглуулахад эдийн засгийн үр ашигтай, нэн шаардлагатай дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх, нутагшуулах | | Нэвтрүүлсэн шинэ технологи, үйлдвэрлэж борлуулсан бүтээгдэхүүн, үр дүн | + | + | + | + | **100%** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **93.** | | ЦЦБ-ний үйлдвэрлэл хадгалалтад эдийн засгийн үр ашигтай, нэн шаардлагатай дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх, нутагшуулах | | Нэвтрүүлсэн шинэ технологи, үйлдвэрлэж борлуулсан бүтээгдэхүүн, үр дүн | + | + | + | + | **100%** |
| **94.** | | Лабораторийн шинжилгээнд эдийн засгийн үр ашигтай, нэн шаардлагатай дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх, нутагшуулах | | Нэвтрүүлсэн шинэ технологи, үр дүн | | | + | + | **100%** |
| **95.** | | Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжийн байдалд үнэлгээ хийж, хөрөнгө төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх судалгаа хийх | | Судалгааны тайлан зөвлөмж | | | + | + | **20%** |
| **96.** | | Цусны албаны Засвар үйлчилгээ удирдлагын системд эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, бүртгэлийг нэгдсэн нэршилд оруулах, хөгжүүлэх | | Нэвтэрсэн цахим программ | | + | + | + | **100%** |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 1.5. Улсын нөөцийн тухай хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, стратегийн болон гамшгийн нөөцийн бараа, материалыг улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагчийн агуулахад технологийн горимын дагуу хадгалах | | | | | | | |
| **Зорилт 1.5.1.** Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн ЦЦБ-ий нөөц хангамж, бэлэн байдлыг хангана. | | | | | | | |
| 27. | Цус, цусан бүтээгдэхүүний Улсын нөөцийн хадгалалтын аюулгүй байдлыг хангаж, нөхөн сэлгэлтийг хийнэ. | - | ОБЕГ-тай хийгдсэн гэрээ, ажлын тайлан | Гэрээг дүгнэж, улсын нөөцөд бараа, материал худалдан авах нэмэлт гэрээ байгуулсан. | Гэрээний үүргийг хэрэгжүүлж, шаардлагатай бүтээгдэхүүний нөхөн сэлгэлтийг бүрэн хийж, нөөцийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | ОБЕГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газартай 2012 оноос хийсэн (маш нууц) гэрээг тухай бүр шинэчлэн хэрэгжилтийг ханган ажилласан. Улсын нөөцийн хөлдөөсөн шинэ сийвэнгийн нөхөн хангалтыг 3, 4, 10, 11 сард хийж, Улсын нөөцийн цус цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж ажилласан. Төвийн нөөцийн ХШС, КС-ийн нөхөн хангалтыг сар бүр хийсэн. Цус цусан бүтээгдэхүүний хадгалалтад тогтмол хяналт тавьж ажилладаг. ОБЕГ-тай гэрээг сунгаж баталгаажуулсан. | 100% |
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ **2.** Тусламж үйлчилгээний чанар, цусны аюулгүй байдлыг хангаж, Чанарын болон ХЭМАБ-ын менежментийг тогтвортой хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах | | | | | | | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2.1. Үндэсний хэмжээнд цусны сонор сэрэмжийн тогтолцоог хөгжүүлж, цусны аюулгүй байдалтай холбоотой баримт бичгийг шинэчлэх | | | | | | | |
| **Зорилт 2.1.1.** Цусны сонор сэрэмжийн тогтолцооны бүртгэл мэдээллийг баяжуулж, дэмжлэгт хяналт үнэлгээ, мэргэжил арга зүйгээр хангана. | | | | | | | |
| 28. | ДЭМБ-ын стратегийн зорилтыг хэрэгжүүлж, цус, цусан бүтээгдэхүүний урвал хүндрэлтэй холбоотой бүртгэл мэдээллийг баяжуулж дүн шинжилгээ хийнэ. | - | Бүртгэл мэдээлэл, дүн шинжилгээ хийсэн тайлан | 2020-2022 оны ДЭМБ-ын стратегийг мөрдөж, Эрүүл мэндийн байгууллагуудын цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн тайланг нэгтгэсэн. | Эрүүл мэндийн байгууллагуудын цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн тайланд дүн шинжилгээ хийж мэдээллийн сан үүсгэсэн байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийн бүртгэл мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр үүсгэн цахим мэдээний санг урвал хүндрэл илэрсэн өвчтөн болон сэлбэсэн бүтээгдэхүүний мэдээллийг агуулсан байдлаар Excel хэлбэрээр бүртгэн хадгалж байна. 2024 онд цус сэлбэлттэй холбоотой 10 урвал, хүндрэл бүртгэгдэж мэдээний санд хадгалагдсан. Бүтээгдэхүүн захиалга болон олголтын bp.mohs.mn программд ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэл илэрсэн үед мэдээлэх 3 маягтыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр оруулан туршилтын шатанд явагдаж байна. Үүний үр дүнд цус цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагууд урвал хүндрэлийг энэхүү программаар мэдээлэх, төвийн хэмжээнд мэдээллийн нэгдсэн сан үүсэх нөхцөл бүрдэж байгаагаар давуу талтай юм. | |
| 29. | Цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээний заавар шинэчлэн батлуулна. | - | Шинэчлэн батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/03 дугаар тушаалыг мөрдөж ажилладаг. | Тушаал шинэчлэх санал, тушаалын төслийг шинэчлэн боловсруулж ЭМЯ-д хүргүүлсэн байна | “Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар”, Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал гарч, ажлын хэсгийн хурлыг 2 удаа хийж, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэсэн тушаалын төсөл, танилцуулга, саналын товьёог зэргийг нэгтгэн Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт хүргүүлсэн. | 100% |
| 30. | Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх журмыг шинэчлэн батлуулах | - | Шинэчлэн батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/506 дугаар тушаалыг мөрдөж ажилладаг. | Тушаал шинэчлэх санал, тушаалын төслийг шинэчлэн боловсруулж ЭМЯ-д хүргүүлсэн байна | Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177 дугаар тушаал гарч, ажлын хэсгийн хурлыг 2 удаа хийж, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэсэн тушаалын төсөл, танилцуулга, саналын товьёог зэргийг нэгтгэж байна. | 70% |
| 31. | Цусны салбар төвүүд болон гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад цусны аюулгүй байдлын дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангана. | 5.4<br>Улсын төсөв | Дэмжлэгт хяналт үнэлгээний тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | 2023 онд 3 гэрээт Эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан. | Цусны салбар төв болон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд цахим болон ажлын байран дээрх дэмжлэгт хяналт үнэлгээг тус бүр 3-оос доошгүй удаа хийж, мэргэжил арга зүйгээр хангасан байна. | Цусны аюулгүй байдалтай холбоотой Эрүүл мэндийн сайдын тушаалуудын хэрэгжилтийг сайжруулах,, ЭМС-ын 2018 оны А/506 дугаар тушаалыг шинэчлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, эмнэлзүйн зохистой хэрэглээ, зөв дадлыг хэвшүүлэхэд дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжин туслах зорилгоор Төвийн Ерөнхий захирлын баталсан удирдамжийн дагуу 2024 онд нийт 18 Цусны салбар төв болон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд цахим болон ажлын байран дээрх дэмжлэгт хяналт үнэлгээ хийж мэргэжил аргазүйгээр ханган, зөвлөмж хүргүүлэн ажилласан байна. Үүнд: Цахим дэмжлэгт үнэлгээнд: Дархан-Уул, Дундговь, Завхан аймгийн Тосонцэнгэл, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өмнөговь, Сэлэнгэ, Сэлэнгэ аймгийн Мандал, Булган, Дорнод, Баянхонгор, Төв, Хэнтий, Архангай, Завхан, Баян-Өлгий аймгийн цусны салбар төвүүд. Ажлын байран дээрх дэмжлэгт үнэлгээнд: Орхон ЦСТ, Говьсүмбэр ЦСТ, ХУДНЭ тус тус хамрагдсан. 2024 онд дэмжлэгт хяналт үнэлгээг цахим хэлбэрээр хийснээр үйл ажиллагааны чиглэл бүрээр мэргэжил аргазүйн зөвлөгөөг тус төвийн эмч, мэргэжилтнүүдээс шууд авах, бусдаасаа туршлага судлах нөхцөлийг бүрдүүлэх болон цаг хугацаа, зардал хэмнэсэн онцлог, давуу талтай байлаа. Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран НЭМГ-ын харьяа 14 эрүүл мэндийн байгууллагуудын цусны аюулгүй байдалд дэмжлэгт үнэлгээ хийж мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлсэн. | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2.2. Лавлагаа шатны тусламж үйлчилгээг үзүүлж мэргэжил арга зүйгээр хангах | | | | | | | |
| **Зорилт 2.2.1. Л**авлагаа шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн шаардлагад нийцүүлэн өндөр түвшинд үзүүлнэ. | | | | | | | |
| 31. | Цус сэлбэлт судлалын чиглэлээр иммуно-гематологийн лавлагаа шинжилгээг хийх | 132.2 Улсын төсөв | Лавлагаа шинжилгээ- ний нэр, төрөл, тоо, тохирлын хувь. | Хувийн тохироо, эргэлзээтэй бүлэг тодорхойлох, кумбсын шууд ба шууд бус урвал, эсрэг бие илрүүлэх, дүйн тодорхойлох, резус сөрөг баталгаажуулах, анти-Д титр тодорхойлох, резусийн дэд бүлэг тодорхойлох 7 нэр төрлийн шинжилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр хийсэн. | Хувийн тохироо тодорхойлох, эргэлзээтэй бүлэг тодорхойлох, кумбсын шууд ба шууд бус урвал, эсрэг бие илрүүлэх, дүйн тодорхойлох, резус сөрөг баталгаажуулах, анти-Д титр тодорхойлох, резусийн дэд бүлэг тодорхойлох 7 нэр төрлийн шинжилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр хийсэн. | Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу:<br>Хувийн тохироо-174<br>Элэг шилжүүлэн суулгах үеийн тохироо-470<br>Анти-Д титр-196<br>Кумбсын шууд ба шууд бус урвал-182<br>Д сөрөг баталгаажуулах-40<br>Резусын дэд бүлэг-50<br>Эсрэгбие илрүүлэх, дүйн тодорхойлох-57<br>Эргэлзээтэй бүлэг-6<br>АВО бүлэг-1279 тус тус хийж хариуг олгосон. | 100% |
| 32. | Цусны бүлэг, хувийн тохирооны Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | 5.6 Улсын төсөв | Үнэлгээнд оролцсон лабораторийн тоо, тайлан, сургалтад | 2023 оны 6, 11 дүгээр саруудад 2 удаа зохион байгуулж нийт 202 лабораторийг хамруулсан. | 21, 22 дахь удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, 20, 21 дэх удаагийн үнэлгээний тайлан семинарыг | -2024.02.22-нд 20 дах удаагийн гадаад үнэлгээний тайлан семинарыг зохион байгуулж нийт 103 лабораторид гэрчилгээ олгосон. Амжилтгүй оролцсон 2 байгууллагад албан бичиг хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамруулсан байгууллагын тоо | | зохион байгуулсан байна. хангалтгүй үр дүнтэй оролцсон лабораториудыг сургалтад хамруулсан байна. | -2024 оын 5 сарын 22-нд 21 дэх удаагийн гадаад үнэлгээг зохион байгуулж 103 лабораторийг хамруулаад байна. 2024.09.26-нд 21 дахь удаагийн цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох шинжилгээний тайлан семинарыг зохион байгуулж, оролцогч лабораториудад мэдээллийг хүргэсэн.<br>АВО бүлэг тодорхойлох шинжилгээг 100 (94,3%) лаборатори хангалттай хийж хариуг ирүүлж, 6 (5,7%) лаборатори хангалтгүй хариу ирүүлсэн. ·Резус бүлэг-100% зөв хийсэн.<br>ЧГҮ-ний хөтөлбөрт хамрагдсан нийт лабораторийн 65 (61.3%) нь хувийн тохироо тодорхойлох шинжилгээний хариу ирүүлсэн.<br>Зөв хариу илгээсэн: 40 (61.5%)<br>Буруу хариу илгээсэн:25 (38.5)<br>Хангалтгүй үр дүн үзүүлсэн лабораториудад зөвлөмж хүргэсэн.<br>22 дахь удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг 2024.12.03-ний өдөр зохион байгуулж, 105 лабораторид сорьцыг тараагаад байна. Шинжилгээний үр дүнг хүлээн авах сүүлчийн хугацаа 12 сарын 10. | |
| 33. | Цусны бүлэгнэлтийн шинжилгээний Үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | 8.0<br>Улсын төсөв<br>Ханган нийлүүлэгч байгууллага | Үнэлгээнд оролцож гэрчилгээ авсан лабораторийн тоо, хангалтгүй үр дүнтэй оролцсон лабораториудад хүргүүлсэн зөвлөмж | 2023 онд 6, 11 дүгээр сард 2 удаа зохион байгуулж, 80%-иас дээш үнэлгээтэй оролцсон лабораториудад гэрчилгээ олгосон. | 6, 7 дах удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулж, 5, 6 дах удаагийн үнэлгээний тайлан, семинарыг зохион байгуулж, амжилттай оролцсон лабораториудад гэрчилгээ, хангалтгүй үр дүнтэй оролцсон лабораториудад зөвлөмж хүргүүлсэн байна. | 2024.02.22-нд 5 дах удаагийн тайлан семинарыг зохион байгуулж 80%-с дээш үнэлгээтэй 92 лабораторид гэрчилгээг олгосон.<br>-2024.06.18-нд 6 дахь удаагийн бүлэгнэлтийн шинжилгээний үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулсан.<br>-2024.09.26-нд 6 дахь удаагийн бүлэгнэлтийн шинжилгээний тайлан семинарыг зохион байгуулж, оролцогч лабораториудад мэдээллийг хүргэсэн. Нийт 99 лаборатори оролцсоноос 80%-с дээш үнэлгээтэй 91(92%), 80%-с доош үнэлгээтэй 8(8%) тус тус байсан. Амжилтгүй оролцсон 8 лабораторид зөвлөмжийг хүргүүлсэн.<br>-7 дах удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг 2024 оны 12 сарын 3-нд зохион байгуулж, 99 лабораторид сорьцыг тараагаад байна. | 100% |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 2.3. Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй стандартын хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангах, сайжруулах | | | | | | | |
| **Зорилт 2.3.1. О**лон улсын болон үндэсний стандартын шаардлагыг тогтвортой хангаж, тасралтгүй сайжруулна. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 34. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2018-2022 оны Чанарын хөгжлийн хөтөлбөрийг 95 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, 2023 онд төлөвлөсөн ажлын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө /2023-2025/-г нийт 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн. Үүнээс 2023 онд 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 19 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, төлөвлөгөөний биелэлт 90 хувь. | 90% |
| 35. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологи, чанарын шаардлагын магадлан итгэмжлэлд хамрагдана. | 1.0<br>Улсын төсөв | Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ | 2018 онд магадлан итгэмжлэлд хамрагдаж 5 жилээр итгэмжлэгдсэн. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологи, чанарыг шаардлагын магадлан итгэмжлэлд хамрагдаж гэрчилгээг сунгасан байна. | 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 5 хүний бүрэлдэхүүнтэй Магадлан итгэмжлэлийн шинжээч нар ажиллаж, магадлан итгэмжлэлийн хугацааг 3 жилээр сунгуулсан.<br>Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын өөрийн үнэлгээ хийж, цаашид сайжруулах 5 чиглэлийн хүрээнд 12 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжилтийг 94,1%-ийн биелэлттэй ханган ажиллаж байна.<br>Үүнд:<br>1. Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага<br>MNS 7014:2023 стандартыг танилцуулах ажлын байран дахь сургалт болон нийт ажилдагсдад чиглэсэн бүлгийн сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 121 ажилтан хамрагдсан байна.<br>2. Үйлчилгээний стандартын эрүүл мэндийн<br>ажилтанд тахигдах шаардлага, үйлчлүүлэгчийн харилцааны ерөнхий шаардлага-ыг сайжруулах хүрээнд байгууллагын Соёл хамтач ажиллагааны баг, Төвийн ёс зүйн салбар хороотой хамтран “Сэтгэлээ жолоодож хүндлэлийг түгээе” сарын аяныг зохион байгуулж хэрэгжилт 90%-ийн биелэлтэй байна.<br>3. Төвийн ажиллагсдын эрхэмлэн ажиллах зарчим<br>шинээр батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>4. Хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах заавар шинээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулан ажиллаж байна.<br>5. “Хувь хүний соёл, инээмсэглэл” сэдвээр сургалт<br>хийж нийт 40(61%) ажилтан хамрагдсан.<br>6. Зөөлөн ур чадварын сургагч багшийн сургалтад<br>3 ажилтан хамрагдаж байна.<br>7. Төвийн ажлын байран дахь хувцаслалтын<br>журамд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталж ажиллагсад мөрдөн ажиллаж байна.<br>8. Тусгай хэрэгцээтэй, хөгжлийн бэрхшээлтэй<br>үйлчлүүлэгчид зориулсан гадна талын шат, налуу замыг стандартын дагуу шинэчлэн засварласан.<br>9. Төвийн 1 болон 2 давхарт бүрэн засвар хийж<br>дуугүй хөтчийг шинэчлэн байрлуулж, ажиллагсад үйлчлүүлэгчдэд аюулгүй, таатай орчинг бүрдүүлсэн.<br>10. Төвийн гадна талын хаягжилтыг орох гарах<br>гарц заасан мэдээлэл бүхий болгон шинэчлэж, гэрэлт самбар хэлбэрээр төвийн 1, 2-р байрны гадна талд болон УХТЭ-ийн эмнэлгийн төв хаалганы хэсэгт байрлуулан хаягжилтын ил тод, ойлгомжтой байдлыг сайжруулсан.<br>Эдгээр ажлыг хэрэгжүүлсний үр дүнд 2024 оны эхний 04 сарын байдлаарх донор, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлтийг 11 сарын байдлаарх дүгнэлтийг харьцуулахад 6.8%-иар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж өссөн үзүүлэлтэй байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36. | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх | | Аудитын тайлан, зөвлөмж | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлж, 2022 онд магадлах аудитад амжилттай хамрагдсан. | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын батал-гаажуулах аудитад хамрагдсан байна | Тус төв нь 2016 оноос эхлэн Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 болон Хөдөлмөрийн Эрүүл мэнд аюулгүй байдлын ISO 45001:2018 менежментийн тогтолцооны стандартыг тогтвортой хэрэгжүүлэн, тасралтгүй сайжруулж ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын 12,13-ны өдрүүдэд Монсертф ХХК-ий магадлах аудитад амжилттай хамрагдаж, гэрчилгээг үргэлжлүүлэн эзэмших шаардлага бүрэн хангасныг тодорхойлуулсан.<br>Мөн орон нутгийн цусны салбар төвүүдийн үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэхэд тасралтгүй дэмжин тусалж, мэргэжил аргазүйгээр хангаж ажилладаг бөгөөд 2024 оны 10 сард Дундговь аймгийн ЦСТ Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын анхдагч баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдаж гэрчилгээгээ гардан авсан нь орон нутгийн ЦСТ-ийн анхдагч болсон амжилттай байна. | 100% |
| 37 | ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх | | Аудитын тайлан, зөвлөмж | 2022 онд ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын баталгаажуулах аудитад амжилттай хамрагдсан. | Жил бүр ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандартын магадлах аудитад хамрагдаж, ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог тогтвортой хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулсан байна. | | |
| 38 | Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015 стандартыг хэрэгжүүлэх | | Аудитын тайлан, зөвлөмж | 2022 онд Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015 стандартын баталгаажуулах аудитад амжилттай хамрагдсан. | 2023 онд Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015 стандартыг тогтвортой хэрэгжүүлж, баримт бичгийн шинэчлэл хийсэн байна. | 2024 оны 11 сард дотоод аудит хийгдэж сайжруулах санал ирснийг 3 сарын дотор залруулахаар төлөвлөсөн.<br>САЗ-3, АЗ-4 тус тус шинээр боловсруулж батлуулан мөрдөж эхэлсэн. 2024.8 сард 3 болон 4-р шатны баримт бичгийн үнэлгээг хийж, засаж сайжруулах арга хэмжээ авсан.<br>2024.04.27-нд Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний дэлхийн 7 хоногийг тохиолдуулан MNS ISO 15189:2015-ийг нэвтрүүлсэн сайн туршлага солилцох өдөрлөгийг зохион байгуулж улсын болон хувийн хэвшлийн 85 лабораторийн эмч, мэргэжилтнийг хамруулсан. Өдөрлөгийн хүрээнд:<br>● Лабораторийн үйл ажиллагааны талаар Reel бэлтгэж танилцуулах,<br>● Эрүүл мэндийн лаборатори Чанар ба чадавхад тавих шаардлага MNS ISO 15189:2015 стандартын хэрэгжилт, сайн туршлагын танилцуулга хийх, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ● MNS ISO 15189:2015 стандартын хүрээнд хөтлөгдөж буй баримт бичгийг танилцуулах,<br>● Лабораторийн үйл ажиллагаатай танилцах тур хийх зэрэг үйл ажиллагааг төлөвлөн амжилттай зохион байгуулсан. | |
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ 3. Хүний нөөцийн хөгжлийг хангах, мэдээллийн технологи, сургалт, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэн, инноваци нэвтрүүлэх | | | | | | | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3.1. Хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажлуулах, хөгжүүлэх | | | | | | | |
| **Зорилт 3.1.1. Т**өрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангана. | | | | | | | |
| 39. | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангана. | 1228.0 Улсын төсөв | Шинэчлэн батлагдсан хөтөлбөр, баталсан тушаал | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2021-2025)-ийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | ЦССҮТ-ийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2021-2025)-ийг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Төвийн төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр (2024-2026)-ийг шинэчлэн батлуулж 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Үүнд:<br>- 2024 онд ЭМЯ, ЭМХТ болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинар, зөвлөгөөнд мэргэжлийн дагуу давхардсан тоогоор нийт ажиллагсдын 78 хувь хамрагдсан.<br>- 2 эмч магистрт сурч байгаа бөгөөд мэргэшлийн "Ахлах", Зөвлөх" зэргийг 2 ажилтан хамгаалсан.<br>- МУ-ын ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу ур чадварын нэмэгдлийг 25 хүртэлх хувиар 11 удаа, 2019 оны 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг улирал бүр 60 хүртэл хувиар урамшуулалт цалин олгосон.<br>- Эрүүл мэндийн яамны харьяа тусгай мэргэжлийн төвүүдийн дунд зохиогдсон спортын 5 төрөлт тэмцээнд байгууллагаараа оролцож 2-р байр эзэлсэн. Хамт олны дунд волейболын нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, эрүүл мэнд, хамтын нөхөрлөлийг бүрдүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Нийт ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгт эрт илрүүлэгийн насны ангиллаар 18-30 нас, 31-45 нас, 46-60 насны багц шинжилгээнд хамруулж 45-с дээш болон доош насны бүлэгт хувааж эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, андрологи, урологийн эмчийн үзлэгт нийт 68 ажилтныг /97,1 хувь/ хамруулсан.<br>- Ажилтны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг дэмжиж УХТЭ-ийн цэцэрлэгт тодорхой тооны хүүхдийг хамруулсан. Мөн төвд хүүхдийн өрөө байгуулан, 10 гаруй сая төгрөгөөр тохижуулж ажилтны ажлаа амар тайван хийх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>- БЗД-ийн ИТХ-ын ажлын албатай хамтран ажиллаж цусны донорын үйлсийг сурталчлан анх удаа Баянзүрх дүүрэг цусны донор дүүрэг болсон бөгөөд төвийн 10 ажилтанд газар эзэмших эрхийн бичиг олгосон.<br>- ЭМЯ-ны гэрээний хүрээнд ХХБ-тай гэрээ байгуулан нийт ажилтны 50 гаруй хувь нь ипотек, цалингийн зээлийн бага хүүтэй, түргэн шуурхай үйлчилгээ авч байна. | |
| 40. | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах замаар тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | - | Нийт ажилчдад 3-аас дээш жил ажилласан ажилчдын эзлэх хувь | 2022 онд нийт ажилчдын тоонд 3-аас дээш жил тогтвортой ажилласан ажилчдын эзлэх хувь 55 байна. | Нийт ажилчдын тоонд 3-аас дээш жил тогтвортой ажилласан ажилчдын эзлэх хувь суурь түвшинөөс буураагүй байна. | 2024 оны хүний нөөцийн хөдөлгөөн 18 хувьтай, нөхөн хангалт 90 хувьтай байна. Нийт ажилчдын тоонд 3-аас дээш жил тогтвортой ажилласан ажилчдын эзлэх хувь 83 байна. | 100% |
| 41. | Төсвийн орлогын давсан хэсгээс олгох урамшууллын 60-аас доошгүй хувийг ажилтнуудын нийгмийн асуудал шийдвэрлэхэд зориулах | | Урамшуулалд зарцуулсан хэмжээ, хувь | 2021 онд 57 хувийг зарцуулсан байна. | 60-аас доошгүй хувийг зарцуулж, Цусны донорын тухай хуулийн төсөлд ажилтны нийгмийн хамгаалалтай холбоотой заалтыг тусгасан байна. | Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 224 дугаар тушаалаар 856 075 634 төгрөг үйл ажиллагааны орлогоос давж батлагдсан байна. Ерөнхий захирлын 2023 оны А/92 дугаар тушаалаар 368,4 сая төгрөгийг нийт ажилтны нийгмийн асуудлыг дэмжих, 6,6 сая төгрөгийг ахмад ажилтнууд дэмжлэг үзүүлэх, 5,4 сая төгрөгийг Монголын донорын холбоо ТББ-ын сайн дурын ажилтнуудын нийгмийн асуудлыг дэмжихэд тус тус зарцуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 42. | Ажлын гүйцэтгэл, ур чадварт суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ. | 132.0 Улсын төсөв | Мөнгөн урамшуулал олгох журам, Ур чадварын нэмэгдэл олгох журам, урамшуулал авсан ажилчдын хувь | 2022 онд Улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал болон ур чадварын нэмэгдлийг тооцон бүрэн олгосон. | 2023 онд ур чадварын нэмэгдлийг ажилтны 80-аас доошгүй хувьд олгосон байна. | 2023 онд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг 4 удаа, ур чадварын нэмэгдлийг 7 удаа тус тус тооцож нийт ажилтны 95 хувьд олгосон байна. | 100% |
| **Зорилт 3.1.2. Х**үний нөөцийг бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 43. | Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг ил тод хэрэгжүүлж, дасан зохицох хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. | - | Хүний нөөцийн хөдөлгөөний хувь | 2022 оны хүний нөөцийн хөдөлгөөн 14 хувьтай, сул ажлын байрыг нийтэд ил тод мэдээлж, нөхөн хангалт 90 хувьтай байсан. | Ажилтны тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, Сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн хэрэгжилт, ил тод байдлыг хангаж, хүний нөөцийн хөдөлгөөнийг жилд 15-аас доош хувьд тогтмол байлгана. | Сул ажлын байрыг нийтэд ил тод мэдээлж, сул ажлын байранд сонгон шалгаруулалт явуулах зарыг Зангиа.мн сайт, ЭМХТ-ийн HRDS систем, төвийн вэб сайт, пейж хуудсанд тус тус тухай бүр ил тод байршуулж ажилласан. 2023 оны хүний нөөцийн хөдөлгөөн **18 хувьтай**, нөхөн хангалт 93 хувьтай байна. | 100% |
| 44. | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх | | Үнэлгээний дүгнэлт, авсан арга хэмжээ | 2018, 2021, 2022 онд мэргэжлийн байгууллагаар хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн. | Хөдөлмөрийн нөхцөлийн болон зарим ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. | 2018 онд ХАБЭМ-ийн төвөөр 13 ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэсэн. Ажлын хэвийн нөхцлөөр үнэлэгдсэн. 2021 онд АШУҮИС-ийн Хөдөлмөр орчны эрүүл ахуйн лабораториор гэрэлтүүлэг, агаарын харьцангуй чийглэг, температур, шуугианы хэмжилтүүдийг нийт 24 байршилд хийлгэсэн. Дахин хийлгэх шаардлага гараагүй тул энэ онд хийлгээгүй. 2023 онд АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээр үйлдвэрийн тасгийн технологич сувилагч, Инженер техникийн тасгийн тоног төхөөрөмжийн инженерийн ажлын байранд эрсдлийн үнэлгээг хийлгэсэн.<br>Дээрх үнэлгээний хүрээнд ирсэн 21 зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Нэгдсэн лабораторийн тасагт өгсөн зөвлөмжийн дагуу ашиглаж буй химийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодисуудын “Хор аюулын лавлах мэдээлэл ХАЛМ-ийг боловсруулж лабораторид ажиллаж буй бүх ажиллагсдад танилцуулах сургалтыг зохион байгуулсан. | |
| 45 | Эрүүл мэндийн ажилтныг мэдлэг чадвараа дээшлүүлэх боломжоор хангана. | - | Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, мэргэжлийн зэрэг шинээр авсан, ахиулсан эмнэлгийн мэргэжилтний тоо | 2022 онд мэргэшил дээшлүүлсэн, мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 72.5% байна. | Мэргэшил дээшлүүлсэн, мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувийг 2026 он хүртэл 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ. | ЦССҮТ-ийн нийт эмч, сувилагч эмнэлгийн мэргэжилтний 93,2 хувь нь төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн бөгөөд, 67,7 хувь нь мэргэшлийн зэрэг хамгаалсан байгаагийн **9,6 хувь нь** 2023 ондоо шинээр мэргэшлийн ахлах зэрэг хамгаалсан бөгөөд ахлах зэрэг хамгаалсан ажилчдын 6,4 хувь нь эмч 3,2 хувь нь сувилагч мэргэжилтэй албан хаагчид байсан байна. 2024 онд 1 эмч мэргэшлийн ахлах зэрэг, 1 эмч зөвлөх зэрэг хамгаалахаар шалгалтад хамрагдаж байна.<br>Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны Сургалт төслийн ажилтан Э.Энхболор 24 багц цагийн “Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи төрөлжсөн мэргэшлийн сургалтанд суралцаж төгссөн. Донор зохион байгуулалтын тасгийн технологич сувилагч Э.Дашгарав АШУҮИС-ийн “Чих хамар хоолой” мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтад, Цусны чанар, аюулгүй байдлын албаны Халдвар судлаач, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ажилтан Э.Чагцалдулам Монголын тархвар, халдвар судлаач эмч нарын нийгэмлэгээс зохион байгуулсан 18 долоо хоногийн “Infection prevention and control” сургалтад, Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга А.Амарзаяа удирдлагын академи дээр зохион байгуулагдсан Эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг чадавхижуулах 2 сарын сургалтад, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны Мэдээллийн технологийн инженер Ч.Далайцэрэн, Б.Хишиг-Очир нар Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан 32 өдрийн IT админ сургалтад тус бүр хамрагдсан. Мөн Донор зохион байгуулалтын тасгийн технологич сувилагч Э.Анар ЭМХТ-ийн 2023 оны мэргэжил дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалтын намрын элсэлтээр “Цус, цусан бүтээгдэхүүний технологич” мэргэжил дээшлүүлэх сургалтад элсэн суралцаж байна. | 100% |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3.2. Цус сэлбэлт судлалын чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3.2.1. Г**адаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | |
| 46. | Цус сэлбэлт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын бүс нутгийн болон гадаад орны байгуулагата й хамтын ажиллагааг хөгжүүлнэ. | 0.4 Улсын төсөв | Байгууллагын гишүүнчлэл хамтын ажиллагаатай байгууллагын тоо | Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн (ISBT) 2022 оны гишүүнчлэлээ сунгасан. 2019 онд Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM)-той 4 жилийн хугацаатай санамж бичиг байгуулсан. | 2023 оны гишүүнчлэл сунгаж хамтран ажилласан байна. AATM-тай санамж бичигт заасан хамтын ажиллагаа хэрэгжсэн байна. | Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй 5 жилийн хамтын ажиллагааны гэрээг байгуулсан. Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэг /ISBT/-ийн гишүүнчлэлээ сунгаж “Affiliate Membership” гэрчилгээг 2023 оны 5 дугаар сард авсан.<br>Олон улсын Цус Сэлбэлтийн Нийгэмлэ г(ISBT )-ийн гишүүнчлэлийн эрхийг ажилтан бүрийн Төрийн цахим шуудан https://mail.gov.mn/ email хаягийг шинээр бүртгүүлж мэдээлэл солилцож байна. Цусны 26 салбар төвийн ажилчдын мэдээллийг шинэчлэн ISBT-ийн боловсролын портал дээрх материал, илтгэл, вебинар, цахим ном, олон улсын удирдамжыг үнэ төлбөргүй авч танилцах, үйл ажиллагаанд оролцох, хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлсэн.<br>Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM -)ноос жил бүр зохион байгуулдаг XVIII удаагийн их хурал болон Цус сэлбэлтийн анагаах ухааны салбарын тэргүүлэх судлаач, эрдэмтэн, мэргэжилтнүүдийн олон улсын хурал болох AATM-AABB-ийн 4 дэх удаагийн хурлаар 2023 оны Азийн цус сэлбэлтийн холбооны шилдэг байгууллагаар шалгарсан.<br>Азийн цус сэлбэлтийн холбоотой 2013 оноос хойш хамтран ажиллаж байгаа ба санамж бичгийг 2023 оны 3 сарын 14 өдрөөс хойш 2028 он хүртэл 2 тал харилцан тохиролцож хамтын гэрээг байгуулсан. Хамтын гэрээний заалтууд бүрэн хэрэгжсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | Эрүүл мэнд, боловсролын болон бусад төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх | | Хамтын ажиллагаатай байгууллага, хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 2022 онд 70 гаруй байгууллагатай гэрээ, санамж бичиг байгуулан ажилласан. | Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг үнэлсэн байна. | 2023 онд шинээр болон үргэлжлүүлэн 6 байгууллагтай байгуулсан хамтын ажиллагаа санамж бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Үүнд: МУЗН, ЗХЖШ, Ротару Монгол Байгууллага, Монголын Донорын Холбоо, JCI Монгол байгууллага, Сэтгэлийн 1000 үйлс. JCI МОНГОЛ байгууллага нь Цус өгөх үндэсний өдрийг тэмдэглэн өнгөрүүлж 1 сарын туршид салбар 15 байгууллагын хамт олон цусаа бэлэглэсэн. | 90% |
| **Зорилт 3.2.2.** Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлнэ. | | | | | | | |
| 48. | Эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулах | 10.5<br>Улсын төсөв | Зохион байгуулсан хурлын хөтөлбөр, илтгэлийн хураангуй | Цусны албаны эрдэм шинжилгээний онол, практикийн XYII бага хурлыг зохион байгуулсан. | Цус сэлбэлт судлалын салбарын онол, практикийн XIX бага хурлыг зохион байгуулагдаж, илтгэлийн хураангуй хэвлэгдсэн байна. | Монгол Улсын Цусны албаны 60 жилийн ойд зориулсан Олон Улсын Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Ерөнхий захирлын 2023.09.28-ний өдрийн А/62 тушаалаар батласан. Цус сэлбэлт судлалын салбарын олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Эмнэлзүйн цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, эмчилгээний үр дүн”, “Лабораторийн суурь судалгаа”, “Цусны албаны үндсэн үйл ажиллагаа” гэсэн үндсэн сэдвээр зохион байгуулсан. Ирүүлсэн илтгэлүүдээс 10 илтгэлийг сонгон аман хэлбэрээр, 5 ханын илтгэлийг тус тус сонгон шалгаруулж хэлэлцүүлсэн. ЦССҮТ-ийн Ерөнхий захирал АУ-ны доктор, профессор Н.Эрдэнэбаяр “Цусны албаны сургалт, эрдэм шинжилгээний ажлын өнгөрсөн ба одоо” сэдвээр, БНХАУ-ын Шанхайн цусны төвийн профессор Зу Зиан “Цусны ховор бүлэг” сэдвээр зочин илтгэл тавьсан. Зочин шүүгчээр АШУҮИС-ийн Био-Анагаахын сургуулийн Дархлаа судлалын тэнхимийн багш, АУ-ны доктор, дэд профессор Л.Энхсайхан, Молекул биологи, Удам Зүйн тэнхимийн багш, АУ-ны доктор, дэд профессор Ж.Жамбалдорж, Цус судлалын тэнхимийн багш АУ-ны доктор О.Пүрэвжал нар ажилласан. Эрдэм | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээний хурлын илтгэлийн хураангуйг хэвлүүлж судлаачдын хүртээл болгосон. | |
| 49. | Цус сэлбэлт судлалын чиглэлээр “Үндэсний семинар”-ыг зохион байгуулна. | 8.0 Улсын төсөв | Семинарын хөтөлбөр, удирдамж, тайлан | 2022 онд “Үндэсний семинар”-ыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. | Үндэсний семинарыг зохион байгуулж, цусны салбар төвүүд, холбогдох эмч, мэргэжилтнийг мэргэжил аргазүйгээр хангасан байна. | ДЭМБ-ын санхүүгийн болон техникийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Цусны албаны 60 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Цус сэлбэлт судлалын салбарын “Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь сэдэвт Үндэсний семинар”-ыг баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу 2023.04.27-28-ны өдрүүдэд зохион байгуулж Эрүүл мэндийн яам, төв болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, 21 аймгийн 26 Цусны салбар төв болон төвийн удирдлага, эмч мэргэжилтэн нийт 240 хүн хамрагдлаа. Семинарын эхний өдөр ЦССҮТ-ийн хурлын танхимд 21 аймгийн 26 Цусны салбар төвийн нийт 80 орчим эмч, мэргэжилтнүүдийг хамруулж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн, цусны салбар төвийн эрхлэгч эмч нар үр дүнгийн тайлан, сайн туршлага, ололт амжилтын талаар хэлэлцэн туршлага солилцлоо.<br>Семинарын хоёрдах өдөр Цус сэлбэлт судлалын нийт эмч, мэргэжилтнүүд болон Улсын болон хувийн хэвшлийн эмнэлэг, Цусны салбар төвүүд, нийт 160 эмч, мэргэжилтнүүдийг хамруулан Чингис хаан зочид буудлын Өргөө танхимд зохион байгуулав. Үндэсний семинарыг зохион байгуулснаар цус сэлбэлт судлалын чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлдэг улсын болон хувийн хэвшлийн нийт эмч нарын дунд цусны чанар, аюулгүй байдлын талаарх мэдлэг, ур чадвар нэмэгдэж, цус сэлбэлт судлалын салбарын талаар бодлогын чиг хандлагыг тодорхойлж үр дүнд хүрсэн семинар болсон. Мөн Цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч гэрээт Эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн тайланд хийсэн дүн шинжилгээ, анхаарах асуудлыг хэлэлцсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | АШУҮИС, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХСҮТ, ГССҮТ-ийн эмч нар уригдан оролцож эмнэлэг тус бүрийн цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ, сүүлийн үеийн судалгаа, үр дүнг танилцуулав. Цус сэлбэлт судлалын үндэсний семинарыг улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг хамруулан анх удаа зохион байгуулж байгаагаараа онцлог бөгөөд техникийн болон санхүүгийн тайланг ДЭМБ-д хүргүүлсэн. | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ 3.3. Цус сэлбэлт судлалын чиглэлээр сургалт зохион байгуулах, сургалт зохион байгуулах чадавхийг дээшлүүлэх | | | | | | | |
| **Зорилт 3.3.1.** Сургалт зохион байгуулж, эмч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулна. | | | | | | | |
| 50. | Богино хугацааны багц цагийн сургалт зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан эмч мэргэжилтний тоо | 2022 онд богино хугацааны багц цагийн сургалтыг 2 чиглэлээр нийт 7 удаа зохион байгуулж 192 эмч, мэргэжилтэн хамрагдсан | Богино хугацааны багц цагийн сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтэнг мэргэжил арга зүйгээр хангаж, чадавхжуулсан байна. | 2023 онд багц цагийн богино хугацааны сургалтыг үндсэн 2 сэдвээр 18 удаа зохион байгуулж нийт 1452 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | 100% |
| 51. | Нийт ажилчдын авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн болон бусад тасралтгүй сургалт зохион байгуулах | | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, 2022 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүл мэндийн яамны батлагдсан ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Эхний хагас жилийн тайланг 06 дугаар сарын 13-ны 267 дугаар албан бичгээр, бүтэн жилийн тайланг 12 сарын 01-нд хугацаанд нь хүргүүлсэн. Зохион байгуулсан сургалтын тоо 9, ажиллагсдын хамрагдалтын хувь 90% байна. | 100% |
| **Зорилт 3.3.2.** Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | | | | | | | |
| 52. | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал /их эмч/, Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи/ био анагаах судлаач/ чиглэлээр | 4.0 Суралцагч-дын төлбөр | Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тушаал, төгссөн эмч, мэргэжилтний тоо | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал чиглэлээр 9 их эмч, Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр 3 био- | Эмнэлзүйн цус сэлбэлт судлалаар , Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн сургалтыг | Эрүүл мэндийн сайдын А/533 тоот тушаалын дагуу 2022 оны намрын элсэлтээр элссэн төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтыг ЭМХТ-ийн захирлын А/14 тоот тушаалаар 03 сарын 31-ний өдөр төгсөлтийн шалгалт зохион байгуулж шалгалтын протоколыг ЭМХТ-д хүргэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулна. | | | анагаахын мэргэжилтэн, тус тус суралцаж төгссөн. | тус тус зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын А/216 тоот тушаалаар Эмнэл зүйн цус сэлбэлт судлалын их эмчийн төрөлжсөн мэргэшлээр 3 эмч, Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи мэргэжлээр 1 Био-анагаахын мэргэжилтэн элсэн суралцаж 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр төгсөлтийн шалгалтыг зохион байгуулж ЭМХТ-д шалгалтын протоколыг хүргэсэн. 2023 оны 11 сарын 08-нд ЭМС-ын А/394 тоот тушаал гарч 4 гэрчилгээг баталгаажуулахаар ЭМХТ-д хүргүүлсэн. | |
| 53. | Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн /сувилагч/ мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна. | 4.0 Суралцагч-дын төлбөр | Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тушаал, төгссөн сувилагчийн тоо | Цус, цусан бүтээгдэхүүний технологич чиглэлээр 3 сувилагч тус тус суралцаж төгссөн. | Цус, цусан бүтээгдэхүүний технологичийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан байна. | ЭМХТ-ийн захирлын мэргэжил дээшлүүлэх сургалтын А/09 дүгээр тушаалаар 2 сувилагч төгссөн.<br>Мэргэжил дээшлүүлэх сургалтад 2023 оны 05 дугаар сарын 26-ний өдрийн ЭМХТ-ийн захирлын А/43 тоот тушаалаар 5 сувилагч элсэн суралцаж, ЭМХТ захирлын А/76 төгсөлтийн тушаалаар 4 сувилагч төгссөн. | 100% |
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ:4. Байгууллагын хөгжил, ил тод байдлыг хангах | | | | | | | |
| **Зорилт 4.1.1** Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. | | | | | | | |
| 54. | Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллана. | - | Цусны донорын тухай хууль | Цусны донорын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, шат шатны хэлэлцүүлэг хийгдсэн. | Хуулийн төслийг өргөн барьсан байна. Батлагдсан хуулийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. | Цусны донорын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулан УИХ-ын Ажлын хэсэгт хүргүүлсэн. Засгийн газар, холбогдох яам, агентлагуудаас санал авч төсөлд тусгасан. D-Parliament.mn сайтад байршуулан олон нийтийн санал авч, 2022 оны 9 сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Засгийн газраас хуулийн төсөлд өгсөн санал, дүгнэлтийг нэгтгэн 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр УИХ-ын Ажлын хэсгийн хурал, Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд тус тус танилцуулсан байна. Холбогдох ажлуудыг бүрэн хийсэн. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсон “Цусны донорын тухай хуулийн төсөл”-ийг УИХ-ын бүрэн эрхийн дагуу бие даан санаачлан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулж, батлуулахаа УИХ-ын гишүүн уламжилсан болно. | |
| 55. | Төвийн бүтэц үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулна. | 1.0<br>Улсын төсөв | Шинэчлэн боловсруулсан стандартын төсөл | ЦССҮТ-ийн бүтэц, үйл ажиллагааны MNS 6674:2017 стандартыг мөрдөж байна. | | Ерөнхий захирлын 2023 оны А/77 дугаар тушаалаар ЦССҮТ-ийн бүтэц, үйл ажиллагааны MNS 6674:2017 стандарт шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ЦЧАБА-ны даргаар ахлуулсан 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажилласан. Ажлын хэсэг Үндэсний болон Олон улсын жишигт нийцүүлэн стандартыг шинэчлэх төслийг боловсруулж байна. | 2024 онд төлөвлөсөн |
| 56. | Цусны донорын тухай хуультай уялдуулан байгууллагын дүрэм, бүтцийг шинэчлэн батлуулна. | - | Төвийн шинэчлэн батлуулсан бүтэц, дүрэм | 2020 онд батлагдсан дүрэм, бүтцээр үйл ажиллагаа явуулж байна. | | Цусны донорын тухай хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, санал авах ажлуудыг бүрэн хийсэн. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсон “Цусны донорын тухай хуулийн төсөл”-ийг УИХ-ын бүрэн эрхийн дагуу бие даан санаачлан боловсруулж, батлуулахаа УИХ-ын гишүүн уламжилсан болно.<br><br>Цусны донорын тухай хууль батлагдахаар хуультай уялдуулан төвийн дүрэм, бүтцийг шинэчлэхээр төлөвлөж байна. | 2024 онд төлөвлөсөн |
| 57. | Үйл ажиллагаатай холбоотой журам зааврыудыг шинэчлэх | | Шинэчилсэн журам, заавар | 2022 оны байдлаар төвийн үйл ажиллагааг зохицуулж буй 58 журамд үнэлгээ хийсэн. | Төвийн үйл ажиллагааг зохицуулж буй бүх журмуудыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | Нэгдсэн менежментийн тогтолцоонд шилжих хүрээнд төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, стандарт үйл ажиллагааны зарим зааварт шинэчлэл хийсэн.<br><br>Байгууллагын хэмжээнд нийт<br><br>1. Үйл явцын тодорхойлолт зураглал-9<br>2. Журам-70<br>3. Стандарт ажиллагааны заавар-81<br>4. Тоног төхөөрөмжийн ажлын заавар - 39<br>5. Ажлын заавар-60<br>6. Маягт-180 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7. Хяналтын хуудас-36 тус тус мөрдөн хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 58. | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой дагалдаж гарах журмуудыг боловсруулж мөрдөх | - | Журмын хэрэгжилтийг хангаж авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөө, Сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, Цалин хөлсний журам, Шагнал, урамшлын журмыг боловсруулж баталсан. | Шинэчлэн батлагдсан Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөө, Сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, Цалин хөлсний журам, Шагнал, урамшлын журмыг хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Шинэчлэн батлагдсан Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөө, Сонгон шалгаруулалтын журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, Цалин хөлсний журам, Шагнал, урамшлын журмыг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Төвийн ажиллагсдад Ур чадварын нэмэгдэл олгох журмыг шинэчлэн баталсан.<br><br>Засгийн газрын 240 дүгээр тогтоолын дагуу 6 ажилтны цалингийн зэрэглэлийг шинэчлэн А01 тушаалаар баталгаажуулсан.<br><br>Төвийн хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэх санал авч 2024 онд шинэчлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 90% |
| 59. | Эрүүл мэндийн улсын албаны тушаал, шийдвэр, төлөвлөгөөтэй уялдуулан төвийн гамшгийн үеийн ажиллах журам, төлөвлөгөөг шинэчлэн, бэлэн байдлыг хангаж ажиллах | | Тодотгосон төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ЦССҮТ-ийн ажиллах журмыг 2021 оны А/17 тушаалаар шинэчлэн баталсан. ТҮТ-ны төлөвлөгөөнд 3 удаа тодотгол хийсэн. | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах тодотгосон төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. | ЦССҮТ-ийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Чанарын менежмент, эрсдэлийн удирдлагын багаар эрсдэлийн үнэлгээ хийлгэн тодотгол хийж БЗД-ийн Онцгой байдлын хэлтсээр шинэчлэн батлуулсан. ОБЕГ-ын даргын 2019 оны А/388 дугаар тушаалын дагуу БЗД-ийн Онцгой байдлын хэлтэс, ЧД-ийн Онцгой байдлын хэлтсээс чиглэл, мэдээлэл авч ажилласан. Тодотгосон төлөвлөгөө хэрэгжилт 100%. Төлөвлөгөөнд:<br>● Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч<br>● Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг<br>● Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн орон тооны бус бүлгийн тусгай үүрэг гүйцэтгэх бүлгүүдийн томилгоот бүрэлдэхүүний гүйцэтгэх чиг үүрэг<br>● Байгууллагын эрсдэлийн менежмент | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ● Байгууллагын гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах 2023 оны төлөвлөгөө<br>● Байгууллагын гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах 2023 оны төлөвлөгөө<br>● Аюулгүй цэгт цуглarах, нүүн шилжих арга хэмжээ<br>● Гамшгийн үед байгууллагын ажилтан, албан хаагч, эд хөрөнгийг түр байранд нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэх арга хэмжээ<br>● Гал түймрээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөө<br>● Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн хээрийн эмнэлгийн бүдүүвч<br>● Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги байгуулсан тушаал<br>● Холбоо зарлан мэдээллийн схем<br>● Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн судалгаа<br>● Төвийн ажиллагсдын авто тээврийн хэрэгслийн судалгаа<br>● Улаанбаатар хотод газар хөдлөлтийн үеийн цус цуглуулалтын төлөвлөгөө<br>● Ажлын зураг зэргийг шинэчлэн тусгаж албажуулсан. | |
| Зорилт 4.1.2. Мэдээ тайлан гаргах, нэгтгэх, дүн шинжилгээ хийнэ | | | | | | | |
| 60 | Статистик мэдээ тайланг хүлээн авч нэгтгэх, дүн шинжилгээ хийх тайлагнах | - | Үндсэн үйл ажиллагааны өдөр тутмын тоон мэдээ, сарын статистик үзүүлэлт, тайлан | Сар бүр статистик үзүүлэлт гаргаж дүн шинжилгээ хийж танилцуулдаг.<br>Өдөр тутам үндсэн үйл ажиллагааны тоон мэдээ гаргаж мэдээлдэг. | Тогтмол гардаг статистик үзүүлэлт, тоон мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж , эрх бүхий байгууллагад хугацаанд нь тайлагнасан байна. | Цусны салбар төвүүдээс батлагдсан маягтаар 2022 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж, ЭМХТ-д тайлангийн хугацаанд хүргүүлж, А үнэлгээ авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 61. | Шийдвэр гаргагчийг нотолгоонд суурилсан бодит мэдээллээр хангана. | - | Боловсруулсан мэдээлэл, тайлан | ЭМЯ, удирдлагыг шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, тайлангаар тогтмол ханган ажилладаг. | ЭМЯ, эрх бүхий байгууллага, удирдлагыг шийдвэр гаргахад нотолгоонд суурилсан бодит мэдээлэл тайлангаар тогтмол ханган ажилласан байна. | Цусны албаны сүүлийн 5 жилийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэн баяжуулж “Эрүүл мэндийн үзүүлэлт 2022” эмхэтгэлд 2022 оны онцлох үйл ажиллагааны хамт хэвлүүлсэн. Цусны албаны үндэсний семинарт тайлан мэдээ гаргалт, сайжруулах зөвлөгөөг танилцуулж мэргэжил арга зүйгээр хангасан. Цусны албаны үйл ажиллагааны статистик үзүүлэлтийн 2013-2022 оны дэлгэрэнгүй нэгтгэл гаргаж, мэдээний бүртгэлийн санг баяжуулсан. 2023 онд сарын бүрийн статистик мэдээг гарган, дүн шинжилгээ хийж, ажиллагсад болон удирдлагыг мэдээллээр тогтмол хангасан. Өдөр тутмын статистик тоон мэдээ гаргаж төвийн дотоод группэд байршуулж мэдээллийн шуурхай ил тод байдлыг хангаж, шийдвэр гаргах боломжоор бүрэн хангасан. Уламжлал болгон зохион байгуулдаг эрдэм шинжилгээний XX бага хуралд “ЦССҮТ-ийн цус цусан бүтээгдэхүүний зардлыг тооцсон дүн” Цусны албаны 2013-2022 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийг харьцуулсан судалгаа сэдвээр хамтарсан илтгэл хэлэлцүүлсэн. Нийтэд мэдээллийн ил тод байдлыг хангаж https://donor.mohs.mn/web/?p=6565 хаягт тортмол байршуулсан. | 100% |
| **Зорилт 4.1.3.** Төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг сайжруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 62. | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, мөрдөнө. | 4.0<br>Улсын төсөв | Шинэчлэн батлуулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг | 2019 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг анх боловсруулж хэрэгжүүлсэн. | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлсэн байна. | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэн боловсруулах санхүүжилтийг 2022 оны давсан орлогоос шийдвэрлэж, ХАА-ны төлөвлөгөөнд тусгаж хуулийн дагуу шийдвэрлэсэн. Хараат бус аудиторууд, нягтлан бодогч, захирлуудын холбоо ТББ-тай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 оны 06 сарын 21-ний өдрийн 23/10 тоот гэрээ байгуулан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн. | |
| 63. | Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангана. | - | Тайланд хийсэн дүн шинжилгээ | - | Санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангах, байгууллагын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажилласан байна. | 2023 онд Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан. | 90% |
| **Зорилт 4.1.4.** Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног, төхөөрөмжийн шалгалт тохируулга баталгаажилтыг тогтмол хийлгэнэ. | | | | | | | |
| 64. | Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийх | 38.0 Улсын төсөв | Шинэчилсэн тоног төхөөрөмжийн тоо | 2016-2019 онд Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж, тавилгын иж бүрэн шинэчлэл хийсэн. | Жил бүрийн төсөвт шаардлагатай эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн төсвийг тусган шийдвэрлүүлж, тоног төхөөрөмж ийн шинэчлэлийг үе шаттай хийсэн байна. | Ашиглалтын хугацаа дууссан, эвдрэл гэмтэлтэй эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийг жил бүр төсөвт тусгадаг болович шийдвэрлэгдэхгүй байна. | 30% |
| 65 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, хэвийн үйл үйл ажиллагааг хангаж, мэргэжлийн байгууллагаар шалгалт, тохируулга, баталгаажуулалт тогтмол хийлгэх | 38.0 Улсын төсөв | Шалгалт тохируулга, баталгаажуулалт , Засвар үйлчилгээ хийсэн удаа | 2022 онд тоног төхөөрөмжийн баталгаажуулалт 8, багаж хэрэгслийн шалгалт тохируулга 39 удаа хийлгэсэн. Эмнэлгийн тоног төхөөрөмжид 7 удаагийн төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийсэн. | Жил бүр эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ шалгалт тохируулга, баталгаажуулалтыг бүрэн хийж үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажилласан байна. | Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дугаартай ‘’ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийх’’ журмын дагуу төвийн хэмжээнд ашиглагдаж байгаа Электрон Жин-1, Температур, чийгшил хэмжигч-1, Автоклав монометр-1, Жингийн туухай-1, Механик, даралтын аппарат-5 Пепитик-9 Цусны жин-30 Аналитик жин-1 Биеийн өндөр жин хэмжигч нийт 53 ширхэг хэмжих хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар шалгалт тохируулга, баталгаажуулалт хийлгэсэн. Төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг сар болгон үзлэг, засвар үйлчилгээ хийж техникийн ашиглалтын паспортод тэмдэглэл хөтөлж хэвийн үйл ажиллагааг хангаж, төлөвлөгөөний биелэлт 100% хэрэгжсэн. | 100% |

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ДАРГА Ч.БАТБОЛД